

**МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭ,  
ҮЙЛДВЭРЛЭЛ (ТХҮ)-ИЙ ХЭРЭГЖИЛТ**  
БОДЛОГО, ХЭРЭГСЭЛ, АРГА БАРИЛЫН ТАЛААРХ  
МЭДЛЭГИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАНДЛАГЫГ  
САЙЖРУУЛАХ НЬ



## Талархал

Монгол улсын ТХҮ-ийн суурь судалгааны тайланг боловсруулах ажлыг Европын Комиссоос санхүүжүүлж буй СВИЧ Ази хөтөлбөрийн ТХҮ-ийн бүрэлдэхүүн хэсгээр дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлал (БОАЖЯ)-д үзүүлж буй техникийн туслалцааны дэмжлэгийн хүрээнд хэрэгжүүлэв.

Зохиогчид: Баяр Эрдэнэчимэг | Бёрн Бауэр

Хянан тохиолдуулсан: Араб Хобалла, Лорейн Гатлабаян, Сара Габай

Хамтран ажилласан:



БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Санхүүжүүлсэн:



Европын Комисс;

switchasia



СВИЧ Ази хөтөлбөр

© 2020 SWITCH-Asia

Энэхүү тайланд тусгасан үзэл бодол нь зөвхөн зохиогчдын үзэл бодол бөгөөд Европын Холбооны үзэл санаа, бодлогыг заавал илэрхийлэх албагүй.

## ТОВЧИЛСОН ҮГ

---

<b>АХБ</b>	Азийн хөгжлийн банк
<b>БОАЖЯ</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
<b>БХБЯ</b>	Барилга, хот төлөвлөлтийн яам
<b>ГХЯ</b>	Гадаад харилцааны яам
<b>ЕСБХБ</b>	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
<b>ЕХ</b>	Европын холбоо
<b>ЖДҮ</b>	Жижиг, дунд үйлдвэр
<b>МБХ</b>	Монголын банкны холбоо
<b>МТСХ</b>	Монголын тогтвортой санхүүгийн холбоо
<b>МУХАҮТ</b>	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
<b>МХЕГ</b>	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
<b>НҮБ</b>	Нэгдсэн Үндэсний Байгууллага
<b>НҮББОХ</b>	НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр
<b>НХБ</b>	Ногоон хөгжлийн бодлого
<b>ОБЕГ</b>	Онцгой байдлын ерөнхий газар
<b>ОУСК</b>	Олон улсын санхүүгийн корпораци
<b>ОҮИТБС</b>	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
<b>СЗХ</b>	Санхүүгийн зохицуулах хороо
<b>СХЗГ</b>	Стандарт, хэмжил зүйн газар
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТХА</b>	Тогтвортой худалдан авалт
<b>ТХЗ 12</b>	Тогтвортой хөгжлийн 12-р зорилго
<b>ТХЗ</b>	Тогтвортой хөгжлийн зорилго
<b>ТХҮ</b>	Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл
<b>ТХҮБ-2030</b>	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030
<b>УАНС</b>	Уур амьсгалын ногоон сан
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо
<b>ҮХГ</b>	Үндэсний хөгжлийн газар
<b>ХНХЯ</b>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
<b>ШУА</b>	Шинжлэх ухааны академи
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам
<b>PAGE</b>	НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл

# АГУУЛГА

---

<b>ТОВЧИЛСОН ҮГ</b> .....	<b>I</b>
<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>V</b>
<b>ХУРААНГУЙ</b> .....	<b>1</b>
<b>1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>2</b>
<b>2. СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	<b>7</b>
2.1. Цар хүрээ ба хязгаарлалт .....	7
2.2. Арга зүй.....	7
<b>3. ТХҮ-ТОЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН</b> .....	<b>8</b>
3.1. Салбар дундын суурь бодлогын баримт бичиг .....	8
3.1.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010-2030).....	8
3.1.2. Ногоон хөгжлийн бодлого (2014-2030).....	8
3.1.3. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030).....	11
3.1.4. Алсын хараа-2050 .....	12
3.1.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024).....	15
3.1.7. Орон нутгийн Ногоон хөгжлийн бодлого .....	15
3.2. ТХҮ-ийн хэрэгжилтийг дэмжих эрх зүйн зохицуулалтын хэрэгсэл .....	16
3.2.1. Байгалийн нөөцийн тогтвортой менежмент .....	16
3.2.2. Хог хаягдлын менежмент.....	17
3.2.3. Үйлдвэрлэлийн голлох кластерт хамаарах бодлого, хэрэгжилт .....	20
3.2.3.1. Хүнс, хөдөө аж ахуй .....	21
3.2.3.2. Боловсруулах үйлдвэр .....	22
3.2.3.3. Барилгын салбар .....	24
3.2.3.4. Тогтвортой аялал жуулчлал .....	26
3.2.3.5. Ногоон худалдаа .....	28
3.3. Тогтвортой худалдан авалт .....	30
3.4. Ногоон санхүүжилт .....	31
<b>4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗУРАГЛАЛ</b> .....	<b>34</b>
4.1. Гол оролцогч талууд .....	34
4.1.1. Шийдвэр гаргагчид .....	34
4.1.2. Холбогдох төрийн байгууллагууд .....	36
4.1.3. Хувийн хэвшлийн салбар.....	37
4.1.4. Сургалт, судалгааны байгууллагууд .....	37
4.1.5. Сонирхогч бүлэг .....	38
4.1.6. Хэрэглэгчид .....	39
4.2. Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхол .....	44
4.3. Оролцогч талуудын мэдлэг .....	46

4.4. Оролцогч талуудын зураглал.....	46
<b>5. ТХҮ-ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА.....</b>	<b>48</b>
5.1. Өөрчлөлтийн төлөөх стратеги .....	48
5.2. Мэдээлэл солилцоо: Цахим технологийн боломж.....	49
5.3. Мэдээлэл-сурталчилгааны хэрэгцээт сэдэв.....	51
<b>5.4. Худалдан авалт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах .....</b>	<b>53</b>
5.5. Мэдээллийн бүтээгдэхүүн .....	53
5.6. Мэдээллийн суваг .....	55
5.7. Институчлал.....	57
5.8. Хамтын ажиллагаа ба оролцоо .....	57
<b>6. ОЛОН УЛСЫН ТХҮ-ИЙН САЙН ТУРШЛАГА.....</b>	<b>59</b>
6.1. Ногоон үйлдвэрлэл.....	59
6.1.1. Эко-инновац.....	59
6.1.2. Есо-шошго .....	62
6.1.3. Тогтвортой байдлын тайлагнал .....	65
6.2. Тогтвортой худалдан авалт .....	66
6.3. Тогтвортой аялал жуулчлал .....	75
6.3.1. Нэгдсэн стратеги .....	77
6.3.2. Оролцогч талуудыг идэвхижүүлэх .....	80
6.4. Мэдээлэл, сурталчилгаа.....	84
6.4.1. Боловсрол .....	84
6.4.2. Хамтын ажиллагаа .....	89
6.4.3. Кампанит ажил .....	90
<b>АШИГЛАСАН БҮТЭЭЛ.....</b>	<b>94</b>
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>95</b>
Хавсралт 1: Уулзаж ярилцсан оролцогч талуудын төлөөлөл .....	95
Хавсралт 2: Оролцогч талуудыг төлөөлөл .....	96
Хавсралт 3: Бодлогын баримт бичгийн жагсаалт.....	99

## ЗУРАГ

---

Зураг 1: Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлогын он дараалал .....	12
Зураг 2: Улсын хэмжээнд хог хаягдлын ялгарлын хэмжээ .....	17
Зураг 3: Монгол улсын үйлдвэрлэлийн салбар .....	21
Зураг 4: Хэрэглэгчдийн худалдан авалт .....	40
Зураг 5: 2019 оны төсвийн зардал ДНБ-т эзлэх хувь (төлөвлөснөөр).....	41
Зураг 6: “Төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликейшн болон “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем” .....	41
Зураг 7: Шилэн дансны нэгдсэн цахим хуудас .....	43
Зураг 8: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, 2019 он .....	43
Зураг 9: Оролцогч талуудын зураглал, хоорондын холбоо.....	47
Зураг 10: ТХҮ-ийн зорилтот бүлэг .....	48
Зураг 11: Алхам алхамаар хэрэгжүүлэх ТХА-ын аргачлал .....	68
Зураг 12: ТХА-ын хяналтын системийг бий болгох үндсэн алхамууд.....	69

## ХҮСНЭГТ

---

Хүснэгт 1: СВИЧ Ази хөтөлбөрийн хүрээнд Монгол хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл .....	5
Хүснэгт 2: НХБ-н шалгуур үзүүлэлтүүд .....	9
Хүснэгт 3: Алсын хараа-2050 бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт .....	9
Хүснэгт 4: НХБ-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ.....	35
Хүснэгт 5: Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхол .....	44
Хүснэгт 6: Яамд, агентлагийн вэб сайт, цахим мэдээллийн сан.....	49
Хүснэгт 7: Мэдээлэл-сурталчилгаанд тусгах ТХЗ 12-ийн үндсэн ба дэд сэдэв .....	51
Хүснэгт 8: Мэдээллийн бүтээгдэхүүний давуу болон сул тал.....	53
Хүснэгт 9: Оролцогч талуудын мэдээлэл авах сонирхолтой суваг.....	55
Хүснэгт 10: Мэдээлэл-сурталчилгааны стратеги.....	56
Хүснэгт 11: ТХҮ-ийн бодлогын хэрэгсэл ба аялал жуулчлалын амьдралын мөчлөг .....	79
Хүснэгт 12: Тогтвортой аялал жуулчлалын оролцогч талууд .....	80



Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдэд тогтвортой хөгжлийг хангахад цэвэр технологи нэвтрүүлэх, хаягдал багатай тогтвортой үйлдвэрлэлийг бий болгох, иргэдийн оролцоог ханган байгальд ээлтэй хандлага, дадлыг төлөвшүүлэх замаар ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан эдийн засгийн ногоон өсөлтийг бий болгох чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн билээ. Ногоон хөгжлийн бодлогын стратегийн 1-р зорилтод “Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх”-ээр онцгойлон тодорхойлсон юм.

Монгол Улсын Засгийн газраас тогтвортой бөгөөд ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх, ногоон санхүүжилт, татвар, зээл, урамшууллын тогтолцоог дэмжих, оновчтой хөшүүргийг нэвтрүүлэх чиглэлээр анхаарал тавин, тодорхой ажлуудыг хийгээд байна. Гэвч байгалийн нөөцийн эрчимтэй олборлолт, хотжилт зэргээс шалтгаалсан томоохон өөрчлөлтийн үйл явц, эдгээрээс үүдсэн сорилууд өнөөдөр үргэлжилсэн хэвээр байна.

2007 онд Европын Холбооны СВИЧ Ази хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монгол улс уг хөтөлбөртэй хамтран ажилласан бөгөөд Монгол улс тус хөтөлбөрийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох Буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгтэйгээр анхны төслүүдээ санаачлан, хэрэгжүүлж эхэлсэн юм. СВИЧ Ази хөтөлбөрийн Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл (ТХҮ)-ийн бүрэлдэхүүн хэсгийн дэмжлэгтэйгээр Монгол улсын Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл (ТХҮ)-ийн суурь судалгаа хийгдлээ. Суурь судалгаанд Монгол улсын ТХҮ-тай холбоотой бодлого, хууль эрх зүй, зохицуулалтын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийснээс гадна холбогдох талуудын зураглал, түүнчлэн олон улсын туршлагаас оруулжээ. Монгол улс бие даасан ТХҮ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, замын зураглалаа одоогоор гаргаагүй байна. Иймээс замын зураглалыг боловсруулах, ялангуяа холбогдох талууд болон олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулахад энэхүү суурь судалгаа үндэс болно.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны зүгээс СВИЧ Ази хөтөлбөрийн Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл (ТХҮ)-ийн бүрэлдэхүүн хэсгийн хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

**Цэрэндоржийн Уранчимэг**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам

Свич ази ТХҮ-ийн хөтөлбөрийн үндэсний зохицуулагч





Европын Холбооны улс орнууд эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй эргэлтийн эдийн засагт шилжих шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг. 2008 онд Европын Комиссоос Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл ба Тогтвортой аж үйлдвэрийн бодлого (ТХҮ/ТАҮБ)-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, бага зардлаар баялгийг бүтээх нийтлэг зорилгын хүрээнд тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний чиглэлээр нилээн хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, үйлдвэрлэл, хэрэглээний хэв маягийг өөрчлөх нь дэлхийн нийтээр тогтвортой хөгжлийг хангахад зайлшгүй шаардлагатай гэдгийг бататгасан юм.

Европын Холбооноос Монгол улсад "Засаглалыг бэхжүүлэх", "Ажил эрхлэх боломжийг дэмжих", "Хүний эрх", "Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчин"-ы чиглэлээр хөгжлийн хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. "Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчин"-ы чиглэлээр хог хаягдлын менежмент, агаарын бохирдол, сүлжмэлийн салбарын эко-шошго, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр дэмжих үйл ажиллагаа явуулдаг.

Европын холбооны санхүүжилттэй СВИЧ Ази хөтөлбөр нь Азийн орнуудын эдийн засгийн өсөлтийг нь дэмжин, байгаль орчны доройтлыг бууруулахын сацуу ногоон эдийн засгийн хөгжил болон нүүрстөрөгчийн ялгарал багатай, нөөцийн хэмнэлттэй, эргэлтийн эдийн засагт шилжих шилжилтийг дэмжих зорилготой.

Европын холбооны техник туслалцааны нэг хэсэг болох 2019-2021 онд хэрэгжих СВИЧ Ази хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэмжлэгтэйгээр хийгдсэн "Монгол улсын Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалт, институт болон хэрэгжилтийн суурь судалгаа"-г та бүхэнд танилцуулах завшаан тохиож байгаад би баяртай байна.

Энэ нь Монгол улсын тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлтэй холбоотой бодлого, зохицуулалт, түүнчлэн институцийн хүрээний талаархи цогц шинжилгээ хийж, зураглал хийсэн судалгаа болно. Толилуулж буй тайлан мэдлэг ойлголтоо дээшлүүлэх, тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн чиглэлээр олон улсын тэргүүн туршлагаас суралцах, нэвтрүүлэх сонирхолтой оролцогч болон холбогдох талуудад хэрэгтэй эх сурвалж болно гэдэгт би найдаж байна.

**Траян Христееа**

Европын Холбооноос Монгол Улсад суух элчин сайд,

Төлөөлөгчийн газрын тэргүүн



## ХУРААНГУЙ

---

Европын Холбооны СВИЧ Ази хөтөлбөрийн Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэг 2019-2021 онд Монгол Улсын Засгийн газрыг дэмжин ажиллана.

Монгол улс тогтвортой хөгжлөөр замнах бодлогоо боловсруулж, хэрэгжүүлж ирсэн удаан хугацааны түүхтэй бөгөөд Үндсэн хуулиндаа ч тусгасан байдаг юм. Тогтвортой хөгжилд хүрэх гол арга замын нэг бол тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлд шилжих шилжилт бөгөөд Засгийн газар тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл (ТХҮ)-ийн бүтцийг бүрдүүлэх хариуцлагыг хүлээсэн байдаг. 2019 оны 10 сараас 2020 оны 3 сар хүртэл, зургаан сарын хугацаанд хийсэн Монгол улсад ТХҮ-ийн бүтцийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалт, хэрэгжилтийн суурь судалгааны үр дүнг энэхүү тайланд танилцуулж байна. Судалгаанд олон тооны бодлого зохицуулалтын баримт бичиг, тайлан, 50 гаруй ярилцлага, 2020 оны 1 сард зохион байгуулагдсан ТХҮ-ий оролцогч талуудын техникийн уулзалт-зөвлөгөөний үр дүн зэргийг ашиглав.

Энэхүү судалгаанд ТХҮ-д холбогдох одоо хэрэгжиж буй бодлого, зохицуулалтын баримт бичгүүдийг нэгтгэн танилцуулж байна. 2014 онд батлагдсан Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого (НХБ) болон 2016 онд батлагдсан Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 (ТХҮБ 2030)-д ТХҮ-ийн ач холбогдлыг онцлон заасан бөгөөд Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд ТХҮ-ийг нутагшуулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тусгагдсан. Судалгааны тайлангийн эхний хувилбар гарсны дараа буюу 2020 оны 5 сард Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, 8 сард “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсан бөгөөд эдгээрийг бодлогын баримт бичгийг энэхүү тайланд нэмж оруулав.

Хоёрдугаарт холбогдох институцийн одоогийн тогтолцооны дүр зургийг гаргав. ТХҮ нь салбар дамжсан, төвөгтэй шинжтэй байдаг тул олон түвшний үндэсний болон орон нутгийн янз бүрийн чиглэл, салбарын байгууллагууд бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих зэрэг ТХҮ-ийн янз бүрийн шатанд оролцдог. Монгол улсад ТХҮ-ийг нутагшуулахад гол оролцогч талууд ихээхэн сонирхож, ач холбогдол өгч байгааг суурь судалгаанд хамрагдсан оролцогч талуудын зураглал харуулж байна.

Судалгаанд тухайлбал хог хаягдлын менежмент, бизнесийн голлох салбаруудын байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн зарим зохицуулалтын арга хэрэгслүүдийг нэгтгэв. Тогтвортой худалдан авалт нь шинэ ойлголт бөгөөд одооноос л худалдан авах ажиллагааны талаарх хууль тогтоомжид тусгах ажил хийгдэж, зарим ногоон санхүүжилтийн механизмыг бий болж эхэлж байна.

Оролцогч талуудыг ойлголт, мэдлэг, чадавхитай болгох нь ТХҮ-ийг хэрэгжүүлэх үндсэн зорилтын салшгүй хэсэг байдаг тул судалгаанд оролцогч талуудын мэдлэг, хандлага, дадлыг сайжруулах мэдээлэл-сурталчилгааны стратегийг тодорхойлж, энэхүү тайланд танилцуулж байна. ТХҮ-ийн чиглэлээр олон улсын сайн туршлагаас суралцах боломжийг олгох үүднээс суурь судалгааны тайлангийн сүүлчийн бүлэгт аль болох бүс нутгийн болон хөгжлийн хувьд ойролцоо улс орнуудын хуримтлуулсан туршлага, үр дүнтэй стратегийг оруулав.

Монгол улс ТХҮ-г үндэсний бодлого, хөгжлийн хөтөлбөртөө тусгаж, илүү тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлд шилжихэд бэлэн болжээ. Үндэсний, орон нутгийн, засаглалын түвшинд олон талын оролцогч талууд ч ТХҮ-г нутагшуулахад Монголын засгийн газрын амбицтай зорилгыг дэмжин, дараагийн арван жилд гар бие оролцоход бэлэн байна гэж дүгнэж байна.

# 1. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Европын Комиссоос тус комиссын гадаадад үзүүлэх тусламж, дэмжлэгийг хэрэгжүүлдэг Олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн ерөнхий газар (DG DEVCO)-аар дамжуулан, СВИЧ Ази хөтөлбөрийг 2007 онд эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг дэмжсэн тогтвортой тогтолцоонд шилжих, байгальд ээлтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар Ази тивд ядуурлыг бууруулахад засгийн газрууд, бизнес эрхлэгчид, хэрэглэгчид, дэмжигч мэргэжлийн холбоодыг дэмжих буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Тогтвортой хөгжилд хүрэх хүчин зүйлсийн нэг бол яалт ч үгүй “Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл” (ТХҮ)-д шилжих явдал юм<sup>1</sup>.

1992 онд Риогийн дэлхийн дээд хэмжээний уулзалтын үеэр анх ТХҮ-ий асуудал хөндөгдөж байсан бол, 2012 онд Рио+20 хэмээн нэрлэгддэг НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг анх баталсан дэлхийн дээд хэмжээний уулзалтаар үүний хэрэгцээ бүр тодорхой болсон юм. ТХҮ нь эрчим хүч, ус зэрэг байгалийн нөөцийг хэмнэж ашиглах, хог хаягдал бага гаргаж орчны бохирдуулалтыг багасгахын сацуу хүний бүх хэрэгцээг хангахыг илтгэдэг. Энэ нь ядуурлыг бууруулах, хүлэмжийн хийн ялгарлыг эрс бууруулсан ногоон эдийн засагт шилжихэд түлхүүр ач холбогдолтой ба хүрээлэн буй орчин, байгалийн нөөцөөс голлон хамааралтай дэлхийн хамгийн ядуучуудын амьдралыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэх юм. ТХҮ нь ядуурлыг бууруулах стратегийг хэрэгжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэхийн сацуу ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх арга зам болно. Ялангуяа энэ бүс нутагт шаардлагатай дэд бүтцийг үргэлжүүлэн бүтээн байгуулахад ТХҮ асар их боломжийг бий болгоно.<sup>2</sup>

## ТХЗ 12: Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл<sup>3</sup>

- 12.1 Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн 10 жилийн суурь хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хөгжиж байгаа орнуудын хөгжлийн түвшин, чадавхийг харгалзах
- 12.2 2030 он гэхэд байгалийн нөөцийн тогтвортой менежмент, үр ашигтай ашиглалтыг нэвтрүүлэх
- 12.3 2030 он гэхэд нэг хүнд ноогдох дэлхийн хүнсний хаягдлыг бөөний болон хэрэглэгчийн түвшинд тэн хагасаар бууруулах, үйлдвэрлэл болон хангамжийн сүлжээний хүнсний алдагдал, үүнд ургац хураалтын дараах алдагдлыг бууруулах.
- 12.4 2020 он гэхэд химийн бодис болон хаягдлыг амьдралын мөчлөгийн хугацаанд нь байгаль орчинд ээлтэй менежментээр хангах, агаар, ус, хөрсөн дэх хаягдлыг эрс багасгах.
- 12.5 2030 он гэхэд хог хаягдлаас сэргийлэх, дахин боловсруулах болон дахин ашиглах замаар хог хаягдлын хэмжээг эрс багасгах
- 12.6 Хувийн хэмшил, ялангуяа томоохон, үндэстэн дамнасан компаниудыг тогтвортой арга ажиллагаа нэвтрүүлэх, тайландаа нөөцийн тогтвортой байдлын мэдээллийг тусгадаг байхыг дэмжих.



<sup>1</sup> ТХҮ-г “байгалийн нөөцийн ашиглалт болон хортой материалын хэрэглээг аль болох багасгасан, түүнчлэн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн туршид хаягдал, бохирдуулагчийн ялгаралтыг багасгахад чиглэсэн байхын сацуу ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээ, боломжийг алдагдуулахгүйгээр өнөөгийн хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлж, хэрэгцээг хангасан үйлчилгээ, бүтээгдэхүүний хэрэглээ” гэж ойлгоно. UNEP: What is SCP: <http://web.unep.org/10yfp/about/what-scp>

<sup>2</sup> UNEP: Sustainable Consumption and Production - A Handbook for Policymakers 2015

<sup>3</sup> Тогтвортой хөгжлийн 12-р зорилго (ТХЗ 12)-ын зорилтуудыг товчлон оруулав.

- 12.7 Үндэсний бодлого, тэргүүлэх чиглэлтэй нийцүүлэн төрийн тогтвортой худалдан авах ажиллагааг хөгжүүлэх
- 12.8 2030 он гэхэд хүн бүр тогтвортой хөгжил, байгаль орчинтой зохицсон амьдралын хэв маягийн талаар мэдээлэл авдаг байх нөхцөлийг хангах
- 12.a Хөгжиж байгаа орнуудыг илүү тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлд шилжихэд нь шинжлэх ухаан, технологийн чадавхиа бэхжүүлэхэд нь дэмжих
- 12.b Орон нутагт ажлын байр бий болгож, соёл болон бүтээгдэхүүнийг нь дэмждэг тогтвортой аялал жуулчлалын тогтвортой хөгжилд үзүүлж буй нөлөөллийн хяналт-шинжилгээний арга хэрэгслийг боловсруулж, нэвтрүүлэх
- 12.c Зах зээлийн гажуудлыг арилгах замаар үрэлгэн хэрэглээг дэмждэг шатах түлшний үр ашиггүй татаасыг оновчтой болгох

ТХҮ нь НҮБ-ын баталсан даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-д чухал үүрэгтэй хэсэг нь болно. Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэлийн тухай Тогтвортой хөгжлийн 12 дугаар зорилго (цаашид ТХЗ 12 гэх)-ийг бусад зорилгуудтай хамгийн нягт уялдаатай бөгөөд үүнийг ялангуяа бусад 14 зорилготой хослуулан, уялдаатай хэрэгжүүлэхийг зөвлөдөг.<sup>4</sup> Иймээс тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн бүтцийг бий болгон нутагшуулах нь даян дэлхийн тогтвортой хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол түлхүүр болно.

ТХҮ нь янз бүрийн салбарыг дамнан хамардаг тул цогц арга барил, олон чиглэлийн оролцогч талуудын оролцоог шаардагдана. ТХҮ-ийн амжилттай хэрэгжихүйц бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянаж үнэлэхэд засгийн газрын, салбар хоорондын болон мөн бүхий л түвшинд хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Энэ нь зөвхөн үйлдвэрлэлийг сайжруулаад зогсохгүй хэрэглэгчдийг тогтвортой хэрэглээний сонголт хийдэг байх соёлд шилжихэд нь дэмжсэн бодлого хэрэгжүүлэлтийг шаарддаг. Тиймээс энэхүү шилжилтэд засгийн газар, боловсрол, хувийн хэвшил, хэрэглэгчид гээд нийгмийн бүхий л салбар, иргэн бүрт оролцох ёстой болдог.<sup>5</sup>

Европын Холбоо (ЕХ)-ны дэмжлэгтэйгээр СВИЧ Ази хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн цагаасаа хойш буцалтгүй тусламжийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Азийн хөгжиж буй 19 оронд эко шошгожуулалт, тогтвортой худалдан авалт, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүч, эко-аялал жуулчлал, тогтвортой үйлдвэрлэл, хүнс, нэхмэл-оёдлын үйлдвэрлэлээс авахуулаад ногоон барилга, хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн ашиглалтын болон бусад янз бүрийн салбарт 100 гаруй буцалтгүй тусламжийн төсөл хэрэгжүүлж ирсэн. Мөн тус хөтөлбөрийн Бүс нутгийн бодлогын нөлөөллийн бүрэлдэхүүн хэсэг (БНБН)-ийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн (НҮББОХ)-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд БНБН-ийн хүрээнд нилээн хэдэн улс орнууд, тухайлбал Малайз, Шри Ланка, Филиппин, Тайланд, Индонези улсын үндэсний түвшинд болон бүс нутгийн түвшинд ТХҮ-тэй холбоотой зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үр дүнтэй бодлогын хэрэгслийг бий болгож, бүс нутгийн хүрээнд мэдлэг, чадавхийг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг.

2018 онд эхэлсэн СВИЧ Ази хөтөлбөрийн 2 дугаар үе шатад хөтөлбөрийг өргөжүүлэн Төв Азийн Казакстан, Киргизстан, Тажикистан, Түркменистан болон Узбекистаныг оролцуулан хэрэгжүүлэхээр болов. 2020 оны байдлаар ЕХ-ны санхүүжүүлж буй буцалтгүй тусламжийн 130 гаруй төсөл хэрэгжиж байна.

<sup>4</sup> Le Blanc, D. (2015) Towards integration at last? The sustainable development goals as a network of targets. DESA Working Paper No. 141. ST/ESA/2015/DWP/141.

<sup>5</sup> UNEP: Sustainable Consumption and Production - A Handbook for Policymakers 2015

Хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийн төслүүдийг хэрэгжүүлэх болон сүлжээг бий болгох замаар дараах зорилгод хүрэхийг зорьж байна. Үүнд:

- Бизнес эрхлэгчид байгаль орчинд ээлтэй технологи, арга туршлагыг илүү ашигладаг болох,
- Хэрэглэгчдийн хандлагад эерэг өөрчлөлт гарснаар хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлтой болох,
- Үндэсний болон бүс нутгийн түвшинд ТХҮ-ийн талаар хамтарсан бодлогын яриа хэлэлцээ хийх, ТХҮ-ийг сурталчлах нэгдсэн платформтой болох,
- ТХҮ-ийн тэргүүлэх чиглэл, хэрэгцээний талаар үндэсний болон бүс нутгийн түвшинд туршлага хуваалцах, суралцах замаар идэвхтэйгээр яриа хэлэлцээрийг санаачлан өрнүүлэх болон
- ТХҮ-г хангаснаар эдийн засгийн үр дүнтэй арга хэлбэр, хэрэгслийг боловсруулах.

2017 онд Бангконг хотноо төвтөй СВИЧ Ази 2-р хөтөлбөрийн “Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн хэсэг” (товчоор ТХҮ-ийн бүрэлдэхүүн хэсэг)-ийг эхлүүлсэн бөгөөд уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд мэдлэгийг үр нөлөөтэй түгээх, амжилттай хэрэгжиж буй төсөл, туршлагыг олон нийтэд түгээн сурталчлах, Ази болон Европын холбогдох талуудын хамтын ажиллагаа, сүлжээг бий болгох, ТХҮ-ийн сайн туршлагыг дэлгэрүүлэх, хэвлэн нийтлэх ажлууд хийгдэнэ. Энэ хүрээнд дараах үр дүнд хүрэх зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд:

- ТХҮ-ий бодлогыг боловсруулахад бодлогын зөвлөгөө өгч, дэмжих,
- Сурталчилгаа, олон нийтэд нөлөөлөх замаар бүх оролцогч талуудын мэдлэгийг дээшлүүлэх,
- ТХҮ-ийн хэв маягийг дэлгэрүүлэхийн тулд сайн туршлагыг сурталчлах,
- Төрийн албан хаагчид болон бусад гол оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх,
- Орон нутаг, бүс нутагт ТХҮ-ийн тэргүүлэх чиглэлээр яриа хэлэлцээг өрнүүлэх, болон
- ЖДҮ-ийг цэвэр технологи, арга туршлагыг нэвтрүүлэхэд идэвхжүүлэх.

Монголд ТХҮ-ийн бодлогыг хэрэгжүүлэх, нутагшуулах зорилгоор БОАЖЯ-аас гаргасан хүсэлтийн дагуу ТХҮ-ийн бүрэлдэхүүн хэсэг ТХҮ-ийн бодлого боловсруулж, шийдвэр гаргах түвшний бодлого боловсруулагчдыг чадавхижуулахад нь дэмжих, ЖДҮ болон бичил ЖДҮ эрхлэгчдийг эко инновацийг нэвтрүүлэх, ашиглахад нь чадавхийг нь бэхжүүлэхэд чиглэсэн багц ажлыг хоёр жил хагасын хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хэдийгээр бүхэлдэхүүн хэсэг макро түвшинд илүү ач холбогдол өгч байгаа ч төслийн “ТХҮ-ийн чиглэлээр үндэсний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд нь нэгдсэн, зохицуулалттай арга барилыг дэмжих” үндсэн зорилгын хүрээнд мезо болон микро түвшинд тодорхой дэмжлэг үзүүлэн ажиллана. Иймээс дараах 3 чиглэлээр бүрэлдэхүүн хэсэг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ:

- БХ 1: ТХҮ-ийн үндэсний бодлого, хөтөлбөрийг сайжруулахад дэмжих,
- БХ 2: Тогтвортой худалдан авалтыг дэмжих, болон
- БХ 3: Сонгосон зарим боловсруулах үйлдвэрийн салбарыг “ногооруулах”-ыг дэмжих.

УИХ-с 2014 онд баталсан Ногоон хөгжлийн бодлого (НХБ)-д<sup>6</sup> “Хэдийгээр Монгол улсад Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн үндэсний дагнасан төлөвлөгөө байхгүй ч гэсэн НХБ ба түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тогтвортой хэрэглээ ба

<sup>6</sup> Ногоон хөгжлийн бодлого, УИХ-ын 2014 оны 43 дугаар тоот тогтоолын хавсралт.

үйлдвэрлэлийн хөтөлбөрүүдийн 10 жилийн хугацааг хамарсан тогтолцоонд тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн хэв маягийг голлох байр суурьтай болгох тодорхой алхмууд тусгагдаж, холбогдох мониторинг хийх үзүүлэлтүүдийг санал болгосон нь ТХЗ-12.1-тэй нийцэж байна”<sup>7</sup> гэжээ. НХБ-ын стратегийн зорилт 1-д “Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ” гэж заасан бол стратегийн зорилт 5-д “Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно” гэж тодорхойлсон юм.

2009 оноос хойш СВИЧ Ази хөтөлбөрөөс Монгол улсад ТХУ-г нутагшуулахад нь дэмжих зорилгоор хүнс, нэхмэл, арьс шир, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр нилээн хэдэн төслийг санхүүжүүлж ирлээ (Хүснэгт 1-г харна уу, дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.switch-asia.eu/countries/southeast-asia/mongolia/-c> авна уу).

### Хүснэгт 1: СВИЧ Ази хөтөлбөрийн хүрээнд Монгол хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл

ТӨСӨЛ	САЛБАР	ТХУ-ИЙН АРГА АЖИЛЛАГАА	Хугацаа А	Хэрэгжүүлэгч
1 Ногоон бүтээгдэхүүн ба шошгожуулалт (дууссан)	Хүнс ба ундаа, Нэхмэл, арьс ширний үйлдвэрлэл	Эко-шошго, Тогтвортой байдлын бүтээгдэхүүний загвар	2009/9 - 2012/4	Амтердамын Их сургууль (IVAM, Голланд), Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МУХАҮТ), Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ), Тохиромжтой технологийн төв (GrAT, Австри)
2 Ногоон барилгын төсөл (дууссан)	Барилгын материал үйлдвэрлэл	Ногоон үйлдвэрлэл, Тогтвортой байдлын бүтээгдэхүүний загвар	2012/1 - 2015/12	Каритас Чес, МУХАҮТ, Шведийн Байгаль орчны судалгааны хүрээлэн (IVL), Каритас Монгол ТББ
3 Барилгын материал дахин боловсруулалт (хэрэгжиж байгаа)	Барилгын материал үйлдвэрлэл	Хог хаягдлын менежмент	2016/3 - 2020/7	Каритас Чех, Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо (МХХДБҮХ), ШУТИС, Барилга архитектурын сургууль, Делфтийн Технологийн их сургууль (Голланд)
4 Хонины ноосон барилгын материал (SWBM) (дууссан)	Барилгын материал үйлдвэрлэл	Тогтвортой байдлын бүтээгдэхүүний загвар and тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ	2013/1 - 2016/5	Пипл Ин Нийд ТББ (PIN, Чех), Монголын Байгаль Орчны Консорциум (МБОК), Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо (МХААХҮХ), SEVEP Эрчим хүчний үр ашгийн төв (Чех)
5 Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг (STeP EcoLab) (хэрэгжиж байгаа)	Нэхмэл, арьс ширний үйлдвэрлэл	Эко-шошго	2017/12 - 2021/12	Хил хязгааргүй Малын Эмч нар ба Агрономчид ТББ (Франц), ТоС Холбоо (МБХ), Монголын ноос, ноолуурын холбоо (МННХО, ШУТИС, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо (МБАНХ), Байгаль орчин аюулгүй байдлын төв (БОАБТ), Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн нэгдсэн төв (Герман)
6 Дулаан шийдэл төсөл (SWITCH Off Air Pollution) (хэрэгжиж байгаа)	Эрчим хүч, барилга	Гэр хороололд дулааны алдагдал багатай байшин барихад дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх	2018 - 2021	Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм (GERES, Франц) тэргүүлэн Пипл Ин Нийд ТББ (PIN, Чех), ШУТИС, Барилга архитектурын сургууль, Барилгын эрчим хүчний хэмнэлтийн сургалт, судалгааны төв, Гэр хорооллын зураглал төв,

<sup>7</sup> Мөн “Монгол улсын Тогтвортой хөгжлийн төлөв, тайлан”-ийн 50-р талд харна уу.

				Монголын үндэсний барилгын ассоциацитай хамтран	
7	УБ хотын байгалийн нөөцийг тогтвортой ашиглах ЗР <i>(эхэлнэ)</i>	Тогтвортой хог хаягдлын менежмент	Ухаалаг хэрэглээний төлөвлөгөө, Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилах үйлдвэрийг сэргээх	2020-2023	Судалгааны үндэсний зөвлөл (Итали), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хамтран
8	Монгол: Тогтвортой хуванцар дахин боловсруулалт <i>(хэрэгжиж байгаа)</i>	Тогтвортой хог хаягдлын менежмент	Тогтвортой нийлүүлэлтийн сүлжээ болон хуванцарын хаягдлын менежментийг 3 чиглэгдсэн газарт хэрэгжүүлэх	тодорхойгүй	Каритас Чех тэргүүлэн Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо (МХХДБҮХ), Монголын байгаль орчны аюулгүй байдлын төв (МБОАБТ) болон Т. Г. Масарик Ус судлалын хүрээлэн, олон нийтийн судалгааны байгууллага (TGM WRI, Чех)-тай хамтран

Эх сурвалж: <https://www.switch-asia.eu/projects/>

Энэхүү судалгааны зорилго нь одоо байгаа ТХҮ-тэй холбоотой бодлогын тогтолцоо, үндэсний болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүд, холбогдох институцийн тогтолцооны төлөв байдалд дүн шинжилгээ хийж тодорхойлоход оршино.

ТХҮ-тэй холбоотой бодлого, хэрэгсэл (урамшууллын тогтолцоо эсвэл хэрэгцээтэй хэрэгсэл), оролцогч талууд болон нөлөө бүхий талуудыг зурагласнаар магадгүй Монголын Засгийн газарт цаашид ТХҮ-г үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх, үүнд ТХҮ-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох институцийн хүрээг бэхжүүлэхийг тусгасан, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах үндэс суурь болох боломжтой.



## 2. СУУРЬ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэгт суурь судалгааны цар хүрээ, судалгааны хязгаарлалт, түүнчлэн бодлого, институцийн хүрээг тодруулах, зураглахад ашигласан арга зүй, хэрэгслийг тоймлон нэгтгэлээ.

### 2.1. ЦАР ХҮРЭЭ БА ХЯЗГААРЛАЛТ

Энэхүү судалгаанд Монгол улсын засаглалын тогтолцооноос гадна иргэний нийгэм дэх ТХҮ-ын институцийн цар хүрээний ерөнхий тоймыг гаргахыг зорив.

Үүнд ТХҮ-ийг тусгасан бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх болон хяналтыг хэрэгжүүлэхэд оролцдог үндэсний болон орон нутгийн байгууллагууд хамаарна.

Мөн төрийн бус байгууллагууд, тухайлбал бизнесийн болон салбарын холбоод, иргэний нийгмийн байгууллагууд орж байна.

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд тухайн орныхоо тэргүүлэх ач холбогдол бүхий олон асуудлуудаа шийдвэрлэхийг зорьж байгаа ч заримдаа цогц олон асуудал хоорондоо зөрчилдөх нь бий. Иймээс энэхүү судалгаа нь тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн үндсэн асуудлууд болох нөөцийн хэмнэлттэй ашиглалт, хаягдал багатай, эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг Монгол улс ямар бодлого, зохицуулалтаар шууд болон тодорхой хэмжээгээр дэмжиж байгаад төвлөрсөн болно.

### 2.2. АРГА ЗҮЙ

Судалгааны баг баримт бичиг, хууль тогтоомжийн судалгаа хийснээс гадна зураглалд холбогдох мэдээлэл авах зорилгоор оролцогч талуудын төлөөлөлтэй ярилцлага хийж, санал солилцов<sup>8</sup>.

Баримт бичиг, хууль тогтоомжийн судалгаанд дараах судалгааг хийв. Үүнд:

- ТХҮ, холбогдох болон нөлөөлөх байгууллагуудтай холбоотой, байгаа бодлогын баримт бичгүүдийн тойм,
- Монгол улсын болон бусад орнуудын ТХҮ-ийг хэрэгжүүлэхэд гарч буй амжилт, сайн туршлага, үзүүлэлт зэрэг онлайн мэдээллийн эх сурвалжуудын судалгаа, болон
- ТХҮ-тэй холбогдох чиглэлээр хандивлагчдын санхүүжилттэй байгаа хэрэгжиж буй төслүүдийн тойм.

Баримт бичгийн судалгаанд Монгол Улсын бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын албан ёсны баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, нэмж холбогдох судалгааны тайлан, нийтлэл, ном, жилийн тайлан, вэб хуудсуудад гарсан хоёрдогч мэдээллийг хянаж, шинжилгээнд ашиглав.

Баримт бичгийн судалгаанаас гадна гол оролцогч талуудтай уулзаж, ярилцах ажлыг зохион байгуулсан. Үүнд яамдын хэлтэс, газар, агентлагууд, төрийн холбогдох байгууллагын удирдлага, хариуцсан мэргэжилтнүүд, бусад оролцогч талууд, тухайлбал мэргэжлийн холбоод, ТББ, төсөл хэрэгжүүлэгчид, судлаачид, хандивлагчдын төлөөлөл зэрэг 30 гаруй хүнтэй уулзалт зохион байгууллаа.

<sup>8</sup> Бодлогын баримт бичгүүдээс зохих хэсгүүдээс иш татан оруулсан боловч судалгааны баг ярилцлагад оролцогчийн нэрийг нууцлах үүднээс ярилцагаас иш татаагүй болно. Уулзаж, ярилцлага хийсэн оролцогч талуудын төлөөллийн бүрэн жагсаалтыг Хавсралт 2-т харуулав.



## 3. ТХҮ-ТОЙ ХОЛБООТОЙ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Судалгааны баг Монгол Улсын макро эдийн засгийн хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө (салбар дундын макро түвшний бодлого), салбарын бодлогын баримт бичиг, мөн ТХҮ бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбогдох байгаль орчин, байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулах, ногоон өсөлтийг хангахтай холбоотой бүхий л арга хэрэгслийн хүрээг судлан нэгтгэснийг энэ бүлэгт танилцуулж байна.

### 3.1. САЛБАР ДУНДЫН СУУРЬ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

#### 3.1.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010-2030)

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг 2010 оны 7-р сарын 15-ны өдөр УИХ-с баталсан билээ. Энэ Үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлыг хангах гол чиглэл, арга замыг тодорхойлсон төрийн бодлогын чухал баримт бичиг бөгөөд үүнээс үүдэлтэй аюулгүй байдлын салбар, эрх зүйн орчны өргөн хүрээтэй шинэтгэлийг эхлүүлсэн юм. Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож, зөвхөн төр, түүний тусгай байгууллагуудын үүрэг хэмээн үзэж байв. Шинэ нөхцөл байдал нь аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга замыг өргөтгөж, шинэчилсэн үзэл баримтлал нь хүн төвтэй, цогц, мэдлэгт суурилсан гэсэн суурь зарчмаар өөрчлөгдсөн. Хувь хүний аюулгүй, амгалан, эрүүл, хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн сурвалж болж, энэ нь цаашлаад төр, улс, үндэсний аюулгүй байдлыг хангах ба энэ нь тунхаглалын шинжтэй бус төр, нийгэм, иргэдийн харилцан хамтын ажиллагаагаар, харилцан уялдаатай байх тодорхой стратеги, чиглэлийг заасанд энэ баримт бичгийн ач холбогдол оршино.

Бодлогын суурь баримт бичгүүдийн жагсаалтыг Хавсралт 3-с харна уу.

#### 3.1.2. Ногоон хөгжлийн бодлого (2014-2030)

УИХ-с 2014 оны 43 дугаар тоот тогтоолоор “Ногоон хөгжлийн үзэл санаанд тулгуурласан, иргэдийн оролцоог хангасан эдийн засгийн өсөлтийг бий болгосноор хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцөлийг бүрдүүлсэн хөгжингүй улс болох”<sup>9</sup> зорилгыг хэрэгжүүлэх Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого (НХБ)-ыг батлав. НХБ-д уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон хөгжил, үүнийг санхүүжүүлэх хувилбар, ногоон ажил эрхлэлт, байгаль орчин, соёлын өвийг дээдлэн хүнд ээлтэй хотын дэд бүтцийг хөгжүүлэх зорилт бүхий дараах стратегийн зургаан зорилтыг дэвшүүлсэн байна:

1. Стратегийн зорилт 1. **Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ЯЛГАРАЛ БОЛОН ХАЯГДАЛ БАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛНЭ.**
2. Стратегийн зорилт 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

<sup>9</sup> УИХ-ын 2014 оны 43 дугаар тоот тогтоолын хавсралт.

3. Стратегийн зорилт 3. Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
4. Стратегийн зорилт 4. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
5. Стратегийн зорилт 5. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно.
6. Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг 14 үзүүлэлтийг ашиглан 2020 болон 2030 онуудад тодорхой зорилтот түвшинд хүргэхээр тогтоосон (**Хүснэгт 2**-г харна уу).<sup>10</sup>

## Хүснэгт 2: НХБ-ын шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлт	2020	2030
Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь	20%	30%
Барилгын дулааны алдагдлын бууралт	20%	40%
Хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ	20%	40%
Ногоон хөгжилд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2%	3%
Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулах зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2%	3%
Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	20%	30%
Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ	25%	30%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хувь	20%	30%
Нийт газар нутагт ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	8.5%	9.0%
Баталгаат ундны усаар хангагдах хүн амын эзлэх хувь	80%	90%
Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдах хүн амын эзлэх хувь	40%	60%
Ядуурлын түвшин	24%	15%
Улаанбаатар хот, бусад суурин газрын ногоон байгууламжийн талбайн эзлэх хувь	15%	30%
Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	28%	30%

Бодлогын хэрэгжилтийн 1-р үе шат буюу 2014-2020 онд ногоон хөгжлийн үндэс суурийг тавих гол ажлууд хийгдэв. Үүнд:

- НХБ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлах: БОАЖЯ-с бүх холбогдох талууд, үүнд яамд, байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл зэргийг оролцуулан НХБ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраас 2016 оны 1 сард баталсан.
- 2017 онд НХБ-ын хэрэгжилтийг үнэлэх 14 үзүүлэлт, үр дүнгийн 108 үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх үндэслэлийг боловсруулахад

<sup>10</sup> 2013 оны тоон мэдээллийг суурь болгон авч үзнэ.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ), НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE) хамтран ажиллаж, ҮСХ-с 38 шалгуур үзүүлэлтийг баталсан.

- Ногоон хөгжлийг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго, шалгуур үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийн, ТХЗ-тай уялдуулах, зорилтууд болон хэрэгжүүлэх арга хэмжээнүүдтэй уялдсан байдалд дүн шинжилгээг Дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэн (GGGI) хийж, 43 үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг эцэслэн боловсруулжээ.

НХБ-д “Эхлээд хөгжье, дараа нь цэвэрлэе” гэсэн өнөөгийн хандлагыг өөрчлөн байгальд ээлтэй, хаягдал багатай, үр ашигтай үйлдвэрлэлийг хөгжүүлэн, бүтээмжийг дээшлүүлж, нийгмийн оролцоог хангасан, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгон хүн амын амьдралын чанарыг сайжруулах хэрэгцээ, шаардлага зайлшгүй тулгараад байгааг онцолсон юм.

НХБ-ын стратегийн зорилт 1 ТХҮ-тэй шууд холбогдоно: Энэ зорилтод Монгол улс “байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх”-ээр томъёолсон.

НХБ-ын бусад зорилтууд ч ТХҮ-ийн асуудлууд болон ТХЗ 12-той мөн шууд уялдаатай. Тухайлбал:

- Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ (Стратегийн зорилт 3), болон
- Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ (Стратегийн зорилт 4).

ТХҮ-ийг нутагшуулахыг дэмжсэн чиглэлүүдийг дээрх стратегийн зорилтуудад хүрэх арга замд бүр тодорхой зааж өгөв. Тухайлбал:

- 3.1.7. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;
- 3.1.8. Эрдэс баялгийн салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий үйлдвэрлэлийг дэмжих;
- 3.3.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний 2-оос доошгүй хувийг жил бүр ногоон хөгжилд зарцуулж, нэгж бүтээгдэхүүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, бүтээмжийг дээшлүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх;
- 3.3.2. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, дэмжих, байгалийн нөөцийн ашиглалтын бүтээмжийг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх;
- 3.3.4. Байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн ногоон татварын системийг бий болгох;
- 3.3.6. Засгийн газрын худалдан авалтын 20-оос доошгүй хувийг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах;
- 3.3.8. Ногоон хөгжлийн үзүүлэлтийг үндэсний тооцооны системд тусган байгаль орчноос нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцох;
- 3.5.1. Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан эх оронч үзэл, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх;

- 3.5.2. Байгаль орчны удирдлагын MNS ISO14000 багц стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох;
- 3.5.4. Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2030 онд 3 хувьд хүргэн, ногоон хөгжлийн хурдасгуур болгох;
- 3.5.5. Инноваци, биотехнологи, нанотехнологи дамжуулах, бойжуулах, нутагшуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, чанар, онцлогоороо тэргүүлсэн ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх; болон
- 3.6.4. Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувь бууруулах.

### **3.1.3. Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016-2030)**

2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын 35 дугаар тогтоолоор НХБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдав. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд бодлогын стратегийн 6 зорилт, 51 зорилгын хүрээнд 255 арга хэмжээг 2020, 2030 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнд:

#### **1. Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжих**

Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашиг, ногоон барилга, олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн ил тод хариуцлагатай байдал, байгаль хамгаалал, нөхөн сэргээлт, байгальд ээлтэй дэвшилтэд техник технологи, тогтвортой хөдөө аж ахуй зэрэг чиглэлээр **70** үйл ажиллагаа,

#### **2. Экосистемийн даацыг тогтвортой хадалах**

Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн баялгийн ашиглалтын нөөц, байгаль орчны бохирдол, эрүүл аюулгүй орчин, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтол, эко аялал жуулчлал зэрэг **63** үйл ажиллагаа,

#### **3. Байгалийн капитал, хүний хөгжил, цэвэр технологийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх**

Ногоон эдийн засаг, санхүүжилт, татвар, зээл, урамшуулал, оновчтой хөшүүрэг, дэвшилтэт цэвэр технологи нутагшуулалт, хөрөнгө оруулалт, төрийн тогтвортой/ногоон худалдан авалт зэрэг **34** үйл ажиллагаа,

#### **4. Ногоон амьдралын хэв маягийг хэвшүүлэх**

Ногоон ажлын байр, зохистой хөдөлмөр эрхлэлт, амьжиргаа, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн гамшиг, чадавхыг бэхжүүлэх, байгальд ээлтэй амьдралын хэв маяг **36** үйл ажиллагаа,

#### **5. Тогтвортой хөгжлийн боловсрол, шинжлэх ухаан, инновацыг хөгжүүлэх**

Боловсрол, шинжлэх ухаан, инноваци, ногоон технологийн чиглэлээрх хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, байгаль орчны удирдлагын ISO 14000 багц

стандарт, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн боловсрол зэрэг 17 үйл ажиллагаа, болон

## 6. Хүн амын суурьшлын төлөвлөлтийг цаг уурын өөрчлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх

Байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээ, орчны бохирдлыг бууруулсан “ногоон”, “ухаалаг” хот, суурин, тав тухтай, цэвэр амьдрах орчин зэрэг 34 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

### 3.1.4. Алсын хараа-2050

Энэ судалгаа хийгдэж, тайлангийн эхний хувилбар гарсны дараа буюу Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг хүчингүй болсонд тооцон, тухайн үеийн Засгийн газар дахин “Алсын хараа-2050” бодлогын баримт бичиг шинээр батлагдсан юм. Иймээс Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогын залгамж урт хугацааны хөгжлийн бодлого болох Алсын хараа-2050 баримт бичгийг энд танилцуулж байна.

**Зураг 1**-т Монгол улс тогтвортой хөгжлийг цогцлооход чиглэсэн бодлогын үзэл баримтлалаа баталж, хэрэгжүүлж ирсэн цаг хугацааны онцлох чухал үе шатуудыг харуулав<sup>11</sup>.

**Зураг 1: Монгол улсын тогтвортой хөгжлийн бодлогын он дараалал**



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь 9 зорилго, нийт 50 зорилттой ба гурван 10 жилээр буюу 2020-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

- 1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл:** Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно.
- 2. Хүний хөгжил:** Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана.
- 3. Амьдралын чанар ба дундаж давхарга:** Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ.
- 4. Эдийн засаг:** ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд оногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна.
- 5. Сайн засаглал:** Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.
- 6. Ногоон хөгжил:** Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана. Хүлэмжийн хийн ялгарал багатай, хүртээмжтэй ногоон хөгжлийг бий болгоно.
- 7. Амар тайван, аюулгүй нийгэм:** Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад дотоод таатай орчин бүрдэнэ.

<sup>11</sup> GIZ: Aligning Mongolia's NDC and SDGs through its national Green Development Policy, 2019

8. **Бүсчилсэн хөгжил:** Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ.
9. **Улаанбаатар ба дагуул хот:** Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ. Улаанбаатар хот орон зайн оновчтой бүтэц, нутагшилт суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж буй дагуул хотуудтай, эрүүл аюулгүй, амьдралын таатай орчин бүхий олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинэ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд **2021-2030 он хэрэгжүүлэх үйл АЖИЛЛАГАА**-г мөн баталсан.<sup>12</sup> Үүнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлж өгчээ. Тухайлбал “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах” Зорилт 6.4-ын хүрээнд ТХҮ-г **нутагшуулахад чиглэсэн** тодорхой арга хэмжээнүүдийг төлөвлөсөн. Тухайлбал:

6.4.1. Байгальд ээлтэй, хэмнэлттэй хэрэглээ, үр ашигтай дэвшилтэт ногоон технологийг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.

6.4.2. Үүсэх хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн эко төлбөрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлнэ.

6.4.3. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

6.4.4. Бохирдол, хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.

6.4.5. Байгаль орчны менежментийн MNS ISO14000 багц стандарт нэвтрүүлэх, ногоон гэрчилгээ олгох тогтолцоог дэмжин эрчимжүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний зөв дадлыг бий болгоно.

6.4.6. Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.

6.4.10. Барилгын салбарт ногоон, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлнэ.

6.4.14. Байгальд ээлтэй ногоон төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх төр, хувийн хэвшлийн хамтарсан үндэсний ногоон санхүүгийн тогтолцоог байгуулж хөгжүүлнэ.

6.4.15. Байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүгийн тогтолцоог бэхжүүлж, тогтвортой бизнесийн зарчмыг эдийн засаг, нийгмийн салбарт нэвтрүүлж, аж ахуйн нэгжийн байгаль орчин, нийгмийн хариуцлагыг өндөржүүлнэ.

6.4.16. Байгальд ээлтэй тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ухаалаг хэрэглээг төлөвшүүлж дэлгэрүүлэх, байгаль орчин, нийгэмд ээлтэй төсөл, үйл ажиллагааг

<sup>12</sup> УИХ-ын 2020 оны 52 дугаар тоот тогтоолын 2 дугаар хавсралт.



санхүүжүүлэх үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо (ногоон банк, ногоон бонд, ногоон бирж, ногоон даатгал)-г шинэ шатанд гаргана.

6.4.18.Химийн хорт болон аюултай бодисыг бүртгэх, шилжилт хөдөлгөөнийг хянах, бүртгэл, мэдээллийн цахим системийг бий болгож хөгжүүлнэ.

6.4.19.Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажиллагааг хэвшүүлж, дахин боловсруулах, эрчим хүч гаргах байгаль орчинд хор, нөлөөгүй үйлдвэрийг байгуулна.

6.4.20.Улаанбаатар хот, бүсийн төвүүд болон бусад хот, суурин газарт хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын ландфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна.

6.4.21.Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг нийт 72 үзүүлэлтийг ашиглан 2025, 2030 болон 2050 онд тодорхой түвшинд хүрэхээр тодорхойлсон<sup>13</sup>. Үүнээс ТХҮ-т холбогдох үзүүлэлтийг сонгон харуулав.

### Хүснэгт 3. Алсын хараа-2050 бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018 оноор)	Хүрэх түвшин		
				2025	2030	2050
31	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум ам. доллар	13.1	23.9	47.6	209.0
36	Боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	хувь	10.9	12	14.6	27.4
42	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	сая.хүн	0.6	1	2	6
59	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	7.6	27	40	50
60	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	25.6	52	64	90
61	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	10	20	50
62	Нэгж ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүнд ногдох дотоодын материалын хэрэглээ	кг/ам.долл ар	15	10	6	3

<sup>13</sup> УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт.



### 3.1.5. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024)

2020 оны 7 сард шинэ Засгийн газар байгуулагдан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулсан ба үйл ажиллагааны хөтөлбөр УИХ-ын 2020 оны 8 сарын 28-ны өдрийн 24 дугаар тогтоолоор батлагдав. Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх, өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, дараах зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтуудаа дэвшүүллээ:

1. **“КОВИД-19”** халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.
2. **Хүний хөгжлийн бодлогын** хүрээнд иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, дундаж давхаргыг өргөжүүлэх чиглэлээр эрүүл мэнд, соёл, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн талаар оновчтой бодлого хэрэгжүүлнэ. Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэх зорилт, арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.
3. **Эдийн засгийн бодлого** нь макро эдийн засгийн орчныг бэхжүүлэх, дунд хугацаанд эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтвортой өсөлтийг хангах, тэргүүлэх салбарыг хөгжүүлэхэд чиглэгдэж байна.
4. **Засаглалыг бэхжүүлэх** хүрээнд шударга ёсыг бэхжүүлэх, төрийн албаны бүх шатанд сахилга, дэг журам тогтоох, хүнд суртлыг арилгах, хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл хийх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг чандлан баримтлах, иргэдийн тайван, аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарна. Түүнчлэн төрийн үйлчилгээг олон нийтэд түргэн шуурхай хүргэх “Цахим Монгол”-төрийн шуурхай үйлчилгээг хэрэгжүүлнэ.
5. **Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх** хүрээнд байгалийн нөөцийг зохистой ашиглах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, иргэдийн эрүүл амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байх, байгаль орчинд ээлтэй бизнес эрхлэх, байгалийн нөөцийг хамгаалах, хомсдолоос урьдчилан сэргийлэх, ухаалаг ашиглах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлнэ.
6. **Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын** хүрээнд бүс нутгийн болон орон нутгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийг сайжруулах, Улаанбаатар хот болон дагуул хотуудын ирээдүйг оновчтой төлөвлөх, ухаалаг шийдэл бүхий хот болгон хөгжүүлэх зорьж байна.

### 3.1.7. Орон нутгийн Ногоон хөгжлийн бодлого

Өвөрхангай, Хэнтий, Архангай, Баянхонгор, Орхон, Ховд аймгуудад БОАЖЯ-г бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлсний үр дүнд Монгол улсын ногоон хөгжлийн бодлогыг орон нутгийн онцлог, давуу талыг харгалзан Өвөрхангай, Хэнтий, Архангай, Баянхонгор, Орхон, Ховд аймгууд ногоон хөгжлийн стратеги, үйл ажиллагаагаа тусгасан Ногоон хөгжлийн бодлогоо боловсруулан батлан, хэрэгжүүлж байна.

Нийслэлийн Байгаль орчны газар, Азийн сан олон улсын байгууллагатай хамтран ногоон хотыг цогцлоох зорилгоор Монгол улсын Ногоон хөгжлийн бодлогод суурилсан Улаанбаатар хотын 2020 он хүртэлх ногоон хөгжлийн стратеги, төлөвлөгөөг

боловсруулж, 2016 оны 3 сард уг анхны төлөвлөгөөг баталжээ. Улаанбаатар хот Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Ногоон хотуудын хөтөлбөрт нэгдсэний дараа Улаанбаатар хотыг Ногоон хот болгох үйл ажиллагааны төлөвлөгөөг ЕСБХБ болон БНСУ-ын Санхүү, эдийн засгийн яамны дэмжлэгтэйгээр 2019 оны 11 сард шинээр боловсруулж, баталсан байна.

## 3.2. ТХҮ-ийн хэрэгжилтийг дэмжих эрх зүйн зохицуулалтын хэрэгсэл

Монгол улсын дунд болон урт хугацааны хөгжлийн стратеги бодлого, төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн 17 зорилго, эдгээрийн зорилтууд, үүн дотор хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэлийн 12 дугаар зорилго, түүний 11 зорилтууд хангалттай тусгагдсан гэж үзэж болохоор байна.

Өмнөх хэсэгт тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийг нутагшуулахад ач холбогдол бүхий харилцан уялдаатай үндэсний хөгжлийн бодлого, хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгээс танилцуулсан. Энэ хэсэгт ТХЗ 12 сэдэвтэй холбоотой Монгол Улсын хувьд тэргүүлэх ач холбогдолтой чиглэл, салбарын гол бодлого, зохицуулалтын баримт бичгээс танилцуулж байна.

### 3.2.1. Байгалийн нөөцийн тогтвортой менежмент

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2 дах хөтөлбөр болно) Засгийн газрын 2015 оны 325 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан юм. Монгол Улсын иргэн бүрийн Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцвэрт байдал алдагдахаас хамгаалуулах эрхийг нь баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэх эрхэм зорилгын хүрээнд тэргүүлэх 4 чиглэлээр 2025 он хүртэл хэрэгжүүлэхээр 14 зорилго, 29 зорилт, 74 хүрэх үр дүнг тодорхойлсон.

- **Тэргүүлэх чиглэл 1:** биологийн олон янз байдлын хамгаалал, зохистой ашиглах талаарх шийдвэр гаргагч, олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх (2 зорилго, 4 зорилт, 9 үр дүн бүхий)
- **Тэргүүлэх чиглэл 2:** биологийн олон янз байдлын нөөцийн талаарх шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан зохистой ашиглах болон хамгааллын бодлогыг бий болгон хэрэгжүүлэх (5 зорилго, 12 зорилт, 34 үр дүн бүхий)
- **Тэргүүлэх чиглэл 3:** биологийн олон янз байдлын тогтвортой ашиглах нөхцөлийг хангах (3 зорилго, 5 зорилт, 14 үр дүн бүхий)
- **Тэргүүлэх чиглэл 4:** биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг хамгаалах, ашиглах бодлого, эрх зүйн орчныг сайжруулах (4 зорилго, 8 зорилт, 17 үр дүн бүхий)

Энэ хөтөлбөр байгаль орчны холбогдолтой бодлого, бусад үндэсний хөтөлбөрүүд Ус үндэсний хөтөлбөр (2010-2021), Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2010-2020), Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011-2021), Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр (2005-2035), Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр (2012-2021) зэрэгтэй уялдаатай.

Байгаль орчны менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтдээ 30 гаруй хууль, холбогдох 150 гаруй зохицуулалтын баримт бичиг байна (зөвхөн ойн менежментэд хамаарах 40, усанд хамаарах 20 г.м.).


### 3.2.2. Хог хаягдлын менежмент

**ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ:** Алсын хараа-2050, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, ялангуяа НХБ-ын тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн арга хэлбэрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлын хэмжээг бууруулах, цэвэр, эрүүл орчинг бүрдүүлэхээр заасан. Монгол улс хог хаягдал, хорт бодистой холбоотой олон улсын гэрээ, конвенциудад нэгдэн мөрдөж байна. Тухайлбал: Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц (1993), Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц (1996), Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц (1999), and Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци (2003) зэрэг.

Хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилт өссөнтэй холбоотойгоор сүүлийн арван жилийн хугацаанд хог хаягдлын асуудал Монгол улсын хэмжээнд тулгамдсан асуудлын нэг болоод байна (**Зураг 2**-г харна уу). 2009 онд жилд 820 мянган тонн хог хаягдал улсын хэмжээнд гаргадаг байсан бол 2015 оны байдлаар 2.9 сая тонн хог хаягдал үүсч, даруй 3,6 дахин нэмэгджээ<sup>14</sup>.

Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хог хаягдлын хууль эрх зүйн шинэчлэлийн ажил хийгдэн, зарим хуулийн давхардлыг арилгах, шинээр өнөөгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажлууд хийгдсэн. Тухайлбал хог хаягдлын менежментийн тухай хуулийг 2017 онд боловсруулж баталсан нь эхний шатны хэрэгжилтийн гол үр дүн болжээ. Хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор “Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2017 онд шинээр боловсруулсан. Ерөнхий стратеги нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хог хаягдлыг багасгах шийдлүүд болох урьдчилан сэргийлэх, бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглаж байж зайлуулах гэсэн шатлалыг тусгаж өгсөн. Харамсалтай нь энэ стратеги батлагдаагүй юм.

**Зураг 2. Улсын хэмжээнд хог хаягдлын ялгарлын хэмжээ**



Эх сурвалж: ХХМССҮАТ (2017) болон ХХААХҮЯ

Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор 2019 оны 3 сарын 1-ээс эхлэн 0.035 мм болон түүнээс нимгэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав баглаа боодлын зориулалтаар ашиглах, үйлдвэрлэх, импортлохийг хориглосон. БОАЖЯ-с Эко төлбөрийн тухай хууль боловсруулахаар ажлын хэсэг гарган ажиллаж байгаа бөгөөд хуулийн төсөлд хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр үйл

<sup>14</sup> Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2017 он (батлагдаагүй)

ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд тухайн хуулийн дагуу олсон орлогын 50 хувийг дэмжлэг хэлбэрээр олгохыг тусгах тухай мэдэгдсэн байна<sup>15</sup>.

Засгийн газрын 2015 оны 263 дугаар тогтоолоор батлагдсан “Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилж, урамшуулал олгох журам” нь хог хаягдлыг бууруулахад урамшууллын хөшүүрэг болж байгаараа ач холбогдолтой юм.

**Үйлдвэрийн болон хортой хог хаягдлын менежмент:** Үйлдвэрийн хог хаягдлыг аюултай (зарим үйлдвэрлэлийн, эрүүл мэндийн байгууллагын, лабораторийн болон барилга угсралт, барилга нураалтын хог хаягдал үүнд хамаарна) болон энгийн хог хаягдал (үүнд зарим барилга угсралт, барилга нураалтын хог хаягдал, худалдаа-үйлчилгээний хог хаягдал хамаарна) гэж ангилна. Хэдийгээр үйлдвэрийн хог хаягдлыг хотын хог хаягдал гэж тооцохгүй ч зарим газарт аюултай хог хаягдлыг тухайн хот суурин газрын хогийн байгууламжид буюу төвлөрсөн цэгт зайлуулдаг.

Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт аюултай хог хаягдлын менежмент, зохицуулалтын чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор заасан. Монгол улс байгаль орчны асуудлаарх Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц, Ховордсон амьтан, ургамлын аймгийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES), Аюултай хог хаягдлыг хил дамнуулан зөөвөрлөх, тэдгээрийг устгахад хяналт тавих тухай конвенцийн (Базелийн конвенц) зэрэг бараг ихэнх олон улсын гэрээ хэлэлцээр, конвенциудад нэгдсэн. БОАЖЯ нь хүлээн авагч орны байгаль орчны асуудал эрхэлсэн яамтай хамтран аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх тохиолдолд тээвэрлэлтийн хяналт, шалгалтыг зохион байгуулдаг.

БОАЖЯ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-с аюултай хог хаягдлыг хянаж, хууль эрх зүйн хэрэгжилтийн хангаж ажиллана. Дараахь хууль тогтоомжуудаар аюултай хог хаягдлын менежментийг зохицуулна. Үүнд:

- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (1995, 2006);
- Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дугаар тушаалын хавсралт);
- ЗГ-ын 2007 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт (126 бодис) болон Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт (31 бодис);
- Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх, бүртгэх, тайлашнах журам (Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт), болон
- Полихлорт бифенилийн бүртгэл хөтлөх, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах, импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх журам (БОХЖ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2012 оны А-17/16 дугаар тушаал).

Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ)-ний тухай хууль тогтоомж, аргачлал, зохицуулалтын журмууд цогцоор боловсруулагдан, мөрдөгдөж байдаг ба БОНБУ-ний хэрэгслийг ашиглахад ихээхэн туршлага хуримтлуулсан. 2012 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад биологийн олон янз байдлыг хамгаалах, эдийн засгийн үнэлгээг тооцох, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалахыг тусган хуульчилсан. 2012–2013

<sup>15</sup> Эх сурвалж: <https://www.mne.mn/?p=4204>

онд байгаль орчны аудит нэвтрүүлсэн нь байгаль орчны менежментийн тогтолцоонд чухал алхам болсон юм.

Бусад зохицуулалтын хэрэгслүүд нь:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлсөн байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт,
- Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам,
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам зэрэг болно,

Монгол улс хаягдал боловсруулах үйлдвэрийн татварыг 50 хувь бууруулахаар тооцож байна<sup>16</sup>.

Засгийн газар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС Монгол)-ыг даган мөрдөхийг тунхагласнаас хойш Монгол улс ОУИТБС-н тайланг тогтмол гаргадаг болсноор уул уурхай, олборлох салбарын компаниудыг ТХЗ 12.6-т нийцүүлэн тогтвортой арга барил нэвтрүүлэх, компаниуд тогтвортой байдлын талаарх мэдээллийг тайландаа тусгахад чухал алхам болов. Монгол орны байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтөд үнэлгээ-дүгнэлт өгч нэгтгэн, төрийн бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад үндэслэл болгох зорилгоор БОАЖЯ 2 жил тутамд Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайланг гаргаж байна.

Мөн төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллага, ТББ-с хийсэн хот суурин газрын хатуу болон үйлдвэрийн хог хаягдлын талаар олон тайлан гарсан байна (жишээ нь 2030 он хүртэл хэрэгжүүлэх Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, 2017).

БОАЖЯ ба Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь байгаль орчны албан ёсны статистик мэдээллийг гаргахад хамтран ажилладаг. Байгаль орчны менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд сүүлийн үед ахиц гарч байгаа боловч MNS ISO 14001 стандартын дагуу гэрчилгээжсэн ААНБ цөөн байна. Зохицуулалтын бус механизм нь тухайлбал Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн иргэнд урамшуулал олгох журам" юм.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ:** Эмнэлгийн хог хаягдлын менежмент нь чухал бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг юм. Эрүүл мэндийн сайдын 2009 оны 293 тоот тушаалаар “Эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежментийн стратеги, түүнийг 2009-2013 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” батлагдсан нь эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлыг өндөр даралттай уураар ариутгах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэхэд гол түлхэц болж өгөв. Үндэсний стратегийг хэрэгжүүлэх, эмнэлгийн хатуу хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд дараах зохицуулалтын баримт бичгүүдийг дагаж мөрдөнө. Үүнд:

- Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2011 оны 07/27 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн байгууллагын мөнгөн ус агуулсан багаж тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар баримтлах журам” батлагдсанаар эрүүл

<sup>16</sup> Эх сурвалж: <https://global-recycling.info/archives/2287>

мэндийн байгууллагууд мөнгөн ус агуулсан халууны шил, мөнгөн устай даралт хэмжигч багаж, шүдний амальгамыг шинээр худалдан авахыг хориглож, цаашилбал дэлхийн мөнгөн усгүй эрүүл мэнд санаачлагад нэгдэх, мөнгөн усыг эрүүл мэндийн салбарт хориглосон улсын нэг болоход дорвитой алхам болов. Энэ тушаалыг дагалдан гарсан зааврууд,

- Байгаль орчин, аялал жуулчлал, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2011 оны А-320/305 дугаар тушаалаар баталсан Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгах түр журам,
- Эмнэлгийг хог хаягдлыг түр хадгалах байр савны тоног төхөөрөмжийн жагсаалт (ЭМС-ын 2011 оны 179-р тушаал),
- Эрүүл мэндийн байгууллагын хош хаягдлын төвлөрсөн байгууламжийн журам (ЭМС-ын 2011 оны 380-р тушаал),
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын төлбөрийн хэмжээ тооцох аргачлал (ЭМС-ын 2015 оны 459-р тушаал),
- Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар (ЭМС-ын 2017 оны А/505 тушаал) зэрэг.

Эрүүл мэндийн салбарын хог хаягдлын менежментийн стратегийг хэрэгжүүлж, хөдөө орон нутгийн эмнэлгүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор тусгай хог хаягдалтай холбоотой “Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг түр хадгалах байгууламж барих заавар”, “Сум, сум-дундын эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалах байгууламж барих заавар”, “Ихсийн нүхний заавар” зэрэг Эрүүл мэндийн сайдын 2011 оны 179 тоот тушаалаар батлагдсан зааврууд мөрдөгдөж байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжсэн төслүүдийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээний хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмж, хангалтыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас 9 аймгийн 28 суманд, Монголын Мянганы Сорилтын сан (Монголын МСС)-с 10 аймгийн 35 суманд, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр 90 сум болон 5 аймгийн эмнэлгүүдэд хүргэж, нийт 1 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн байдаг. Олон улсын байгууллагуудаас эмнэлгүүдийг шатаахгүй технологи буюу өндөр даралттай уурын автоклаваар хангаж, боловсон хүчнийг сургаж дадлагажуулсан байна.

### 3.2.3. Үйлдвэрлэлийн голлох кластерт хамаарах бодлого, хэрэгжилт

Монгол улсын аж үйлдвэрийг дараах үндсэн салбаруудад хуваана (Зураг 3-г харна уу). Ач холбогдол бүхий боловсруулах үйлдвэрлэлд ноос, ноолуур, нэхмэл сүлжмэл, модон бүтээгдэхүүн, хэвлэл, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг ордог байна. Боловсруулах үйлдвэрлэлийн хэмжээ 2019 оны 9 сарын байдлаар өмнөх оны тухайн сарынхтай харьцуулахад 12.60 хувиар нэмэгдсэн байна<sup>17</sup>.


Аж үйлдвэрийн салбарын дунд хугацааны бодлогын хүрээнд хүрэх нэг үр дүн бол “эх оронч худалдан авалтаар төрийн байгууллагын дотоодоос худалдан авах бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ 3-5 дахин нэмэгдэж, иргэд, аж ахуйн нэгжүүд үндэсний үйлдвэрээ дэмжих хандлага эрс өөрчлөгдсөн байхад” чиглэж байна<sup>18</sup>.

<sup>17</sup> <https://tradingeconomics.com/mongolia/manufacturing-production>

<sup>18</sup> <http://mofa.gov.mn/exp/blog/11/175>



### Зураг 3: Монгол улсын үйлдвэрлэлийн салбар



Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл хамгийн ихтэй үйлдвэрлэл-хэрэглээний кластерын нийт амьдралын мөчлөгийн туршид анхаарсан бодлого хэрэгжүүлснээр ТХҮ-ийг амжилттай хэрэгжүүлж, үр дүнд хүрэх боломжтой<sup>19</sup>.

Гэтэл байгаль орчинд сөрөг нөлөө хамгийн их үзүүлэх үйлдвэрлэл-хэрэглээний кластер нь дараах үйлдвэрлэлийн салбарууд болно:



Хүнс, ундаа



Барилга



Тээвэр



Аялал жуулчлал



Нэхмэл-сүлжмэл

#### 3.2.3.1. Хүнс, хөдөө аж ахуй

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2020-2024 онд “Атрын IV аян”, “Монгол мал-II” арга хэмжээг үргэлжүүлнэ<sup>20</sup>.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого (УИХ-ын 2015 оны 104 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан) нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах, хангахад чиглэж байгаа юм. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад ус, эрчим хүчний зарцуулалт багатай, байгаль орчинд халгүй дуслын болон хөрсөн доороос нэвчүүлэх усалгааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зэрэг дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлэх замаар хүнсний ногооны хэрэгцээг 2020 он гэхэд 70%, 2025 он гэхэд 100% хангах зорилгыг хэрэгжүүлэхээр заасан.

Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг баталсан. “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийг (2009-2016) амжилттай хэрэгжүүлсэн байна.

2019 оны 1 сарын 30-нд Засгийг газар “Эрүүл хүнс - эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг баталсан ба хөтөлбөрийн зорилго “хүнсний хангамжийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах, хүртээмжийг нэмэгдүүлэх; хүнсний шим тэжээллэг чанарыг сайжруулах, зохистой хэрэглээг дэмжих; хүнсний сүлжээний бүх шатанд түүхий эд,

<sup>19</sup> The SWITCH-Asia Network Facility, *Sustainable Consumption and Production Policies – A Policy Toolbox for practical use*, 2013. p.19.

<sup>20</sup> Засгийг газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.



бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах; хүнсний боловсруулах салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх; болон хүнсний аюулгүй байдлыг хангах бүтэц, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх”-эд оршиж байна. хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх ба хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 148 тэрбум төгрөг шаардлагатай аж.

2013 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн Үйлдвэр хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А/46/115 тоот тушаалаар “Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам” батлагдсан.

Засгийг газрын 2016-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “ард иргэд, аж ахуйн нэгж, улс орноо өрийн дарамтаас гаргаж, иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжин орлогыг нэмэгдүүлэх” (1.6)-ийн сацуу “иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах” (2.23)-аар заасан.

Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, бүтээгдэхүүний экспортыг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-с “Мах, сүүний анхдугаар аян” (Засгийг газрын 2016 оны 287 тоот тогтоолоор батлагдсан)-ыг хэрэгжүүлнэ.

### **Шигтгээ 1. Нэмүү өртөг ба зах зээлийн уялдаа**

Нэмүү өртөг ба зах зээлийн уялдаа холбооны асуудал нь бүтээгдэхүүний гарц, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтолцооноос хамааран ялгаатай зүйл байдаг. Үйлдвэрлэлийн тогтолцооны нэмүү өртөг ба зах зээлийн уялдаа сүргийн тоо толгойг нэмэх, эсвэл үүлдэр угсааг сайжруулах зорилго бүхий үйлдвэрлэгч хооронд голчлон арилжаалагддаг мал байдаг. Малыг амьдаар худалдаалахдаа гол төлөв аман хэлцэл хийж борлуулдаг. Гэтэл ноолуур, ноос, малын арьс, ширний хувьд хэдийгээр олон төрлийн бүтээгдэхүүний зах зээлд холбогдох боломжтой ч нэмүү өртгийг бий болгон боловсруулах боломж нь эндээ хязгаарлагдмал байна. Учир нь бэлчээрийн мал аж ахуйн иймэрхүү төрлийн бүтээгдэхүүний гарц үндсэндээ, махнаас ялгаатай нь, Монголын зах зээлд бүтээгдэхүүн цуглуулагчдын сүлжээгээр дамжин шууд хилээр гарч хятадын зах зээлд нийлүүлэгддэг (маш бага хувь үлддэг). Хилээр гарсан ноолуур хятадад нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болж боловсруулагддаг байна.

Малчин өрхийн боловсруулсан сүүн бүтээгдэхүүн, заримдаа нэмүү өртөг шингэсэн сав баглаа боодол ашигласан байж болно, шууд өрхөөс эсвэл сум, аймагтаа л зарагдана. Зарим сүүн бүтээгдэхүүн, тухайлбал айргийг хот суурин газрын ойролцоо шууд эцсийн хэрэглэгчид борлуулдаг.

### **3.2.3.2. Боловсруулах үйлдвэр**

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлээс мэдлэг, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэн, бүтээмжийг дээшлүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн цогц зорилтыг тодорхойлоход чиглэж байна. Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөрийг олборлолтын бус бүхий л салбарт хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн зорилго орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт

хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино. Монголын Засгийн газар 2019 оны 4 сард “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлав. Хөтөлбөрийг 2019-2022 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх ба санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулах замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгож буй зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. Түүнчлэн инноваци болон байгальд ээлтэй техник, технологийг эрчимтэй нэвтрүүлэн, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулахаар хөтөлбөрт тусгасан байна. Монгол улсын Засгийн газар ноолуур, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйлдвэрлэлийн салбарыг стратегийн ач холбогдол бүхий салбар хэмээн ач холбогдол өгч хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийг хангахад ноолуурын салбарыг хөгжүүлэн шинэ шатад аваачих зорилгоор 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 47 дугаар тогтоолоор Ноолуур хөтөлбөрийг батлав. Засгийн газар хоршоог ажлыг байр бий болгох, ядуурлыг бууруулахад чухал үүрэгтэй гэж үнэлдэг. Өнөөдөр үндэсний хэмжээнд 4200 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр II 2009-2017 онд хэрэгжиж дууссан ба Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III-г 2019 оны 9 сард батлав. Боловсруулах үйлдвэр, ЖДҮ-тэй холбоотой Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн бэлэн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай гэх мэт 30 гаруй хууль үйлчилж байна. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад Засгийг газраас (2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө) “жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх арга хэмжээг 2020 он дуустал үргэлжлүүлж”, “боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэх”, “бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна гэжээ.

Хөгжлийн банкнаас ноолуурын чиглэлийн 20 аж ахуйн нэгжид 188.2 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгосноор 2018 онд дотоодын үйлдвэрүүд 3700 тн ноолуур бэлтгэсэн байна. ЖДҮ-ийн импортын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн импортоос чөлөөлөх асуудлыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар зохицуулж байна.

Цөөнгүй ЖДҮ, үйлдвэрлэгчид оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэхийг сонирхож байна. Гадаадын орнуудтай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр нь Монгол Улсын экспортын бараанд импортын татвар бага байх боломжийг олгодог. Өөрөөр хэлбэл 2015 оны эхний 9 сард Монгол улс хагас сая долларын өртөгтэй 13 мянга орчим ширхэг ноолууран хувцас экспортолж, үүнд импортын 10.1 хувийн татвар ногдуулсан байна. Үүнийг аажмаар багасгах бодлого баримталж байгаа билээ. Ингэснээр монгол ноолуур нь Хятадын ижил төрлийн бүтээгдэхүүнээс давуу талтай байх боломжтой болох юм.

## **Шигтгээ 2. ЖДҮ-г хөгжүүлэх үндэсний хөтөлбөр**

Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн зорилт 2-т “Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах”-аар тодорхойлсон байна.

Ноолуур хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 3600 гаруй ажлын байр шинээр бий болгож, эцсийн

бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт 5,7 дахин өснө гэж ХХААХҮЯ тооцоолж байна. Дөрвөн жилийн хугацаатай хөтөлбөрийг хоёр үе шаттай хэрэгжүүлснээр нэхмэлийн салбарт 5500 гаруй ажлын байр тогтвортой хадгалагдах бөгөөд хэрвээ ноолуураа боловсруулж чадвал жилдээ 19,8 сая ширхэг сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн экспортод гарган 2,2-4,3 их наяд төгрөгийн борлуулалт хийх боломжтой гэж тооцоолсон байдаг.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр (SMEs)-ийг улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламж зэрэг эх үүсвэрээр санхүүжүүлэн 2019-2022 хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн үр дүнд татвар, хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалт, лизинг, даатгалын үйлчилгээнд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн тоо нэмэгдэж, аж ахуйн нэгжийн бие даасан байдал, өрсөлдөх чадвар сайжирч, дотоодын үйлдвэрээс худалдан авах төрийн байгууллагын худалдан авалт нэмэгдэнэ гэж үзэж байгаа юм. Статистикаас харвал 2017 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн 155,000 аж ахуйн нэгжийн 78,000 гаруй нь үйл ажиллагаа явуулж байгаагаас 60,000 гаруй нь ЖДҮ эрхлэгчид байна.

### 3.2.3.3. Барилгын салбар

НХБ-ын стратегийн 1 дэх зорилтыг хангахад *“ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлж, эдгээрийг дэмжих урамшуулал, хөнгөлөлтийн механизмыг хэрэгжүүлж, барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулахаар”* заасан (3.1.2).

Алсын хараа-2050-ны зорилт 6.4-д “Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах”-аар заасан. Зорилгыг хангахад “тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ”.

“150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд (2019.5.22) ирэх 5 жилд 10,000 нь инженерийн хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдох амины орон сууц, 45,000 нь гэр хорооллын газрыг дахин төлөвлөж барилгажуулах төслийн хүрээнд баригдах нийтийн зориулалттай орон сууц, 16,512 нь дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх төслүүдийн хүрээнд баригдах нийтийн зориулалттай болон амины орон сууцаар нэмэгдүүлэхээр төлөвлөгдсөн.

Хүн амыг орон сууцжуулах тухай Засгийн газрын 2013 оны 4-р сарын 13-ны өдрийн 135 дугаар тогтоолыг үндэслэн Засгийн газрын 2013 оны 200-р тогтоолоор “Орон сууцны 8 хувийн хүүтэй зээлийн журам”-ыг баталсан. Энэ журмыг 2019 онд “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам” нэртэйгээр шинэчлэн баталсан. Гэхдээ эдгээр зохицуулалтын акт ногоон барилга, байгууламжтай холбоогүй болно. Энэ салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 20 орчим хууль тогтоомж, 1000 орчим норматив баримт бичиг байдаг байна.

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага: Сүүлийн 20 жилийн дотор хот, суурин руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эрчимжсэнээс Улаанбаатар хот хурдацтай тэлж, олон талын, ялангуяа дэд бүтцийн хүндрэл бий болсон юм. Энэ чиг хандлага цаашид үргэлжлэх төлөвтэй байна. 2030 он гэхэд нийслэлийн хүн амын тоо 1.700.000-д хүрч, Монгол Улсын хүн амын 50.3% -ийг бүрдүүлнэ гэсэн таамаглал байдаг. Иймээс хотын олон талт асуудлыг шийдвэрлэхэд УИХ 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичиг чухал ач холбогдолтой байв. Энэ баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2020 онд дуусч байна. Иймээс Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна.

Дээрх төлөвлөөний тэргүүлэх чиглэл 4 нь эрчимтэй хөгжиж буй дагуул хот, тосгодтой *“хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд суурилсан хот”* байхаар тодорхойлсон. Үүнтэй холбоотойгоор шинэ нисэх буудлыг түшиглэсэн “Аэро сити”, “Зуунмод хот”, “Майдар хот” төслүүдийг хооронд нь уялдуулан төлөвлөж хөгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлогод заасан 2020 он гэхэд барилгын дулааны алдагдлыг 20 хувиар, 2030 он гэхэд 40 хувиар бууруулах, ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлэх зорилтыг тавьсан. 2014 онд Монголын ногоон барилгын хүрээлэнгээс Ногоон барилгын зэрэглэл тогтоох үнэлгээний системийн анхны төслийг боловсруулж байв. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний зохицуулах хороо болон Дэлхийн Банкны Олон Улсын санхүүгийн корпораци (ОУСК) хамтран ажиллах санамж бичигт 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр гарын үсэг зурсан. Талууд санамж бичгийн хүрээнд Монгол Улсад үндэсний хэмжээний ногоон барилгын үнэлгээний системийг бий болгох, хэрэгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.

Барилга салбар нь эдийн засгийн бусад салбартай холбоотой, үүгээрээ үйл ажиллагааг идэвхижүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлдэг, мөн хот, суурийн газрын хөгжилтэй нягт холбоотой онцлог салбар юм. Тиймээс барилга салбарт тулгардаг нэг бэрхшээл бол түүний салбар дундын шинж чанар, салбар хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалтын асуудал байдаг.

Төрийн орон сууцны корпораци (ТОСК) нь хүн амыг хямд өртөгтэй, чанартай орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлдэг.

2018 оны 4 сард Монгол Улсын Засгийн газар, АХБ-наас 50 сая ам долларын зээлийн гэрээг “Эдийн засгийн хүндрэлтэй үед чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж, 5 жилийн хугацаанд шинээр болон өргөтгөл хийгдэх сургууль, цэцэрлэгийн барилгыг ажлыг хэрэгжүүлэх зорилгоор хийсэн. Тухайлбал 600.000 ам. долларын тендерийн багцад цэцэрлэгийн загвар ногоон байр барихдаа хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байх “Ногоон барилга”-ын шийдлээр гүйцэтгэхээр төлөвлөн, энэ ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөжээ.

2014 онд БОАЖЯ “ногоон хотын шагнал” санаачилж байсан бөгөөд 2015 оноос бусад холбогдох талуудтай хамтран “Ногоон барилга” үзэсгэлэнг тогтмол зохион байгуулж байна. БОАЖЯ, Барилга, хот төлөвлөлтийн яам (БХБЯ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Канадын “Дэлхийн их сургуулийн үйлчилгээ” олон улсын байгууллагын “Юнитерра” хөтөлбөртэй хамтран барилгын салбарт ногоон барилгын стандарт, дүрмийг боловсруулах зорилгоор 2017 онд “Ногоон барилгын зөвлөл”-ийг байгуулсан. Монгол Улсад 2015 оноос хэрэгжиж буй “Юнитерра” хөтөлбөр нь ногоон барилгын салбар

ихээхэн хөгжиж буй Канад улсаас мэргэжилтэн авч ирж, Монголын инженер техникийн ажилтнуудыг сургах, туршлага солилцох чиглэлд үйл ажиллагаа явуулж ирсэн юм.

АХБ болон Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн санхүүжигдэн хэрэгжиж буй Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (АНУРР, 2019-2027)-ийн хүрээнд гэр хорооллын талбайг нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахуйц, нөөцийн хувьд үр ашигтай; нийтийн эдэлбэр зам талбай, нийтийн зориулалттай байгууламж бүхий холимог ашиглалттай; 70 орчим хувь нь халамжийн болон төлбөрийн чадварт нийцсэн орон сууцнаас бүрдэх орлогын түвшний хувьд холимог орон сууцны фонд бүхий эко-хороолол болгон дахин төлөвлөлтөөр хөгжүүлэх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) ОУСК-тай (Дэлхийн Банк Группын гишүүн) хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, ЖДҮ-дэд санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, ингэснээр ногоон барилгад оруулах хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих юм.

Монголд тогтвортой барилгын үзэл баримтлал харьцангуй шинэ хэвээр байгаа бөгөөд ногоон барилгыг төслүүд далайцтай хэрэгжихгүй байна. Учир нь архитектор, дизайнер, инженерүүд нь ногоон технологи, ногоон барилгын материалыг ашиглах талаар бэлтгэгдээгүй байдаг.

Чех улсын Пипл Ин Нийд ТББ (PIN)-с ШУТИС-ын Барилга Архитектурын Сургууль болон Брногийн их сургуультай Монголын барилга салбарын дээд боловсролын чанарыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

### Шигтгээ 3. ЕХ-ны СВИЧ Ази хөтөлбөрийн оруулж буй хувь нэмэр

2018 онд Европын комиссын ЕвроЭйд, АНУ-ын элчин сайдын яамнаас хамтран санхүүжүүлсэн Амьсгалах эрх (R2B) төслийг Пипл Ин Нийд ТББ (PIN)-с агаарын бохирдлын тухай мэдээллийн хүртээмжтэй системийг бүрдүүлж, агаарын бохирдлын талаар явуулж буй засгийн газрын үйл ажиллагааны ил тод хариуцлагатай байдлыг дээшлүүлэх зорилготой хэрэгжүүлсэн. Төслийн хэрэгжилтэд монголын ТББ байгууллагууд: Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Гэр хорооллын зураглал төв оролцсон байна.

Европын холбооны Свич Ази хөтөлбөр санхүүжилтээр хэрэгжиж буй "Дулаан шийдэл" төслийг Францын Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчин, эв нэгдлийн бүлгэм (GERES) байгууллага тэргүүлэн бусад хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамт 2018-2021 онд хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд монголд өргөн хэрэглэгдэх дулаалгын төрөл бүрийн материалаар байр сууцны дулаалга хийж, дулаалга хийх барилгачдыг сурган, өрхүүдийг ногоон зээлд хамрагдахад дэмжин, өөрсдийн бэлтгэсэн барилгачдыг ногоон зээлээр дамжуулж тухайн өрхүүдтэй холбож дулаалгын ажлыг хийж байна.

#### 3.2.3.4. Тогтвортой аялал жуулчлал

Монголын аялал жуулчлалын салбар жижиг боловч хурдацтай хөгжиж салбарын нэг юм. Монгол улсын хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагааг 1999 онд баталсан Аялал жуулчлалын хуулиар зохицуулж байна. Засгийн газар аялал жуулчлалыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах асар их боломжтой тэргүүлэх чиглэл гэж хүлээн зөвшөөрсөн. Иймээс аялал жуулчлалын салбарыг улсын төлөвлөлт, зохицуулалтад суурилан хөгжүүлэх зорилгоор "Монгол улсад аялал жуулчлалыг



хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл"-ийг (Засгийн газрын 167 тоот тогтоолоор) баталсан. Үүнээс хойш Японы засгийн газрын техникийн туслалцаатайгаар үндэсний аялал жуулчлалыг 2015 он хүртэл хугацаанд хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Эдгээр нь салбарын хууль эрх зүй, бодлогын хүрээг тодорхойлоход чухал алхамууд болж, Засгийн газар аялал жуулчлалыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах ихээхэн нөөц боломж бүхий тэргүүлэх чиглэл гэж хүлээн зөвшөөрснийг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд чадавхи, үйлчилгээг сайжруулах замаар нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих тогтвортой аялал жуулчлалын шинэ чиглэл хөгжиж эхэлж байна. Түүнчлэн аялал жуулчлалын гол чиглэлүүд улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад төвлөрдөг. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан, нүүдэлчдийн соёлыг дэлхий дахинаа харуулах аялал жуулчлалыг хөгжүүлэх үүднээс “Аялал жуулчлалыг 2016-2030 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг 2015 онд баталсан<sup>21</sup>. Хөтөлбөрт аялал жуулчлалыг Монгол орны байгаль, түүх, соёлын үнэт өв, нүүдэлчин ахуй, уламжлалт зан заншлыг тусгасан өөр өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаатайгаар бүсчлэн хөгжүүлэхээр заасан.

2017 онд аялал жуулчлалаас 1.2 тэрбум ам. долларын орлого орсон нь дотоодын нийт бүтээгдэхүүний 11.4 хувийг эзэлсэн байна. Гадаадын жуулчдын тоо 2018 онд 529 мянгад хүрсэн байна. “Алсын хараа-2050”, “Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2020-2024”-д тодорхой бүс нутгуудад “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл” хэрэгжүүлэх, “тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурлан, байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар хөгжүүлж”, “2025 он гэхэд гадаадын жуулчдын тоог 1 саяд хүргэх”-ээр заасан. Үүний зэрэгцээ ТХГН-ийн хамгаалалттай газар нутгийнхаа хэмжээг 2030 он гэхэд 30% хүртэл нэмэгдүүлэхээр зорьж байгаа юм (2020 оны байдлаар 19,8%-тай байна).

БОАЖЯ нь тусгай хамгаалалттай газар нутгийн талаархи хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, зохицуулж, тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн менежментийг сайжруулах, эко аялал жуулчлалыг сурталчлах арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тухайлбал:

- Хөтөлбөрт эко аялал жуулчлалыг хөгжүүлэх түшиц 5 газрыг дурдсан бөгөөд үүнээс Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар (БЦГ) болон Онон-Балжийн БЦГ тэргүүлэх ач холбогдолтой болно. Дээрх 2 ТХГН-т эко аялал жуулчлалыг хөгжүүлэн, эдийн засгийн хүртээмжтэй хөгжил, байгаль хамгааллын загвар болгох зорилгоор 38 сая ам.долларын зээлийн санхүүжилтийг Засгийн газар АХБ-аас авах гэрээ хийн, төслийг хэрэгжүүлж эхлээд байна<sup>22</sup>.
- БОАЖЯ, Дэлхийн тогтвортой аялал жуулчлалын зөвлөл (ДТАЖЗ) хамтран ДТАЖЗ-ийн Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар Монгол улсад аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх санамж бичигт 2019 оны 8 сард гарын үсэг зурав.
- Дэлхийн аялал жуулчлалын өдрөөр 2020 оны 9 сард БОАЖЯ-с "Аялал жуулчлал ба цахим хувьсал" уриан дор олон арга хэмжээ зохион байгуулжээ.

<sup>21</sup> Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, 2015.

<sup>22</sup> <https://montsame.mn/en/read/192775>



Давос хотноо зохион тогтмол байгуулагддаг Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт (ДЭЗЧУ) дээр "Монгол улс дэлхийн өрсөлдөх чадварын жагсаалтад даруй 9 дугаараар урагшилж 93-т бичигдэж ихээхэн ахиц гарсан ч бүс нутгийн хамгийн өрсөлдөх чадваргүй улс хэвээр байж, бизнесийн орчны үзүүлэлтээр (83-т), МХХТ-ийн бэлэн байдал (85-т), олон улсад нээлттэй байдал (128-т), байгаль орчны тогтвортой байдал (131-т), дэд бүтэц (111-т), байгалийн болон соёлын чиглэлээр илүү сайжрах шаардлагатай байгаа нь харагдаж байна"<sup>23</sup> гэж дүгнэжээ.

### 3.2.3.5. Ногоон худалдаа

Монгол улс олон улсын байгууллага, санаачлага, гэрээ хэлцэлд нэгдсэн:

- Олон улсын эдийн засгийн харилцааны хөтөлбөр;
- Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д нэгдсэн (1997);
- ЕХ-той түншлэлийн хамтын ажиллагааны гэрээ;<sup>24</sup>
- Худалдааны томоохон түншүүдтэй хийсэн хоёр талт худалдаа, хөрөнгө оруулалтын гэрээнүүд; болон
- Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа АПЕК (АРЕС),<sup>25</sup> Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг буюу АСЕАН (ASEAN),<sup>26</sup> Төв Азийн Бүс Нутгийн Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр буюу КАРЕК (CAREC)<sup>27,28</sup>, Их Түмэн санаачилга зэрэг бүс нутгийн санаачилгууд.

Монгол Улс нээлттэй худалдааг дэмжсэн, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон худалдааг чөлөөлөх (либералчлах) бодлого явуулж байна. Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр (GATS)-ийн хүрээнд бусад хамтын худалдааны гэрээ болон түншлэлийн хэлэлцээрүүдийг хийсэн. Тухайлбал АНУ болон Монголын Засгийн газрын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны гэрээ (2004), ЕХ-той Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр (2013), Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (2015), Монгол Улсын Засгийн газар Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг (2015), Монгол-Орос-Хятадын Эдийн засгийн коридорыг урагшлуулах механизм байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг (2015), Дэлхийн худалдааны байгууллагын Худалдааг

<sup>23</sup> WEF, Insight report. The Travel & Tourism Competitiveness Report 2019, Travel and Tourism at a Tipping Point, Geneva, 2019, p.30

<sup>24</sup> 2015 онд Европын Холбооны зах зээлд Монголоос гаргасан нийт бараа бүтээгдэхүүний 20%-д гаалийн татвар ногдуулаагүй нь тогтвортой хөгжил, сайн засаглалын тусгай урамшууллын хөнгөлөлтөд хамруулсантай (GSP+) холбоотой байв. ЕХ цаашид "Шинэ олон индикатив хөтөлбөр 2014-2020"-ийн хүрээнд ардчилсан тогтолцоог бататгах, тогтвортой хөгжил, эдийн засгийн төрөлжүүлэлтийг дэмжих үүднээс Монгол улсыг дэмжин ажиллах зорилготой байгаа аж. (Эх сурвалж: <https://eeas.europa.eu/delegations/mongolia/en/1548/Mongolia%20and%20the%20EU>)

<sup>25</sup> АПЕК-т оролцсоноор Монгол улс зах зээлээ тэлэх, урт хугацааны туршид эдийн засгаа тогтвортой хөгжүүлэхэд илүү боломжууд нээгдэх юм. АПЕК-ийн зарим ажлын бүлэг, тухайлбал Жижиг, дунд үйлдвэрийн ажлын хэсэг, Эрчим хүчний ажлын хэсэг, Аялал жуулчлалын ажлын хэсэг, Тээврийн ажлын хэсэг, Уул уурхайн ажлын хэсэг нь Монголд ихээхэн анхаарч байна.

<sup>26</sup> АСЕАН-тай аялал жуулчлал, соёлын солилцооны чиглэлээр хамтран ажиллах сонирхлоо Монголын тал илэрхийлсэн.

<sup>27</sup> Монгол улс бүр 2003 онд Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр буюу КАРЕК-т тус хөтөлбөр тээврийн корридорын сүлжээ бий болгох зорилтыг эхлүүлж байх үед нь элсэн орсон юм. КАРЕК-ийн худалдааны нэгдсэн хөтөлбөр 2030-ийн гишүүдээ дэлхийн эдийн засагт ойртон нэгдэх, тэдний өсөлтийн чадавхийг дээшлүүлж, бүс нутгийн хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмждэг.

<sup>28</sup> Нэмэлт мэдээллийг: НҮБХХ-ий Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО)-ын Олон улсын судалгааны төв (ОУСТ)-ийн <http://land-locked.org/c> авна уу.

хөнгөвчлөх хэлэлцээр (2016) зэрэг. 2017 оны байдлаар Монгол улс дэлхийн 25 улс оронтой давхар татварын гэрээ, хэлцлүүдийг байгуулаад байна.<sup>29</sup>

Худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотойгоор НХБ-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.2.4-т ногоон хөрөнгө оруулалт, 3.5-д олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээрт ногоон хөгжлийн зарчмыг тусган бага нүүрстөрөгч бүхий эрчим хүчний хэмнэлттэй технологийн худалдааг дэмжсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн, хэрэгжүүлж байгаа билээ.

Монгол Улсын “Алсын хараа-2050”-д боловсруулах аж үйлдвэрийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2025 онд 12%, 2030 онд 14,6%, 2050 он гэхэд 27,4%-д хүргэхээс заасан. Мөн “бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө”. Тогтвортой эдийн засгийн хөгжлийг хангах хүрээнд худалдаатай холбоотой нилээн хэдэн тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлэхээр заасан (4.5.2).

Түүнчлэн Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэхээр заасан.

2017 онд Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн II хуралдааны протокол” болон “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комиссын хамтын ажиллагааны ажлын хэсгийн 2017-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тус тус гарын үсэг зурсан. Дээрх баримт бичигт зам тээвэр, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн салбар хооронд хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, туршлага солилцох, дугуй ширээний уулзалт зохион байгуулах зэрэг ажлыг тусгасан байна.

Засгийн газар хөрш орнууд болон гол түнш орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэх, Монголын экспортын барааны экспортын зах зээлийг өргөжүүлэх, худалдааг хөнгөвчлөх бодлогыг баримталж байна. Энэ хүрээнд “Монгол экспорт” (2018-2022)-ийг баталж, Экспортыг дэмжих үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдаар ахлуулан байгуулсан. Худалдааны төлөөлөгчийн газруудыг түнш орнуудад нээж байна. Гол түншүүдтэй чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломжийн талаар ТЭЗҮ хийгддэг. Гадаад харилцааны яамны дэргэд “Технологи, инновацийн мэдээлэл, судалгааны зөвлөл” нь ЖДҮ-дэд шаардлагатай мэдээлэл, олон улсын сайн туршлага, гадаад зах зээлийн талаарх мэдээлэл, бараа бүтээгдэхүүн экспортлох боломжийн талаарх мэдээллийг бизнес эрхлэгчдэд түгээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

“Монгол экспорт” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Гадаад харилцааны яам (ГХЯ) Олон улсын худалдааны төв (ОУХТ)-тэй хамтран “Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураг” (ХХО33) боловсруулахаар ажиллаж байна.

<sup>29</sup> <https://lehmanlaw.mn/blog/mongolias-double-taxation-treaties/>

Ихэнх улс орнуудын адил худалдаа, худалдаатай холбоотой хууль эрх зүйн орчин нь олон салбарын хууль эрх зүйтэй холбоотой. Тухайлбал худалдааны салбарт Байгалийн нөөцийн төлбөрийн тухай хууль (2012), Чөлөөт худалдааны бүсийн тухай хууль (2015), Татварын ерөнхий хууль (2008), түүнчлэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015), Цөмийн энергийн тухай хууль (2009), Газрын тосны тухай хууль (2014), Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2006), Арбитрын тухай хууль (2017), Өрсөлдөөний тухай хууль (2010), Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003), Концессын тухай хууль (2010), Компанийн тухай хууль (2011), Хөрөнгө оруулалтын тухай хууль (2008), Хүнсний тухай хууль (2012), (импортын хүнсний бүтээгдэхүүний шошготой холбоотойгоор) болон экспортод холбогдох эрүүл ахуй, фитосанитарийн хяналт, шалгалтад тавигдах шаардлага, амьтан, ургамал, түүхий эд, тэдгээрийн гарал үүслийг улсын хилээр нэвтрүүлэх болон хорио цээрийн болон хяналт шалгалтын тухай хууль, тогтоомжууд хамааралтай болно.

Холбогдох зохицуулалтын талаар дор товч танилцуулав. Үүнд:

- Импорт, экспортын зохицуулалт, хүний эрүүл мэнд, амьтан, ургамлын хорио цээр, үндэсний аюулгүй байдал, олон төрлийн тусгай зөвшөөрөлтэй холбогдох Засгийн газрын тогтоол, зохицуулалтын актууд,
- Монгол Улсын Төв банк, Санхүүгийн зохицуулах хороо, Гаалийн ерөнхий газар болон холбогдох бусад агентлаг, байгууллагуудын гаргасан журам, дүрэм, нормууд,
- Тодорхой салбарын бараа бүтээгдэхүүнийг гаалийн татвар, нэмүү өртгийн албан татвараас татвараас чөлөөлөх жагсаалт, урамшууллын механизмүүд, зохицуулалтууд, жишээ нь Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам (ЗГ-ын 2017 оны 290 тогтоолоор батлагдсан);
- Импортын эсвэл экспортын бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирол, нийцэл, тэмдэг гэх мэт.

### 3.3. ТОГТВОРТОЙ ХУДАЛДАН АВАЛТ

НХБ-д ногоон худалдан авалтыг “эрчим хүч, байгалийн нөөц баялагийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт” гэж тодорхойлсон. НХБ-д 2020 онд засгийн газрын худалдан авалтын 20%, 2030 онд 30%-ийг ногоон худалдан авалт байх зорилт тавьсан. Мөн “Алсын хараа-2050”-д төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэхээр заасан.

Төрийн худалдан авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-иар (2005) зохицуулагдах бөгөөд энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Мөн улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашигтай захиран зарцуулалтыг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо болох “шилэн данс” нэвтрүүлж, нээлттэй болгосон нь чухал алхам болсон.

Дээрх хуулийн 2019 оны 3 сард батлагдсан нэмэлт өөрчлөлтөд ногоон худалдан авалт гэсэн ойлголтыг оруулж өгсөн нь ногоон үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүн худалдан авалтаар дэмжигдэх боломжийг бий болгов. Сангийн яам засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах, худалдан авалттай холбоотой эрх зүй, зохицуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хянана.

Сүүлийн жилүүдэд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авалт хийх үйл ажиллагааг цахимжуулж байгаа нь худалдан авалтын үйл ажиллагааг ногоон хөгжлийн зарчимд нийцүүлэхэд хийж буй томоохон алхам гэж үзэж болохоор байна. Худалдан авах ажиллагааг Ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан сайжруулах шаардлагаар Сангийн яам, БОАЖЯ нь НҮБ-ын Ногоон эдийн засгийн төлөөх түншлэлийн дэмжлэгтэйгээр Тогтвортой худалдан авалтын төсөл хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд Засгийн газрын худалдан авалтын үйл ажиллагааны өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, голлох бараа бүтээгдэхүүний судалгаа, мөн Засгийн газрын тогтвортой худалдан авалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулжээ. Энэ төлөвлөгөө батлагдаагүй юм.

ТӨБЗГ төрийн худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулах, цахим худалдан авах ажиллагааны системийг төрийн байгууллагуудын цахим системтэй холбох, худалдан авалтад цахим гарын үсэг нэвтрүүлэх, худалдан авалтын мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна<sup>30</sup>.

НХБ-д тусгагдсан ногоон худалдан авалтыг 20% хүргэх зорилтыг хэрэгжүүлэхэд тогтвортой буюу ногоон худалдан авалтын удирдамж эсвэл журам, үйлчилгээ болон бараа худалдан авах жижиг баримт бичигт ногоон бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлтийг тусгах, үүнтэй холбоотой дагаж мөрдөх баримт, эко-шошгожуулалт болон ногоон худалдан авалтын урамшууллын механизмыг бий болгох зэрэг ажлуудыг хийх шаардлагатай болж байна. Дээр нь худалдан авалтын мэргэжилтнүүдийг ногоон худалдан авалтад бэлтгэн сургах ажил зайлшгүй шаардлагатай.

### 3.4. НОГООН САНХҮҮЖИЛТ

Монгол улс тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг цогцлооход маш их хэмжээний хөрөнгө оруулалт буюу ногоон санхүүжилт шаардлагатай. Ногоон санхүүжилтийг хэрэгжүүлэх үйл явцад харин банкны салбарын санаачлага, үүрэг оролцоо хамгийн чухал болно. Монгол дахь ногоон санхүүжилтийн санаачилгуудаас зарим жишээг дор танилцуулж байна.

**Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)**-ийн хөтөлбөр: 2013 онд Монголын банкны холбоо (МБХ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Монголбанк, СЗХ, нийт банкуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдан банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд болон банкны харилцагчдын дунд тогтвортой санхүүжилтийн мэдлэг ойлголтыг гүнзгийрүүлэх, чадвар чадамжийг бий болгох зорилгоор ТоС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ. Энэ ажлын бүлэг ТоС-ийн зарчмууд болон 4 салбарын удирдамж /уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр/-ийг боловсруулах ажлыг ОУСК, НХБ-ны зөвлөхүүдийн

<sup>30</sup> Төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн систем <https://www.tender.gov.mn/mn/index/>; Төрийн худалдан авах ажиллагааны газрын вэб хуудас <http://www.spa.gov.mn/#gsc.tab=0>; Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын вэб хуудас [www.ub-procurement.mn](http://www.ub-procurement.mn)

тусламжтайгаар боловсруулсан байна. 2015 оны 1 сараас байгаль орчин, хүний эрх, соёлын өв, ногоон эдийн засаг, санхүүгийн хүртээмж, ил тод байдал зэрэг бидний тулгамдаж буй чухал асуудлуудыг тусгасан энэхүү зарчмуудыг банкууд үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн ба банкнаас санхүүжүүлж буй төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг тодорхойлж, бууруулах, цаашлаад ногоон төслүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд банкуудад дэмжлэг, чиглэл өгөх зорилготой. Монголын банкуудын энэ санаачилгыг олон улсын түншүүд сайн туршлага хэмээн хүлээн зөвшөөрч, туршлагыг Зүүн Өмнөд Азид улам дэлгэрүүлэх үйл явц улам нэмэгдэж байгаа юм.

**ТоС холбоо:** Дээрх хөтөлбөрийн хүрээнд Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо буюу "ТоС Холбоо"-г Монголын Банкны Холбооноос 2017 оны 12-р сард ГҮТББ-ын хэлбэрээр үүсгэн байгуулсан бөгөөд өнөөдөр Монголын банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх 13 банкийг нэгтгэн үйл ажиллагаагаа явуулж байна. ТоС Холбоо нь Монгол улсын санхүүгийн салбар болон бизнесийн байгууллагуудад байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой санхүүжилт, ногоон зээл, хөрөнгө оруулалтын дэд бүтэц бүрдүүлж, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжихийг зорьж ажилладаг.

**Монголын банкны холбоо (МБХ)** 2000 онд үүсгэн байгуулагдаж байсан МБХ нь ТоС Хөтөлбөрийн гол хэрэгжүүлэгч бөгөөд холбоонд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны 14 банк, гадаадын банкны төлөөлөгчийн газар болон бусад санхүүгийн байгууллагууд нэгджээ. Холбооноос гишүүн банкууд салбарын дүрэм, журам, зөвлөмж, стандартыг өөрсдийн санаачлагаар боловсруулж, банкны үйл ажиллагаандаа үе шаттайгаар, нэгдсэн байдлаар нэвтрүүлдэг байна. Үүнд жишээлбэл:

1. Банкуудын ёс зүйн дүрэм
2. Банкинд комплаенсийн бодлого нэвтрүүлэх, чиг үүрэг тодорхойлох үлгэрчилсэн заавар
3. Тогтвортой санхүүжилтийн зарчмууд болон дөрвөн салбарын удирдамж
4. Банкны зээлийн болон эрсдэлийн ажилтнуудад зориулсан Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцох гарын авлага
5. Нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлийн гарын авлага зэрэг

**Монголын Тогтвортой эрчим хүчний санхүүжилтийн үйлчилгээ** (МонТЭХСҮ буюу MonSEFF)-г Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас нийт 25 сая ам.доллараар санхүүжүүлж байгаа ба МонТЭХСҮ нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын тулд эрчим хүчний хэрэглээгээ багасгах болон сэргээгдэх эрчим хүчийг ашиглахаар зорьж байгаа байгууллагуудад Монголын банкуудаар дамжуулан боломжит нөхцлөөр санхүүжилт олгох зорилготой. Зээл нь төслийн өртгийн 100% хүртэлх хэмжээтэй үндэсний мөнгөн тэмдэгтээр олгогдох ба зээлийн санхүүжилтийн дээд хэмжээ нь 2.5 сая ам.доллар байна. Зээлийн санхүүжилтийн доод хэмжээг харилцагч банкнаас тогтоодог байна. Зээлийн нөхцлийг харилцагч банктэй тохиролцох ба ойролцоогоор сарын 1.4-1.5%, жилийн 16%-18% хүүтэй байх боломжтой.<sup>31</sup>

**Монголын ногоон санхүүгийн корпораци (МНСК):** Хувийн хэвшил, олон улсын хөрөнгө оруулагчдын оролцоог хангасан үндэсний санхүүгийн тогтвортой механизм бий болгох

<sup>31</sup> GGGI (2016). Mongolian Green Credit Fund Concept Note.



зорилгоор Монголын ногоон санхүүгийн корпораци (МНСК)-ийг байгуулах бэлтгэл ажлыг Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Байгууллага (GGGI), Уур амьсгалын Ногоон сан (УАНС), МУ-ын Засгийн газар, ТоС хөтөлбөртэй хамтран 2017 онд эхлүүлсэн. МНСК-г байгуулснаар бага хүүтэй арилжааны санхүүжилтыг олон улсын зах зээлээс татан төвлөрүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой болно. МНСК-г байгуулах үйл явц үргэжилж байна.

**“Тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зураг”** баримт бичгийг НҮББОХ, ОУСК болон Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (МТСХ)<sup>32</sup> хамтран боловсруулсан байна. Замын зургийн үндсэн гол зорилго нь Монгол улсад 2030 он гэхэд үндэсний тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон уур амьсгалын зорилтуудтай нийцсэн тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох, хөгжүүлэх үйл явцыг түргэтгэхэд чиглэсэн олон талт, нэгдсэн зохион байгуулалттай, ерөнхий стратеги төлөвлөгөөг боловсруулан бүх оролцогч талуудаар хүлээн зөвшөөрүүлэх явдал юм.

**Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр:** УАНС-аас уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулахад чиглэсэн Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийг (SAP004, 2018-2028) хэрэгжүүлж байна. Энэ нь Монголд улсад анх удаа хэрэгжүүлж буй эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаалтын зээлийн хөтөлбөр бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй байр сууцны зээлийн хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй хэрэгжүүлэх хөтөлбөр болно. Хөтөлбөрийг магадлан итгэмжлэгдсэн хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд Хас банкны өмнөх ижил төстэй ажлын туршлагыг харгалзан сонгосон байна.

Хас банк ногоон бизнесийг дэмждэг тэргүүлэх арилжааны банкнуудын нэг юм. Дээрх Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөрийн хүрээнд энэ банк дараах 2 төрлийн ногоон зээлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнд:

**Тогтвортой банкны үйл ажиллагаа болон Ногоон таксономи:** Ногоон санхүүжилтийн манлайллын хөтөлбөрийн хүрээнд Ногоон таксоном боловсруулах ажлын бүлэг олон улсын сайн туршлагад түшиглэн Ногоон таксономи буюу ногоон ангилал, шалгуурыг боловсруулсан. Энэ нь хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, хөрөнгө оруулалт оруулах төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах юм. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2019 оны 12 сард Монгол Улсад мөрдөгдөх "Ногоон таксономи"-г баталсан. Ногоон таксономи батлагдсантай холбогдуулан Монголбанк ногоон зээлийн статистик мэдээллийг банкуудаас авч нэгтгэн, олон нийтэд ил тод зарладаг болж байна<sup>33</sup>.

**Ногоон зээл:** “Ногоон зээл”-ийн гэрээг БОАЖЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо арилжааны гурван банкттай 2019 оны 8 сарын 15-нд байгуулсан. Нийт 3 тэрбум төгрөгийн дүнтэй гэрээний дагуу иргэн Төрийн банк, Хас, Хаан банкнуудаас сарын 0.7 хувийн хүүтэй, 40 хүртэл сая төгрөгийн зээл авах боломжтой. Зээлийг зөвхөн иргэнд олгох бөгөөд зээлээр авах бүтээгдэхүүн нь халаагуур, гэр, байшингийн дулаалга, эко жорлон байхаар заажээ.

<sup>32</sup> <https://unepinquiry.org/publication/national-sustainable-finance-roadmap-of-mongolia/>

<sup>33</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=21> болон <https://www.sustainablebankingnetwork.org/article/195.html-c> авна уу.



## 4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗУРАГЛАЛ

Оролцогч талуудын дүн шинжилгээ ба оролцогчдын зураглалыг гаргахад ГОУХАН-ийн Saracity WORKS (CW) арга хэрэгслийг ашиглав. Хэвлэгдсэн тайлан, бүтээлүүдэд дүн шинжилгээ хийн, холбогдох байгууллагууд, хүмүүстэй уулзалт, ярилцлага хийж, холбогдох талууд болон бизнесийн төлөөлөгчид оролцсон техникийн зөвлөгөөний үеэр хийсэн судалгааны үр дүнг ашиглав.

2018 оны 8 сарын 24-нд Улаанбаатар хотноо болсон СВИЧ Ази хөтөлбөрийн ТХҮ-ийн газрын олон талын зөвлөлдөх уулзалтын үеэр төслийн багийн ахлагч Др. Хобаллах хэлэхдээ “*өөрчлөлтийг зохих түвшинд түншлэлийн замаар бий болгох хэрэгтэй бөгөөд энэ боломжийг ашиглахын тулд үйлдвэрлэгч төдийгүй хэрэглэгч дундаас тэрхүү хөдөлгөгч “хүчийг” сонгон олж чиглүүлэх, үүний сацуу хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн институц болон зах зээлийг дэмжих шаардлагатай. Шинээр эхлүүлж буй үйл явц тул үр дүнтэй нутагшуулахын тулд ТҮХ-г хөгжлийн бодлогодоо бүрэн тусгасан байх ёстой*”<sup>34</sup> гэжээ. Тэрээр мөн “*ногоон үйлдвэрлэлийг санхүүжүүлэхэд банк санхүүгийн байгууллага, олон нийтийн ойлголт, ногоон хөгжлийг дэмжсэн олон дадлыг бий болгоход хэвлэл мэдээллийн байгууллага, хүүхэд залууст мэдлэг мэдээлэл өгөхөд боловсролын салбарын оролцоо чухал*” болохыг зөвлөсөн юм<sup>35</sup>.

Үүнээс үзвэл ТҮХ-г хэрэгжүүлэхэд оролцогч талууд гэдэг нь ТХЗ 12, НХБ хэрэгжүүлэхэд бодлогын баримт бичгүүдэд заасан, зайлшгүй оролцох ёстой салбаруудын төлөөлөл юм. Эдгээр салбаруудыг төлөөлөх байгууллага, бүлэг хүнийг бүлэглэн стратегийн 6 оролцогч тал болгон хувааж, дараах байдлаар тодорхойлж байна. Эдгээр талууд нь дотроо дэд бүлэгт хуваагдана.

### 4.1. Гол оролцогч талууд

#### 4.1.1. Шийдвэр гаргагчид

ТҮХ-г талаар бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нөлөөлөх байдлаар нь дээд шатны байгууллага, тэргүүлэн хэрэгжүүлэгч болон чиглэлийн яамдыг 3 дэд бүлэгт хувааж байна.

- 1) **ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГА** нь хууль баталдаг Улсын их хурал буюу санхүү, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороодын ажлын албад болно.
- 2) **БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ (БОАЖЯ)** нь Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг тэргүүлэн хэрэгжүүлдэг яам бөгөөд ТҮХ-г хэрэгжүүлэх зорилгоор үндэсний эрх зүйн баримт бичиг батлан, салбар хоорондын зохицуулалтыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлж, хэрэгжилтийг хянадаг төрийн захиргааны төв байгууллага юм (**Хүснэгт 4**-г харна уу).

Энэ дэд бүлэгт мөн **СВИЧ Ази хөтөлбөрийн үндэсний зохицуулагч** бөгөөд БОАЖЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Т.Булган, дээрх хөтөлбөрийн **ТХҮ-ийн үндэсний зохицуулагч** бөгөөд Цэвэр технологи,

<sup>34</sup> <https://www.switch-asia.eu/news/switch-asia-scp-facility-multistakeholder-consultations-on-sustainable-consumption-and-production-hi/?cHash=ce201f154e502c05562427d9a0da4f24&L=0>

<sup>35</sup> <https://montsame.mn/mn/read/98673>

хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлстийн дарга Ц.Уранчимэ нар нь уг хөтөлбөрийн хүрээнд ТҮХ-г монголд үндэсний онцлогт нийцүүлэн нутагшуулахад үндэсний хууль, зохицуулалтын эрх зүйн баримт бичиг боловсруулах, хуулийн хэрэгжүүлэлт, техникийн нөхцлийн талаар мэдээлэлтэй, бусад салбаруудтай уялдуудах, **ЗОХИЦУУЛАХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГДӨГ БҮЛЭГ** юм. Магадгүй энэ үүргийнхээ хүрээнд техникийн зөвлөгөө өгөх, олон салбарын оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсэг ч байгуулж болох юм.

#### Хүснэгт 4: НХБ-ыг хэрэгжүүлэх арга хэмжээ

	Яамдын нэр	Толгойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо
1	<b>БОАЖЯ</b>	46	165
2	ГХЯ	-	6
3	СЯ	9	44
4	ХЗДХЯ	1	2
5	БХБЯ	13	32
6	БСШУСЯ	16	59
7	ЗТХЯ	10	42
8	УУХҮЯ	11	26
9	ХНХЯ	6	27
10	ХХААХҮЯ	13	1
11	ЭХЯ	2	7
12	ЭМЯ	24	50
13	ҮХГ	13	26
14	АНЗД	-	7
15	Аймгуудын удирдлага, хотын захирагч нар	9	77

#### 3) Чиглэлийн яамд:

- a) Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) нь нилээн хэдэн салбарыг хамарсан “Малын эрүүл мэнд” хөтөлбөр, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөр, “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр, “Ноолуур” үндэсний хөтөлбөр зэргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр хөтөлбөр нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг дэмжихэд чухал ач холбогдолтой.
- b) Барилга, хот төлөвлөлтийн яам (БХТЯ) нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хурдацтай уялдан барилга, хот байгуулалт, газар болон геодези, зураг зүйн тухай хууль, тогтоомжуудыг нийгмийн бодит хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгохын зэрэгцээ хот суурин газрын хүн амын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, агаарын бохирдлыг арилгах үйлчилгээ үзүүлж, бусад бодлогын яамд, агентлаг, орон нутгийн удирдлагатай хамтран ажилладаг.
- c) Сангийн яам (СЯ) нь улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, стратегитай уялдуулсан санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах, гадаадын санхүүжилттэй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулалтаар хангах, боловсронгуй болгох, хэрэгжилтэд нэгдсэн хяналт тавих, гадаад, дотоод

өрийн удирдлагыг бэхжүүлэх болон Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлого, удирдлага, хяналт зохицуулалтыг сайжруулах зэрэг үйл ажиллагааг явуулж, салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, түүний үр дүнг хянах үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага болно.

d) Бусад чиглэлийн яамд, тухайлбал Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ), Эрүүл мэндийн яам (ЭМЯ), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ыг нэг дэд бүлэгт оруулж байна:

- ЭЗХЯ нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны оновчтой бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар хүн амын амьжиргааны түвшинг тогтвортой дээшлүүлэх зорилготой. Мөн аж үйлдвэрийн инноваци, технологийн шинэтгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үүргийг хүлээсэн.
- ЭМЯ нь тэргүүлэх чиглэлээ “Монгол хүний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтвортой хөгжлийн зорилт, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийг хангах” гэж тодорхойлжээ. Тус яам эм, үйлдвэрлэл, эрүүл мэндийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал, орчны эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хүн амд эрүүл мэндийн боловсролыг төлөвшүүлэх, эрүүл зан үйл, аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулдаг.
- ХНХЯ нь ТХЗ 12-ийн хэрэгжилтийн үзүүлэлтийг бодлогын түвшинд хариуцахгүй ч 12-той шууд холбогдох 10, 11 болон 5-р зорилтыг хэрэгжүүлэх, ялангуяа жендерийн тэгш байдал, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх, эрх тэгш байдлыг цогцлоох, хангах, эдгээртэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 4.1.2. Холбогдох төрийн байгууллагууд

- 1) **АГЕНТЛАГУУД:** Засгийн газрын 2019 оны 438 дугаар тогтоолын дагуу 2020 оны 2 сараас эхлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас худалдан авах ажиллагааны хэлтсийн чиг үүргийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Ингэснээр ТХҮ-ийн үндсэн чиглэл болох төрийн худалдан авахтай холбоотой бүхий л чиг үүрэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газарт төвлөрч байна. ТХҮ-ийг нутагшуулахад Үндэсний хөгжлийн газар (ҮХГ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ), Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ), болон бусад төрийн агентлагууд чухал оролцоотой. Тухайлбал Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) үндэсний стандартуудыг батлах, хэвлэн нийтлэх болон олон улсын стандарчиллын байгууллага (ОУСБ буюу ISO)-д, бусад олон улсын стандартчиллын бүх байгууллагад Монгол улсыг төлөөлдөг. Энэ утгаараа СХЗГ нь үндэсний эко шошгыг бий болгоход гол үүргийг гүйцэтгэнэ.
- 2) Энэ дэд бүлэгт **ОРОН НУТАГТ ШИЙДВЭР ГАРГАГЧИД** буюу аймгуудын Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн алба зэрэг байгууллагуудыг оруулж байна.

### 4.1.3. Хувийн хэвшлийн салбар

Энэ бүлэгт тухайлбал барилга, нэхмэл, гоо сайхны, арьс шир үйлдвэрлэлийн, аялал жуулчлалын зэрэг тогтвортой үйлдвэрлэлийг сонирхогч, хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн ААНБ, гадаадын бизнесийн байгууллагатай хамтарсан дотоодын компани зэрэг байгууллагууд орно. Монголын ААНБ-ын 90-д хувийг жижиг, дунд аж ахуйн нэгж (ЖДҮ) гэж үздэг.

**Бизнесийн салбар:** ТХҮ нь нөөц ба эрчим хүчний үр ашиг, тогтвортой дэд бүтцийг бий болгох, хүн бүр хэрэгцээт үйлчилгээ авах боломжтой байх, ногоон ажлын байрыг бий болгож, бүх хүмүүсийн амьдралын чанарыг дээшлүүлэх тухай юм. Иймээс ТХЗ 12 ба НХБ-д тусгагдсан стратегийн салбарууд нь үндсэндээ түүхий эд боловсруулах үйлдвэрүүд байдаг бөгөөд эдгээр нь байгаль орчинд хамгийн их нөлөө үзүүлэхийн сацуу экспортод чиглэсэн аж үйлдвэрийн боловсруулах кластерууд юм. Эдгээр салбарууд нь өргөн хэрэглээний бараа, хэрэглээний үйлчилгээтэй илүү холбоотой.

**Нэмүү өртгийн сүлжээ:** Зарим бизнесийн салбарууд хэрэглэгчийн үйлчилгээний салбартай холбогдсон байдаг. Өөрөөр хэлбэл түүхий эд ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг бий болгохын тулд үр ашигтай ажиллаж нэмүү өртгийг бий болгож, баялаш бүтээж байгаа л бол тэр бизнес гинжин сүлжээний нэг хэсэг холбоос юм. Жишээлбэл, өргөн хэрэглээний бараа болох хувцас үйлдвэрлэхэд ноос, ноолуур, арьс шир зэрэг түүхий эд материалд тулгуурладаг бөгөөд үндсэн үндсэн үйлдвэрлэлээс гадна бүтээгдэхүүний сав баглаа боодол үйлдвэрлэдэг үйлдвэрлэл хүртэл энэ сүлжээнд холбогдоно. ТХЗ 12 ба ТХҮ-ийн үндсэн сэдвийн нэг бол нийт амьдралын мөчлөгийн хугацааны туршид хог хаягдлыг бууруулах, менежментийн асуудал байдаг бөгөөд үүнийг ч мөн Монголын үндэсний хөгжлийн бодлогод сайн суулгаж өгсөн байна.

Нэгтгэвэл, ТХЗ 12-ийн хүрээнд дараах бизнесийн салбаруудыг үндэсний бодлогын хүрээнд тэргүүлэх чиглэлийн салбарууд гэж тодорхойлсон бөгөөд эдгээрийг өмнөх бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан билээ ([3.2.3](#)-г харна уу):

- Хүнс, хөдөө аж ахуй,
- Барилгын салбар,
- Тогтвортой аялал жуулчлал,
- Арьс шир, ноолуурын зэрэг боловсруулах үйлдвэр, түүнчлэн
- Бүх салбарыг хамарсан хог хаягдлын менежмент.

### 4.1.4. Сургалт, судалгааны байгууллагууд

Сургалт, судалгааны байгууллагуудыг дараах дэд бүлэгт хувааж байна. Үүнд

- 1) **СУРГАЛТ-СУДАЛГААНЫ БАЙГУУЛЛАГАД** зөвхөн судалгаа хийдэг, тухайлбал ШУА-ийн хүрээлэнгүүд, сургалт болон судалгааг хослон явуулдаг их дээд сургуулиуд орно.
- 2) **СУДАЛГАА-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГА** гэдэгт нь хажуудаа гарааны компанитай сургалт-судалгааны байгууллагууд орох ба эдгээр нь “*инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан, зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлж эхлээгүй байгаа компани*”<sup>36</sup> байдаг учир цэвэр бизнесийн байгууллагад тооцох боломжгүй байгууллагууд юм.

<sup>36</sup> Инновацийн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 заалт.

2000 оны эхэн үеэс Монгол улс албан ба албан бус боловсролын салбарт Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын чиглэлээр нилээн хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлж ирсэн. БОАЖЯ-аас санаачилсан Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний хөтөлбөрийг (ТХБ) 2018 онд Засгийн газар баталсан. Хөтөлбөр нь байгаль хамгаалах, уламжлал соёлдоо хүндэтгэлтэй хандах, уламжлал, зан үйлээ хадгалах, бүх нийтийн байгальд ээлтэй хандлага, дадлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Суурь боловсролын хөтөлбөрт ТХБ-ыг суулгах, сургуулиуд ТХБ-ыг эко-клубээр дамжуулан хэрэгжүүлэх санаачлага, хөдөлгөөн өргөн өрнөж байгаа ч дээд боловсролын хөтөлбөрт системтэйгээр суулгах, бэлтгэгдэж буй боловсон хүчин ТХБ-ын мэдлэг, ойлголтгүй, амьдралдаа хэвшүүлж, ашигласан зүйлгүй төгсч гарч байна. Иймээс ТХУ асуудлыг ТХБ-оор дамжуулан сургалтын хөтөлбөрт суулгах нь ногоон хөгжлийг цогцлоох хойч үеэ бэлдэнэ гэсэн үг юм.

Эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн сургууль, гарааны бизнес нь эдийн засаг, үйлдвэрлэлийн олон салбарт шинжлэх ухааны инноваци, технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд түүчээлэх хүч болно.

#### 4.1.5. Сонирхогч бүлэг

Энэ бүлгийг иргэний нийгмийн байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөлөл гэсэн дэд бүлэгт хувааж байна. Дэд бүлгүүд хоёулаа бодлого боловсруулахад оролцох, ТХУ-ийн талаархи мэдлэг, мэдээллийг түгээхэд чухал үүрэгтэй.

1) **ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД (ИНБ) БОЛОН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООД:** Эхний дэд бүлэгт тогтвортой үйлдвэрлэл, үйлчилгээ болон нэмүү өртгийн сүлжээнд оролцогч, дэмжигч мэргэжлийн холбоод<sup>37</sup>, ижил төстөй байгууллагууд болон ТББ-ыг оруулж байна. ИНБ гэдгийг мэргэжлийн холбоод, ТББ, олон нийтийн бүлгүүд, улс төрийн хөдөлгөөн, сонирхогч бүлгүүд гэж ойлгоно. Монголд барууны загварын иргэний нийгмийн байгууллагын уламжлал байхгүй. Мэргэжлийн холбоодод нь ТББ-уудын тухай хууль (1997)-ийн зохицуулалтын хүрээнд хуулийн этгээдээр бүртгүүлэн, байгууллагын хувьд санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй ба ажилтан ажиллуулах, үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээнд явуулах эрхтэй. Тухайлбал үндэсний түвшинд ажилладаг Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо, Барилгын нэгдсэн холбоо, Монголын барилгын материал үйлвэрлэгчдийн холбоо, Монголын ноос, ноолуурын холбоо, Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын аялал жуулчлалын холбоо, Монголын сав, баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо зэрэг мэргэжлийн холбоо байж болно. Тухайлбал ТББ байгууллагын статустай Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим (МХАҮТ)<sup>38</sup> бизнесийн олон салбарын төлөөлөл бүхий олон 3500 гаруй гишүүдтэй, гишүүд, бизнес эрхлэгчид, түншлэгч байгууллагуудыг мэдлэг, мэдээллээр хангадаг. Энэ байгууллага СВИЧ Ази хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Монголд анх хэрэгжүүлсэн “Ногоон бүтээгдэхүүн ба эко шошго” төслийг 2009-2012 онд хамтран хэрэгжүүлсэн байдаг. Монголын банкны холбоо (МБХ) Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх, ногоон санхүүжилтийг дэмжих зорилгоор МТСХ ТББ-г 2017 онд санаачлан байгуулсан<sup>39</sup> бөгөөд СВИЧ Ази хөтөлбөрийн санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжих “Монголын Нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг” /STePEcoLab/

<sup>37</sup> Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо нь монголын хоршоодын 5 холбоодын дээвэр холбоо болно.

<sup>38</sup> <https://www.mongolchamber.mn/mn/>

<sup>39</sup> <http://www.toc.mn/>

төслийг бусад түншийн хамт 2018 оны 5 дугаар сараас хэрэгжүүлж эхлээд байна (3.4-г харна уу).

- 2) **Хэвлэл, мэдээллийн салбар:** Дараагийн дэд бүлэг нь олон нийтэд тогтвортой бөгөөд ногоон хөгжил, ТҮХ-ийн талаарх мэдээллийг түгээх хэвлэл мэдээллийн ажилтнууд, байгууллагууд орно. БОАЖЯ-ны санаачлага, Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн (2015-2018)<sup>40</sup> дэмжлэгтэйгээр нийгэмд тогтвортой бөгөөд ногоон хөгжлийн талаар мэдээлэл түгээх зорилгоор тогтвортой бөгөөд ногоон хөгжлийг сурвалжлахуй гарын авлага боловсруулан, монголын хэмжээнд 360 гаруй сэтгүүлчдийг багц сургалтанд хамруулсан нь өнөөдөр хэвлэл мэдээллийн сувгаар тогтвортой хөгжил, ногоон хөгжил, болон тогтвортой хөгжлийн боловсролын талаарх мэдээлэл нийгэмд жигд хүрч, олон нийт мэдээлэл, ойлголттой болоход нь ихээхэн түлхэц болсон юм. Иймээс эдгээр сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудаар дамжуулан ТҮХ-г сурталчлан таниулах бүрэн боломжтой.

#### 4.1.6. Хэрэглэгчид

Энэ бүлэг хэрэглэгч байхаас гадна өөрсдөө бизнесийн үйл ажиллагаанд оролцогч байх боломжтой.

**Хэрэглэгчид:** Хэрэглэгчдийн худалдан авалтын хэмжээ 2019 оны 3-р улиралд 3080392.70 сая төгрөг байсан бол 4-р улиралд 3179374.20 сая төгрөг болж өссөн байна<sup>41</sup>. Дараах диаграммаас харахад сүүлийн жилүүдэд хэрэглэгчдийн худалдан авалт эрс өссөн байна (**Зураг 4**-г харна уу).

Хүн амын 63.77% нь 35-аас<sup>42</sup> доош насны залуучууд байдаг (нийт хүн амын дөрөвний нэгээс илүү нь 15-аас доош насных байдаг); нийт хүн амын 67.87% нь Улаанбаатар болон бусад томоохон хотуудад амьдардаг; иргэд, тэр дундаа малчид хүртэл гар утас ашигладаг (2018 онд нийт иргэдийн 99.6% нь гар утастай); 1.7 сая буюу хүн амын 79% ухаалаг гар утас ашигладаг; ТВ-ийн зар сурталчилгаа, мобайл маркетинг, нийгмийн сурталчилгаа (фэйсбүүк, инстаграмаар дамжуулан) болон дотоод, гадаадын сурталчилгааны маркетинг сүүлийн арван жилд эрчимтэй хөгжсөн зэрэг монголын хэрэглэгчдийн онцлог талууд байдаг.

<sup>40</sup> ТХБ төслийг Монгол Улсын Засгийн газар, Швейцарийн Хөгжлийн Агентлагтай (ШХА) хамтран санхүүжүүлж, ГОУХАН-ийн Олон улсын үйлчилгээний газар, Шведийн Упсалагийн Их сургууль болон Швейцарийн Олон улсын боловсролын хамтын ажиллагааны хүрээлэн хамтран түншлэлээр хэрэгжүүлжээ.


<sup>41</sup> <https://tradingeconomics.com/mongolia/consumer-spending>

<sup>42</sup> Эх сурвалж: 1212.mn



## Зураг 4. Хэрэглэгчдийн худалдан авалт

(2017.1 сараас 2020.1 сар хүртэл, сая төг.)



Эх сурвалж: *Tradingeconomics.com*, Үндэсний статистикийн хороо

Компаниуд бизнесийн хуулиар "Үйлчлүүлэгч бол хаан" гэсэн уриатай ажилладаг. Гэхдээ хэрэглэгчдийн хувьд Монголын зах зээл маш эрсдэлтэй гэж үздэг. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь "өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах" төрийн захиргааны байгууллага юм<sup>43</sup>.

Засгийн газрын 2020 оны 2-р сарын 12-ны өдрийн 62 дугаартай тогтоолтой холбоотойгоор шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдал зарласан ба энэ хугацаанд зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх, хуурамч сурталчилгаа явуулахгүй, бараа бүтээгдэхүүнийг хэт нөөцлөхгүй байх зэргийг иргэдэд анхааруулж, холбогдох байгууллагуудыг хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон.

2020 оны 3 сарын 15-с эхлэн ШӨХТГ-аас хэрэглэгчдэд илүү хүрч ажиллах үүднээс "Хэрэглэгчийн утас-115" төлбөргүй ярианы дугаарыг өнөөдрөөс албан ёсоор ажиллуулж эхэлсэн. Үүнээс хойш 1600 гаруй гомдол ТӨБЗГ-с хэрэглэгчдийн гомдлыг шийдвэрлэж ажиллаж байна<sup>44</sup>. ТӨБЗГ харьцангуй цөөн тооны ажиллагсадтай бөгөөд хэрэглэгчийн эрхийг өргөн хүрээнд хамгаалан ажиллахад хүчин чадал хүрэлцэхгүй. Иймээс МХЕГ, СХЗГ зэрэг бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай. Дээр нь хэрэглэгчийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх мэдээлэл-сурталчилгааны хэрэгцээ маш их байна.


**Төр-хэрэглэгч:** Монголд улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд (2019.11.3) Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ 2020-2022 онд жил бүр 6 хувиар, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2020 онд 11.7 тэрбум, 2021 онд 12.8 тэрбум, 2022 онд 13.7 тэрбум байхаар төсөөлжээ. Өнгөрсөн онд (2019) төсвийн 38.6%-ийг худалдаг авах ажиллагаанд төсөвлөсөн (Зураг 5-г харна уу). Тайлангийн

<sup>43</sup> UNCTAD/DITC/CLP/2012/2, Voluntary Peer Review of Competition Law and Policy: Mongolia: Full Report, линк: <https://unctad.org/en/pages/PublicationWebflyer.aspx?publicationid=275>

<sup>44</sup> Эх сурвалж: <http://www.afccp.gov.mn/>

3.3-д төрийн худалдан авах ажиллагааны талаарх хууль эрх зүйн орчныг, үүнд ТХА-г тусгасан байдлыг, танилцуулав. Жишээ болшон


**Зураг 5: 2019 оны төсвийн зардал ДНБ-т эзлэх хувь (төлөвлөснөөр)**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо  
Зургийг: Б.Эрдэнэчимээ

Сангийн яамнаас төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, ил тод байдлыг хангах зорилгоор “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ийг боловсруулан, “төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликейшнийг ажиллуулж эхэлсэн (Зураг 6-г харна уу).

**Зураг 6: “Төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликейшн болон “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”**






**ОРОН НУТАГ-ХЭРЭГЛЭГЧ:** Монгол улсын нутаг дэвсгэр гурван түвшний нэгжийн тогтолцоотой ба 1-р зэргийн 21 аймаг, нийслэл хот; аймгууд 330 сумдад (2-р зэрэг), сумд 1592 багт (3-р зэрэг) хуваагдана. Орон нутгийн төсөв Төсвийн тухай хууль, Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар зохицуулагдана.


Орон нутгийн төсөв нь нийтлэг шинжээрээ улсын төсөвтэй төстэй боловч тухайн орон нутгийн онцлогоос шалтгаалан орон нутгийн бараа, үйлчилгээний эрэлт эрэлт хэрэгцээ, сонголт, орлогын бүрдүүлэлт, зарлага өөр өөр байна. Шилэн дансны тухай хууль ([Зураг 7](#)-г харна уу), Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн орлого, эх үүсвэрийг төлөвлөх, тэдгээр сангаас доод шатны төсөвт олгох зэрэгтэй холбогдсон дагуу хариуцлагатай төсөвлөлт, иргэдийн оролцоотой хяналт шинжилгээний арга зүй, шилэн дансны порталын талаархи гарын авлагын баримт бичгүүдийг хэвлэн нийтэлж, хууль тогтоомж, орон нутгийн төсвийн зохицуулалтын талаархи нэмэлт, нарийвчилсан зохицуулалтыг боловсронгуй болгох

Орон нутгийн, ялангуяа уул уурхай ихтэй аймгийн, төсвийн ил тод, нээлттэй байдал сүүлийн жилүүдэд сайжирч байна төсвийн ил тод байдал, орлогын бүрдүүлэлтийн мэдээлэл, гүйцэтгэл болон хяналтын тайлан гаргах зэрэгт ахиц дэвшил гарч байна. Орон нутгийн хөрөнгөөр худалдан авалтын хэмжээ ч бага биш байдаг ([Зураг 8](#)-г харна уу).

**Зураг 7:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудас



**Зураг 8:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, 2019 он



Эх сурвалж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны тайлан, 2019 он

## 4.2. Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхол

**Оролцогч талуудын нөлөө:** ТҮХ-г хэрэгжүүлэхэд стратегийн оролцогч талуудын нөлөөлөл гэдэг нь үндсэндээ тэдний эрх зүйн чадамж хир вэ гэдгийг тодорхойлж буй хэрэг юм. Жишээлбэл, бодлогын шинэчлэл хийх нь улс төрийн хүсэл зориг, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч хориг тавих эрх бүхий тоглогчдын шийдвэрээс хамаардаг.

НХБ-ыг Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний түвшинд нутагшуулахад тэргүүлэн оролцох үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага болох БОАЖЯ нөлөөлөл “их”-тэй. Бусад яам, засгийн газрын агентлаг, албад нь ТҮХ-г хэрэгжүүлэхэд үндэсний бодлого, зохицуулалтад тодорхой үүрэг, чиглэлтэйгээр оролцоно.

Үндсэн хуулийн 58 дугаар зүйлийн 1-д “*Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн*” гэж заасан. Аймгийн Засаг даргыг үндсэндээ төвөөс удирдан чиглүүлж, томилох ба тэрээр орон нутгийн төсвийг захиран зарцуулах, хуваарилах эрхтэй. Орон нутгийн иргэдийн хурал нь тухайн нутгийн иргэдийн санал бодол, байр суурийг сонсож, ашиг сонирхлыг төлөөлөх үүрэгтэй. Энэ утгаар нь орон нутгийн удирдлага “дунд” зэргийн нөлөөтэй гэж үзэв.

Сургалт, судалгааны болон ААНБ бодлого боловсруулах, шийдвэр гаргахад нөлөө багатай. Мөн бусад оролцогч бусад талын нөлөөлөл багатай буюу байхгүй гэж болно.

**Оролцогч талуудын сонирхол:** Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхлыг мэдсэнээр тэдэнд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны стратегийг боловсруулах боломжтой болдог. Үндсэндээ ТХҮ-г нутагшуулах үйл явцад оролцох оролцоонд нь түшиглэн оролцогч талуудын нөлөөллийн түвшин, сонирхлыг [Хүснэгт 5](#)-т харуулав.

### Хүснэгт 5: Оролцогч талуудын нөлөөлөл, сонирхол

Оролцогч тал	Дэд бүлэг	Зорилго	Нөлөө	Сонирхол
1. Шийдвэр гаргагчид	1.1. Дээд шатны байгууллага	дээд шатны хууль тогтоогч бөгөөд хууль, үндэсний хөтөлбөр батлах	+2	дунд
	1.2. БОАЖЯ	хуулийг хэрэгжүүлэгч бөгөөд ТХҮ талаар хуулийн лобби хийх, шинэ хууль, дүрмийг боловсруулах, өргөн барих, хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг зохицуулах	+1	их
	1.2. Үндэсний зохицуулах бүлэг	өндөр түвшинд бодлогын зөвлөгөө өгөх, ТХҮ-ий арга хэмжээг зохицуулах, ТХҮ газартай нягт холбоотой ажиллах, гол оролцогч талуудыг холбох, гол оролцогч талын ажил, ахиц дэвшлийн талаарх мэдээлэл түгээх болон талуудын мэдээлэл солилцох платформ бий болгох	+1	их
	1.3. ХХААХҮЯ	Үндэсний хөтөлбөр, ТХҮ болон Тогтвортой аж үйлдвэрийн бодлоготой холбоотой мэдээлэл бүрдүүлэх, мэдээллээр хангах	+1	их
	1.3. БХТЯ	Барилга, хот байгуулалтын талаар шинээр батлагдсан хууль, тогтоомж, дүрэм, журмыг боловсруулж гаргах, мастер төлөвлөгөө, хот байгуулалтын төлөвлөгөөг батлах	+1	их
	1.3. ЭЗХЯ	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн	+1	их

		бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх; үйлдвэр, технологийн шинэчлэлийг дэмжин зохион байгуулах		
	1.3. ЭМЯ	Эм үйлдвэрлэлийн талаархи хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх; олон нийтэд мэдээлэл сурталчилгаанд оролцох	+1	дунд
	1.3. ХНХЯ	Жендэрийн тэгш байдал, ажлын байрны аюулгүй байдлын талаархи хууль тогтоомжийг боловсронгуй болгох	+1	дунд
	1.1. Дээд шатны байгууллага	дээд шатны хууль тогтоогч бөгөөд хууль, үндэсний хөтөлбөр батлах	+1	дунд
2. Төрийн холбогдох байгууллага	2.1. Агентлагууд болон бусад төрийн байгууллагууд	Хууль хэрэгжүүлэх болон салбарын ХШҮ-д болон техникийн комисст оролцох	0	дунд
	2.2. Орон нутгийн ЗДТГ	ТХҮ-г орон нутагт хэрэгжүүлэх, орон нутгийн ААНБ болон хэрэглэгчдийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангах	0	их- дунд
3. Бизнесийн байгууллагууд	тухайлбал барилга, нэхмэл, гоо сайхны, арьс шир үйлдвэрлэлийн, аялал жуулчлалын зэрэг тогтвортой үйлдвэрлэлийг сонирхогч, хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн ААНБ	Салбар, чиглэлээрээ БОМТ, үндэсний болон олон улсын стандартыг нэвтрүүлэх, эко шошго техникийн шаардлагыг шалгуур үзүүлэлтийн дагуу нэвтрүүлэх, ингэснээр бизнесийг үр ашгаа нэмэгдүүлэн КНХ-г хэрэгжүүлэх	-1	дунд-бага-бага
4. Сургалт, судалгааны байгууллагууд	4.1. Сургалт-судалгааны байгууллага	Судалгаа, шинжилгээ хийх, ногоон хөгжил, тогтвортой хөгжил, ТХҮ сэдвийг сургалтын хөтөлбөрт суулгах	-1	дунд-бага
	4.2. Судалгаа-үйлдвэрлэлийн байгууллага	Судалгааны үр дүнг бизнест нэвтрүүлэх зорилгоор ТХҮ-чиглэлээр үйлдвэрлэлийн судалгаа, инноваци бий болгох	-1	дунд-бага
5. Сонирхогч бүлэг	5.1. мэргэжлийн холбоо, түүнтэй төстөй байгууллагууд	Тогтвортой үйлдвэрлэл, үйлчилгээ, нэмүү өртгийн сүлжээг дэмжих	-2	их-дунд
	5.2. бусад ТББ	Байгалийн нөөцийн хамгаалалт, тогтвортой ашиглалтыг дэмжих	-2	дунд-бага
	5.3. Хэвлэл мэдээлэл	Олон нийтийн мэдлэг, хандлагыг сайжруулах	-2	бага
	5.4. Хэрэглэгчид, олон нийт	Боломжийн үнэтэй, эрүүл бүтээгдэхүүн, үйлчилгээг сонирхох	-2	бага

Тайлбар:

Нөлөөллийн зэрэг: +2 маш нөлөөтэй, тухайлбал хориг тавих эрх бүхий гол оролцогч талууд; +1 нөлөөтэй, тухайлбал тухайн оролцогч тал тодорхой үйл явцыг дэмжих, хурдасгах, саад болох, зогсоох нөлөөтэй; 0 зарим салбарт нөлөө бүхий; -1 бага нөлөөтэй, -2 маш бага буюу нөлөөгүй: тухайлбал ТХҮ-г хэрэгжүүлэх үйл явцад нөлөөгүй.

Сонирхлын түвшин: их – тухайлбал оролцогч тал ТХҮ-с маш их хүлээлттэй, сонирхолтой оролцоно; дунд – тухайлбал оролцогч тал сонирхолтой боловч мэдлэггүйгээс, хууль эрх зүй, зохицуулалтад эргэлзэх; бага – тухайлбал мэдлэг, ойлголтгүйгээс оролцох сонирхолгүй.



### 4.3. Оролцогч талуудын мэдлэг

Дээр дурдсанчлан, ТХҮ-ийн үзэл баримтлал нийгэмд төдийгүй эдийн засгийн салбарт төлөвшөөгүй, шинэ ойлголт тул бизнесийн салбарт хариуцлагатай бөгөөд тогтвортой үйлдвэрлэлийн талаар мэдлэг, хуримтлуулсан туршлага бараг байхгүй гэж хэлж болохоор байна. Иймээс ч “Монгол улсын тогтвортой хөгжлийн төлөв” тайланд<sup>45</sup> “*үйлдвэрлэгчид ногоон технологи, ногоон бүтээгдэхүүн, эдийн засгийн арга зүйн сургалтад хамрагдах шаардлагатай. Дээд боловсролын системд тогтвортой хөгжлийн хичээлийг заавал үзэх ёстой*”-г зөвлөжээ.

Харин хэрэглэгчдийн зан төлөв, мэдлэгийн талаар олон тооны судалгаа хийгдсэн байдаг байна. Эдгээр нь сэтгэл судлал, социологи, нийгмийн антропологи, маркетинг, эдийн засгийн элемент агуулсан байх бөгөөд эдгээрээс зарим өгөгдөл, дүгнэлтийг хэрэглэгчдийн мэдлэг, зан төлөвийн талаарх хандлагыг үнэлэхэд ашиглаж болох юм. Мөн төрөөс гарч буй бодлого, шийдвэрүүд хэрэглэгчид буюу олон нийтийн мэдлэг, хандлагад ч тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг нь дамжиггүй юм<sup>46</sup>.

### 4.4. Оролцогч талуудын зураглал

ТХҮ-г нутагшуулах, ялангуяа НХБ-ыг хэрэгжүүлэх үйл явцад нөлөөлөх нөлөөлөл, зайлшгүй оролцох шаардлагаар нь талуудыг дараах үндсэн 4 бүлэгт хувааж болохоор байна. Үүнд:

1. **ШИЙДВЭР ГАРГАГЧ БУЮУ УДИРДАХ ОРОЛЦОГЧ:** гэдэг нь ТХҮ-той холбоотой бодлогыг батлах, хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах эрх бүхий талууд болно.
2. **ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛ:** ТХҮ-г хэрэгжүүлэхэд шууд оролцоотой, ашиг сонирхолтой, шууд нөлөөлөх болон нөлөөлөлд өртөх бүлгүүд багтана. Эдгээр нь тухайлбал хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянах эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагууд байна.
3. **ТЭРГҮҮЛЭН ОРОЛЦОГЧ ТАЛ** нь хувийн хэвшил, сургалт-судалгааны, судалгаа-үйлдвэрлэлийн болон орон нутгийн түвшинд ТҮХ-г хэрэгжүүлэхэд оролцогч төрийн болон орон нутгийн байгууллага, түүнчлэн салбарын ашиг сонирхлыг хамгаалсан, тодорхой бүлгийг төлөөлөхүйц дээвэр байгууллага орно.
4. **ХОЁРДОГЧ ОРОЛЦОГЧ ТАЛ** нь олон нийт, нутгийн иргэд (магадгүй үйлдвэрлэлийн үйл явц, гинжин сүлжээнд оролцдогч ч байж болно), хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөлөл зэрэг сонирхогч бүлэг байж болно<sup>47</sup>.

Оролцогч талуудын хоорондын холбоог таамаглан дараах **Зураг 9**-т харуулав. Оролцогч талуудын зураглалыг тэдний ТҮХ-г хэрэгжүүлэх үйл явцад нөлөөлөх нөлөөлөл, оролцох хэрэгцээ, шаардлага зэргийг үнэлэх зорилгоор боловсруулсан болно.

<sup>45</sup> “Монгол улсын тогтвортой хөгжлийн төлөв” тайлан, БОАЖЯ, ҮХГ, ҮСХ, АНДЭЗНК, 2018, х.82.

<sup>46</sup> Туул голын онцгой хамгаалалтын бүс, Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн талаар авах зарим арга хэмжээний тухай Хотын захирагчийн 2017 оны А/801 тоот захирамж, 2018 онд хогтой холбоотой гарсан 6 журам, 2018 оны 6 сарын 1-с эхлэн бүх ТХГН-дад модон жорлонг хориглох БОАЖ-ын сайдын 2018 оны А-73 тушаал, 2019 оны 3 сарын 1-с эхлэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай ЗГ-ын 2018 оны 189 дүгээр тогтоол гарч, хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнгээ өгч эхлээд байна.

<sup>47</sup> Тухайлбал байгаль орчноо хамгаалах, иргэдийн ухамсар хандлага, мэдлэгийг дээшлүүлэх зорилго бүхий ТББ.

## Зураг 9: Оролцогч талуудын зураглал, хоорондын холбоо



### Тайлбар:

У = удирдан оролцох тал

— = хууль тогтоомж батлах, боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтарч ажиллах холбоо

— = хамтран ажиллах, мэдээлэл шаардах болон мэдээлэл түгээх холбоо

- - - = мэдээлэл солилцох холбоо

----- = сул эсвэл албан бус холбоо

## 5. ТХҮ-ИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, МЭДЛЭГ, ХАНДЛАГА

### 5.1. ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ СТРАТЕГИ

Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл (ТХҮ) нь өргөн цар хүрээ, олон салбарыг хамардаг. Монгол улс ТХҮ-ийн талаар тусгайлан үндэсний стратеги, бодлого боловсруулаагүй ч ТХҮ-ийг нутагшуулах эрмэлзлэлээ Ногоон хөгжлийн бодлогын баримт бичигт тодорхойлсон. Гэвч салбар хоорондын бодлого уялдаагүй, зарим салбарын бодлогод ТХҮ-г орхигдуулсан байна. Иймээс “Байгаль орчны болон байгалийн нөөц баялгийг олон нийтийн оролцоотой удирдах, шударга ёсны зарчмуудыг үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрүүдэд тусган нэгтгэхэд анхаарах нь чухал юм”<sup>48</sup>.


2020 оны 1-р сард зохион байгуулсан олон талт оролцогчдын техникийн зөвлөгөөний үеэр тодорхойлсон хэрэгцээ, зөрүүний судалгаанд үндэслэн ТХҮ-ий мэдээлэл-сурталчилгааны стратегийн дараах гурван үндсэн зорилгыг тодорхойлж байна. Үүнд:

- 1) Стратегийн оролцогч талууд, үүнд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн гол талуудыг хамруулан, тэдний хэрэгцээнд нийцүүлэн мэдлэгшүүлж, чадавхийг нь бэхжүүлэх;
- 2) Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүчин чармайлт, ТХҮ, ногоон хөгжил болон бусад холбогдох чиглэлд гарч буй ахиц дэвшлийн талаар олон нийт, хувийн хэвшил, хэвлэл-мэдээллийнхэнд мэдээлэх, ойлголтыг нэмэгдүүлэх; болон
- 3) Ногоон хөгжлийг цогцлооход тогтвортой амьдралын хэв маяг, зан үйлийг дадал болгон хэвшүүлэх, үүний тулд оролцогч талуудын оролцоо нэмэгдүүлэх.

Дээрх зорилгод хүрэхэд ТХҮ-ийн мэдээлэл-сурталчилгааны стратегид оролцогч талууд бүрт чиглэсэн зорилтыг, түүнчлэн мэдээллийн хэрэгцээний үнэлгээнд тулгуурлан мэдээлэл-сурталчилгааны арга зүй, тохирох мэдээлэл дамжуулах сувгийг тодорхойлох шаардлагатай<sup>49</sup>.

Мэдээлэл сурталчилгааг үндсэндээ 3 төрлийн зорилтот бүлэгт хүргэхээр төлөвлөж болохоор байна (Зураг 10-г харна уу):

Зураг 10: ТХҮ-ийн зорилтот бүлэг



<sup>48</sup> Монгол улсын үндэсний сайн дурын илтгэл 2019, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, Улаанбаатар, х.46.

<sup>49</sup> Оролцогч талуудын зураглал бүлгээс харна уу.

## 5.2. Мэдээлэл солилцоо: Цахим технологийн боломж

Ил тод байдал, мэдлэг, мэдээллийн солилцоо, үйлдвэрлэл-нийлүүлэлтийн гинжин хэлхээний менежмент, хамтын ажиллагаа зэрэг нь тогтвортой хэрэглээнд хүрэх түлхүүр хүчин зүйлс болдог. Эко дизайны схем, бүтээгдэхүүний стандарт нь хэрэглэгчдийг илүү хариуцлагатай сонголт хийхэд чиглүүлэх ач холбогдолтой. Тухайлбал МХАҮТ-с бүтээгдэхүүний сайн дурын баталгаажуулалтын Ногоон буудал - эко шошго (2012) ба Органик бүтээгдэхүүн эко шошго (2016) гэсэн хоёр схемийг гаргажээ. Сүүлийн үед ялангуяа хүнсний болон дотоодын үйлдвэрлэлийн салбарт маркетингийн сурталчилгаандаа сайн дураараа тодорхойлсон өөрийн зарласан мэдэгдэл болох “эко шошго” буюу “органик” гэсэн наалтыг хэрэглэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь ногоон угаалтыг нэмэгдүүлэх, төөрөгдүүлэх эрсдэлтэй. Иймээс л хэрэглэгч, үйлдвэрлэгч нарт мэдээллийн хэрэгцээ их байдаг. 2020 оны эхээр зохион байгуулагдсан оролцогч талуудын техникийн зөвлөгөөн дээр оролцогчид “ногоон” туршлагын талаар цогц мэдээлэл агуулсан, мэдээлэл солилцооны ТХҮ платформыг бий болгох санал гаргасан. Бүх оролцогч талуудад зориулсан “нэг цэгийн үйлчилгээний” платформыг байгуулах боломжгүй юм. Иймээс өнөөгийн нөхцөлд хэрэг болохуйц байгаа мэдээллийн сан, цахим хуудсыг дараах **Хүснэгт 6**-д нэгтгэн харуулав.

**Хүснэгт 6: Яамд, агентлагийн вэб сайт, цахим мэдээллийн сан**

<b>Цахим мэдээллийн сан</b>	<b>Товч танилцуулга</b>	<b>ТХЗ 12 зорилтын шалгуур үзүүлэлттэй нийцэх байдал</b>
Хог хаягдлын мэдээллийн нэгдсэн санг БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн төв удирдана: <a href="https://www.eic.mn/waste/#statistics">https://www.eic.mn/waste/#statistics</a>	Олон нийтэд нээлттэй мэдээллийн санд нийт хог хаягдлын мэдээг төрлөөр (энгийн, дахин боловсруулах боломжтой болон аюултай хог хаягдал) төвлөрүүлэх ба хог хаягдлын ангилал, хууль эрх зүйн мэдээлэл (хөтөлбөр, хууль, журам), танин мэдэхүй, боловсролын мэдээлэл зэргээс бүрдэнэ.	12.4.1 Аюултай хог хаягдал, бусад химийн бодисын тухай байгаль орчны олон улсын олон талт гэрээ, хэлэлцээрийн дагуу мэдээлэл солилцох үүргээ биелүүлж байгаа эсэх 12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, дахин боловсруулсан материал, тонноор
Химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн нэгдсэн санг БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн төв удирдана: <a href="https://www.eic.mn/toxic/">https://www.eic.mn/toxic/</a>	Мэдээллийн сан нь аюултай хог хаягдлын бодлого зохицуулалт (хөтөлбөр, хууль, журам), янз бүрийн химийн бодис, аюултай бодис, статистик, газарзүйн мэдээлэл, танин мэдэхүй, боловсролын мэдээлэл зэргээс бүрдэх ба бүртгэлтэй хэрэглэгчдэд мэдээлэл оруулна.	12.4.2. Нэг хүнд ногдох аюултай хог хаягдал, устгасан хог хаягдлын эзлэх хувь, устгалын төрлөөр
Байгаль орчинд ээлтэй технологийн мэдээллийн санг БОАЖЯ-ны Байгаль орчны мэдээллийн төв удирдана: <a href="https://eic.mn/greentech/">https://eic.mn/greentech/</a>	Мэдээллийн сан нь дэвшилтэт, цэвэр технологийн мэдээллээс (агаарын чанар, хөрсний чанар, усны чанар, биологийн олон янз байдал, хог хаягдал, сэргээгдэх эрчим хүчний ашиглалт зэрэгтэй холбоотой болон судалгааны	12.а.1. Байгаль орчинд ээлтэй технологи, үйлдвэрлэл, тогтвортой хэрэглээнд зориулсан судалгаа, хөгжлийн тусламжийн хэмжээ

	ажлууд) бүрдэнэ. Одоогоор мэдээллийн санг шинэчлэн өргөжүүлэх ажил хийгдэж байна.	
Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлын мэдээллийн санг <a href="http://www.stf.mn">http://www.stf.mn</a> Шинжлэх ухаан технологийн сан (ШУТС) удирдана.	Тус сан нь их дээд сургуулийн гарааны компани, судалгааны байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулсан хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, үр ашигтай зарцуулах, түүний хяналтыг хийх ба үр дүнг эндээс үнэлгээтэй авах боломжтой.	
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)-ын вэб хуудас <a href="http://www.pcsp.gov.mn/en">http://www.pcsp.gov.mn/en</a>	Цахим хуудаст төрийн худалдан авах ажиллагааны бодлого, хууль, журам, ил тод байдлын мэдээлэл, шилэн данс, сургалт (үүнд ногоон худалдан авалтын сургалт орсон), цахим тендерийн холбоос зэрэг мэдээлэлтэй.	12.7.1 Төрийн худалдан авах ажиллагааны тогтвортой бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх
Сангийн яамны вэб хуудас <a href="https://mof.gov.mn/">https://mof.gov.mn/</a>	Яамны сайт нь засгийн газрын бодлого, төсөв, макро эдийн засаг, бодлого зохицуулалт (худалдан авалтын хууль, журам), ил тод байдлын мэдээлэл, шилэн данс, цахим тендер зэрэг төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллүүдтэй болон бусад холбоосуудтай.	

Сэдэвчилсэн ажлын хэсгийн (жишээлбэл, Монголын бизнесийн зөвлөлийн <http://bcmongolia.org/en/>), ИНБ-уудын цахим хуудас, нийгмийн сүлжээний хуудас (жишээлбэл МҮХАҮТ-ийн <https://www.mongolchamber.mn/>) ашиглах боломжтой ба тодорхой чиглэл, сэдвээр нийгмийн сүлжээнд бүлэг үүсгэн талуудын хамтын сонирхол, мэдээллээ хуваалцах боломж бий.

Хэрэглэгч, үйлдвэрлэгчид тодорхой салбар, чиглэлийн талаар мэдээлэл өгөх, мэдээлэл солилцох платформ бас байна. Тухайлбал АХБ-ны ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих төслийн хүрээнд ХАА, хөнгөн үйлдвэрийн голлох салбарын нэмүү өртгийн сүлжээний мэдээллийн индэр вэб хуудас хийсэн ба эндээс хэрэглэгчид олон талын мэдээлэл авах боломжтой (линк: <http://vcmongolia.mn/default.aspx?page=1>).

Нөгөө талаар “ерөнхийдөө судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хэрэглээний судалгаа, инновацийн төслүүдийн үр дүн нээлттэй бус, олон нийтэд хүргэдэггүй”<sup>50</sup> дутагдал байсаар байна.

Оролцогчдын өөрсдийн тодорхойлсон мэдээлэл, сургалтын хэрэгцээг [Хүснэгт 6-д](#) харуулав.

<sup>50</sup> Б.Эрдэнэчимэг, “2012-2018 онд байгаль орчны салбарт хийгдсэн эрдэм шинжилгээний төсөл, судалгаа, шинжилгээний ажил, бүтээлийн тойм”, 2018 он. Тайлан.

### 5.3. Мэдээлэл-сурталчилгааны хэрэгцээт сэдэв

ТХҮ-ий мэдээлэл-сурталчилгааны стратегийн нэн тэргүүний хэрэгцээт сэдвүүдийг дор эрэмбэлэн харуулав. Үүнд:




- Байгалийн нөөцийн тогтвортой менежмент ба ашиглалт,
- Химийн бодис, хог хаягдлын хариуцлагатай менежмент,
- Тогтвортой арга ажиллагаа ба компаниудын тогтвортой байдлын тайлагнал,
- Тогтвортой худалдан авалт,
- Тогтвортой амьдралын хэв маяг,
- Инновац, ногоон технологи, болон
- Тогтвортой аялал жуулчлал.

Мэдээлэл-сурталчилгааны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Дэлхийд баримталдаг зарчим, сайн туршлагад үндэслэсэн компанийн тогтвортой байдлын тайлагналын загварыг Монголын нөхцөлд тохируулан боловсруулах, ААНБ-ыг сургах, тогтвортой байдлын тайлан хийхийг дэмжих;
- Бүх байгууллагуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг компанийн болон засгийн газрын мэдээллийн хуудсанд тавьж, олон нийтэд ил байлгадаг болох;
- Тайлагналын стандартыг Засгийн газарт танилцуулах;
- Тайлангийн мэдээлэлд оруулах үзүүлэлтүүдийг бизнесийн салбар, бизнесийн болон худалдааны салбарын холбоодтой зөвшилцөн боловсруулах. Хотын бохирдол, хөрсний бохирдол, хог хаягдлын менежмент нь зөвхөн бодлогод тусгахаар хязгаарлахгүйгээр бүх нийтийн хариуцлагатай холбоотой үндсэн сэдэв байна.

ТХЗ 12-ын үндсэн ба дэд сэдвүүд зорилтот бүлгүүд болон дээр дурдсан хэрэгцээт үндсэн сэдэвтэй нягт уялдахыг дараах хүснэгтээр харуулав (Хүснэгт 7-г харна уу).

Хүснэгт 7: Мэдээлэл-сурталчилгаанд тусгах ТХЗ 12-ийн үндсэн ба дэд сэдэв

ТХЗ12 Үндсэн сэдэв	Дэд сэдэв	Зорилтот бүлэг
 12.1 10 ТХҮ-ийн 10 жилийн суурь хөтөлбөр	ТХҮ-г дэмжих	<ul style="list-style-type: none"> <li>- Шийдвэр гаргагчид</li> <li>- Иргэний нийгэм</li> <li>- Хувийн хэвшил</li> </ul>
 12.2 Байгалийн нөөцийн тогтвортой менежмент ба ашиглалт	<ul style="list-style-type: none"> <li>- Эргэлтийн эдийн засаг (эрчим хүчний үр ашиг, ус, ариун цэврийн байгууламж, барилга, барилгын материал)</li> <li>- Байгаль орчны менежментийн тогтолцоо</li> <li>- Ногоон технологи</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн хэвшил</li> <li>- Иргэний нийгэм</li> <li>- Төрийн салбар</li> </ul>
 12.3 Хоол, хүнсний хаягдал	<ul style="list-style-type: none"> <li>- 3R</li> <li>- Тогтвортой амьдралын хэв маяг</li> <li>- Тогтвортой хөгжлийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн салбар</li> <li>- Хувийн хэвшил</li> </ul>



		боловсрол	- Иргэний нийгэм
	12.4 Химийн бодис, хог хаягдлын хариуцлагатай менежмент	Химийн бодисын менежмент	- Төрийн салбар - Хувийн хэвшил - Иргэний нийгэм
	12.5 Хог хаягдлыг багасгах	- Орчны бохирдол - 3R болон хог хаягдлын менежмент - Тогтвортой амьдралын хэв маяг - Тогтвортой хөгжлийн боловсрол	- Хувийн хэвшил - Иргэний нийгэм
	12.6 Тогтвортой арга ажиллагаа ба компаниудын тогтвортой байдлын тайлагнал	- Эргэлтийн эдийн засаг - Байгаль орчны менежментийн тогтолцоо	Хувийн хэвшил
	12.7 Тогтвортой худалдан авалтын арга барил	Ногоон худалдан авалт	- Төрийн салбар - Хувийн хэвшил
	12.8 Тогтвортой амьдралын хэв маягийн талаарх бүх нийтийн ойлголт	- Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ) - Мэдээлэл-сурталчилгаа - Тогтвортой амьдралын хэв маяг	- Иргэний нийгэм - Хувийн хэвшил - Төрийн салбар
	12.a ТХҮ-д шилжих шинжлэх ухаан, технологийн чадавхи	- Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар дахь инноваци (үүнд нэхмэл, ноос, арьс шир боловсруулах үйлдвэрлэл хамаарна)	Хувийн хэвшил
	12.b Тогтвортой аялал жуулчлал	Эко-аялал жуулчлал	Хувийн хэвшил
	12.c Үрэлгэн хэрэглээг дэмждэг зах зээлийн гажуудлыг арилгах	Эдийн засгийн урамшууллын хөшүүргийн загвар, банкны салбарыг дэмжих	Хувийн хэвшил

## 5.4. Худалдан авалт хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах

Зөвлөгөөнд оролцогчид болон ногоон худалдан авалтын сургалтанд оролцогчид одоогийн эсвэл шинээр гаргах худалдан авах ажиллагааны бодлого, журам, удирдамж, заавар, гарын авлага, тендерийн жишиг баримт бичигт дараах зүйлүүдийг тусгах шаардлагатайг санал болгосон. Үүнд:

- Есо-шошго;
- Эрчим хүч, барилгын салбарт ISO 50001-г нэвтрүүлэх;
- Ногоон худалдан авалт;
- Ногоон бүтээгдэхүний жагсаалт, шалгуур үзүүлэлт;
- Инновацийн урамшууллын тогтолцоо;
- Аюултай бодис саармагжуулах, устгах;
- Цэвэр/сэргээгдэх эрчим хүчний стандарт;
- Хүний нөөц болон
- Төсөвлөлт.











Төрийн албан хаагчид болон худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд дээрх сэдвээр сургалт явуулах шаардлагатай байгаа ба сургалтыг явуулахад хамгийн тохиромжтой арга бол оролцогчдын ажлын ачаалал, цаг хугацааны хязгаарлалтыг харгалзан СЯ болон түүний агентлагуудаас зохион байгуулдаг анги танхимын хэлбэр эсвэл онлайн сургалт хэрэгтэй байгааг онцолж байв. Сургалтын агуулгын хэрэгцээг **Хүснэгт 10**-д эрэмбэлэн харуулав.

## 5.5. Мэдээллийн бүтээгдэхүүн

Мэдээлэл-сурталчилгааны үр дүн зорилтот бүлгүүдэд контент, мэдээллийн бүтээгдэхүүнийг хүссэн сувгаар тохиромжтой форматаар уламжлалт болон цахим сувгийг хир оновчтой хослуулан хүргэхээс хамаардаг. Мэдээж төсвийн асуудал энд чухал нөлөөтэй (**Хүснэгт 8**-г харна уу).

**Хүснэгт 8: Мэдээллийн бүтээгдэхүүний давуу болон сул тал**

	Мэдээлэл авах суваг	Мэдээллийн бүтээгдэхүүн	Давуу тал	Сул тал	Харуулж болох формат			
					зураг	видео	аудио	текст
УЛАМЖЛАЛТ	Хэвлэмэл бүтээгдэхүүн	Сэтгүүл, сонин зурагт хуудас, хурлын илтгэлийн нэгтгэл, брошюр, товч танилцуулга, бусад	Цаг хэмнэн мэдээллийг шууд хүргэнэ, үр дүн хэмжигдэнэ	Хэвлэлийн зардал өндөр, боловсруулалт болон бэлтгэлд цаг орно, хэвлэмэл бүтээл байгальд ээлгүй				
	ТВ-ийн нэвтрүүлэг	ТВ нэвтрүүлэг, ярилцлага	олон нийтэд шууд хүрнэ	Бэлтгэлд цаг хугацаа орно, зардал маш өндөр гардаг				
	Арга хэмжээ & кампанит ажил	Уулзалт-хэлэлцүүлэг, нээлттэй арга хэмжээ, үзэсгэлэн болон кампанит ажил	Олон төрлийн мэдээллийн суваг, формат ашиглан олон хүнд хүргэх, нөлөө бүхий	Зохион байгуулалт, бэлтгэл ажилд цаг шаардагдана, төсөв өндөр				

ЦАХИМ			тоглогчийг оруулах, мэдээллийг (онлайн / оффлайн) түгээх боломжтой	гарах магадлалтай				
	Радио нэвирүүлэг	Шторк, ярилцлага-нэвтрүүлэг	Суурин газруудад ФМ олон нийтэд шууд хүрнэ	Зарим газар хүн бүр эсвэл хүлээн авах боломжгүй байх талтай				
	Мэдлэгийн сан болон мэдээллийн хуудас	Үндэсний болон олон улсын оролцогч талуудын, түүнчлэн яамны мэдээллийн хуудас, мэдлэгийн платформ, мэдээллийн сан	Хэрэгцээт мэдээллийг янз бүрийн форматаар түргэн, үнэгүй хүргэнэ, шр дүн хэмжигдэхүйц	Интернет сүлжээтэй байх шаардлагатай, линк болон хуудсыг олон хүн мэдэхгүй байх талтай				
	Нээлттэй нийтлэл, нээлттэй эх нийтлэх, блог	Блогны платформ	Мэдээлийг хурдан түгээх, суралцагч болон багш нарт мэдээлэл солилцох давуу талтай	Хөгжүүлэгч эсвэл хостинг хариуцагчийн хэрэгцээнд илүү чиглэсэн				
	Нийгмийн сүлжээ (Facebook, YouTube, Twitter, Instagram)	Блог, жиргээ, бусдын түүх, арга хэмжээнд уриалах, бэлэн контент түгээх, эсвэл хэрэглэгчдийн хийсэн контентийг харуулах, зураг, дүрс, инфографик, кампанит ажлын мэдээ түгээх зэрэг	Өдөр бүр мэдээллийг шуурхай, үнэгүй, олон хүнд хүргэх, зорилтот бүлгүүдийг холбох, сүлжээ болон түншлэл үүсгэх, бүтээгдэхүүн таниулах, мэдээлэл-сурталчилгаа явуулах, үр дүн нь хэмжигдэхүйц	Интернет сүлжээтэй байх шаардлагатай, линк болон хуудсыг олон хүн мэдэхгүй байх талтай				

## 5.6. Мэдээллийн СУВАГ

Семинарт оролцогчдын ихэнх нь мэдээллийг телевизийн нэвтрүүлэг, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан авах, онлайн платформоор мэдлэг солилцохыг чухалчлав. И-мэйлээр болон мэдээллийн товхимол, хэвлэмэл бусад бүтээгдэхүүнийг түгээх нь мэдээлэл-сурталчилгааны ажилд чухал үүрэгтэй гэж тодорхойлов. Мэдээллийг уламжлалт байдлаар дээрээс доош 1 чиглэлд дамжуулж болно. Гэхдээ зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, сонирхол өөр тул тэд мэдээллийг өөр өөр сувгаар авах хүсэлтэй байдаг юм (**Хүснэгт 9**-г харна уу). Нөгөө талаар оролцогч талууд мэдээлэл солилцооны ач холбогдлыг онцлон, платформ бий болгох санал гаргасныг дээр дурдсан.

**ХЭРЭВ** оролцогч талуудын үндсэн мэдээлэл авах зорилго, мэдээллийн хэрэгцээт байдал тодорхой **бол** дараагийн алхамд мэдээлэл-сурталчилгааг явуулах арга барил, төвлөрөх **ЧИГЛЭЛ**-ийг тодорхойлон нэгтгэж болохоор байна (**Хүснэгт 10**-г харна уу).

### Хүснэгт 9: Оролцогч талуудын мэдээлэл авах сонирхолтой суваг

Зорилтот бүлэг	Мэдээллийн суваг	Түншүүдийн оролцоо
<b>ТӨРИЙН САЛБАР</b>		
Шийдвэр гаргагчид	Мэдлэг болон мэдээллийн платформ; арга хэмжээ (хурал, зөвлөгөөн)	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын түншүүд</li> </ul>
Чиглэлийн яамд, холбогдох төрийн байгууллага	Мэдлэг болон мэдээллийн платформ; арга хэмжээ (зөвлөгөөн, уулзалт); ТВ-ийн нэвтрүүлэг; И-мэйл	<ul style="list-style-type: none"> <li>Олон улсын түншүүд;</li> <li>Төсөл, хөтөлбөрүүд;</li> <li>Хэвлэл, мэдээлэл</li> </ul>
<b>ХУВИЙН САЛБАР</b>		
Бизнесийн байгууллага	Хэвлэмэл бүтээгдэхүүн; Мэдлэг болон мэдээллийн платформ; Нийгмийн сүлжээ, мэдээлэл дамжуулалт; Арга хэмжээ (сургалт байх боломжтой)	<ul style="list-style-type: none"> <li>Төсөл, хөтөлбөрүүд;</li> <li>Судалгаа-үйлдвэрлэлийн байгууллага</li> </ul>
Судалгаа-үйлдвэрлэлийн байгууллага (гарааны компани)	Мэдлэг болон мэдээллийн платформ; Арга хэмжээ (зөвлөгөөн); Хэвлэмэл бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>Төсөл, хөтөлбөрүүд;</li> <li>Хэвлэл, мэдээлэл</li> </ul>
<b>ИРГЭНИЙ НИЙГЭМ</b>		
Хэрэглэгчид	Мэдлэг болон мэдээллийн платформ; Нийгмийн сүлжээ, мэдээлэл дамжуулалт; Хэвлэмэл бүтээгдэхүүн; Нэвтрүүлэг; Арга хэмжээ болон кампанит ажил.	<ul style="list-style-type: none"> <li>Хэвлэл, мэдээлэл;</li> <li>Иргэний нийгэм</li> </ul>
Сонирхогч бүлгүүд,	Мэдлэг болон мэдээллийн	<ul style="list-style-type: none"> <li>Стратегийн оролцогч</li> </ul>

үүнд мэргэжлийн холбоод болон хэвлэл, мэдээллийнхэн орно	платформ; Нийгмийн сүлжээ, мэдээлэл дамжуулалт; Хэвлэмэл бүтээгдэхүүн; Нэвтрүүлэг; Арга хэмжээ болон кампанит ажил.	талууд, түншүүд
Сурагчид, оюутнууд (сургууль, боловсролын байгууллага)	Хичээлийн хөтөлбөр; Арга хэмжээ болон кампанит ажил; Нийгмийн сүлжээ, мэдээлэл дамжуулалт.	• Төсөл, хөтөлбөрүүд

### Хүснэгт 10: Мэдээлэл-сурталчилгааны ТӨВЛӨРӨХ ЧИГЛЭЛ

Стратегийн оролцогч тал	Үндсэн зорилго	Арга барил	Мэдээллийн хэрэгцээ /эрэмбээр/
<b>ТӨРИЙН САЛБАР</b>			
Шийдвэр гаргагчид / хууль, журам батлах дээд түвшний байгууллага	Хууль эрх зүйн орчныг бий болгох, улс төрийн хүсэл, зорилгыг нэмэгдүүлэх	Мэдээллийн, Үйл ажиллагааны	1) ТХҮ-той холбоотой хууль тогтоомж, зохицуулалт; 2) ТХҮ-ийн салбар дамнасан асуудлууд; 3) Бүс нутгийн болон бусад сайн жишээ.
Чиглэлийн яамд, холбогдох төрийн байгууллага	Чадавхийг бэхжүүлэх, мэдээлэл солилцох замаар институцийн чадавхийг сайжруулах	Мэдээллийн, Үйл ажиллагааны	1) ТХҮ-ийн зарчмын талаар нэгдсэн ойлголт, мэдлэг; 2) НХА-ын хууль эрх зүй, журам, шалгуур үзүүлэлт, аргачлал; 3) Худалдан авалттай холбоотойгоор эко шошгожуулалт, тэмдэглэгээний дүрэм, схем; 4) Урамшууллын тогтолцоо, ногоон санхүүжилт; 5) Хүний нөөц, чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр.
<b>ХУВИЙН САЛБАР</b>			
Бизнесийн байгууллага	Чадавхийг бэхжүүлэх болон оролцоог нэмэгдүүлэх замаар ТХҮ-ийн талаарх мэдлэг, дадал, арга барилыг сайжруулах	Мэдээллийн, Хандлагын	1) Холбогдох хууль, журам; 2) Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын журам; 3) Цахим системд бүртгүүлэх; 4) Өгөгдөл, мэдээлэл солилцооны платформ (жишээ нь стандарт, зааварчилгаа, инновац, технологийн мэдээлэл оруулсан); 5) Урамшууллын тогтолцоо, ногоон санхүүжилт, ногоон зээл; 6) Сайн туршлага, төслийн талаарх мэдээлэл.
Боловсрол,	Чадавхийг	Мэдээллийн,	1) орон нутгийн нөхцөлд тохиромжтой

судалгааны байгууллага	бэхжүүлэх, санаачлагыг дэмжин чиглүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх	Хандлагын	үйлдвэрлэлд нэвтрүүлэх болон технологийн суурь судалгаа, эрдэм шинжилгээний ажил (эрчим хүчний үр ашиг, хог, хаягдал боловсруулах, нөөцийн хэмнэлт).
------------------------	--	-----------	--

### ИРГЭНИЙ НИЙГЭМ

Сонирхогч бүлгүүд	Мэдлэг, мэдээллийг түгээх замаар ТХҮ-ийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах	Сэтгэл зүйн, Мэдээллийн, Хандлагын	1) Бодлого, зохицуулалт, эрх зүйн талаарх мэдээлэл; 2) Урамшууллын тогтолцоо, ногоон санхүүжилт, ногоон зээл; 3) Ногоон, тогтвортой бүтээгдэхүүн болон инновацийн мэдээлэл, сайн туршлага.
Хэрэглэгчид, олон нийт	Мэдлэг, мэдээллийг түгээх замаар ТХҮ-ийн талаарх ойлголт, хандлагыг сайжруулах	Сэтгэл зүйн, Мэдээллийн, Үйл ажиллагаанд чиглэсэн	1) Тогтвортой амьдралын хэв маяг, бүтээгдэхүүний талаарх мэдээлэл; 2) Тогтвортой зан үйл, дадал

## 5.7. ИНСТИТУЧЛАЛ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бодлого, төлөвлөлтөд уялдуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх алхамууд хийгдэж байна. Тухайлбал 2017 онд Ерөнхий сайд тэргүүлсэн Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг олон талын төлөөлөл оролцуулж байгуулсан нь тохирсон институцийн механизмыг бий болгоход чухал алхам болсон. Гэвч энэ бүтцийн үйл ажиллагаа харагдахуйц үр дүнгээ өгч, олон нийтэд танигдахгүй байгааг дурдах хэрэгтэй.

БОАЖЯ нь тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлогыг тэргүүлэн хэрэгжүүлдэг (**Хүснэгт 3-г харна уу**). Гэхдээ хэрэгжилтийг эрчимжүүлэхэд үйл ажиллагаанд гол оролцогч талуудыг хамруулах, салбар хоорондын болон орон нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд яамд болон бусад холбогдох агентлагуудын хамтын ажиллагааг сайжруулж, хүчийг нэгтгэх техникийн зөвлөл эсвэл олон салбартай төлөөлөл бүхий ажлын хэсэг эсвэл ажлын бүлгүүдийг зохион байгуулах шаардлагатай байна.

## 5.8. ХАМТЫН АЖИЛЛАГАА БА ОРОЛЦОО

Оролцогч талууд олон чиглэлийн яамд, салбарын байгууллагууд, хувийн хэвшил болон олон нийтийн хамтын ажиллагаа, түүнчлэн мэдээлэл солилцоо хэрэгцээтэй байгааг онцолж байсныг дээр дурдсан. Мэдээлэл солилцооны платформ (техникийн зөвлөгөөний үеэр оролцогчдын санал болгосон) үндэсний болон орон нутгийн түвшинд тогтвортой бөгөөд ногоон хөгжлийн хэтийн зорилгын хэрэгжүүлэх, засаглалыг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр болж болох юм. ТХҮ хэв маягийг Монголд бий болгож нутагшуулахад цаашид



олон талын хүчин чармайлт, хүсэл эрмэлзлэл, түүнчлэн бодлогын хэрэгслүүд хэрэгтэй байна. Үүнд олон улсын хамтын нийгэмлэгийг дэмжлэггүйгээр, бусдын сайн туршлага, алдаа онооноос суралцахуйгээр ТХҮ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Мөн авч буй арга хэмжээнүүдэд холбогдох талууд, үндэсний болон олон улсын байгууллагын санхүүжилттэй хэрэгжиж буй ижил төстөй төсөл, хөтөлбөрүүд хүчээ нэгтгэн, далайцтай өөрчлөлтөд хувь нэмэр оруулдаг байх шаардлагатай байна.

## 6. ОЛОН УЛСЫН ТХҮ-ИЙН САЙН ТУРШЛАГА

Энэ бүлэгт Засгийн газарт чухал гэж үзсэн чиглэлээр олон улсын хэмжээнд хэрэгжүүлж буй ТХҮ-ийн сайн туршлагаудаас танилцуулж байна.

### 6.1. НОГООН ҮЙЛДВЭРЛЭЛ

“Ногоон” бөгөөд илүү тогтвортой эдийн засгийг бүтээн байгуулна гэдэг нь бид хэрхэн хэрэглэж, яаж үйлдвэрлэж байгаагаа өөрчилнө гэсэн үг юм. Ингэснээр хог хаягдал багатай, цэвэр, аюулгүй үйлдвэрлэл, нөөцийн үр ашигтай зарцуулалт, илүү ил тод, нийгмийн хариуцлагатай байдлаас ашиг хүртэж болохоо ойлгосон бизнес эрхлэгчдэд илүү их өөрчлөлтийг авчирна.

Ирээдүйд тогтвортой эдийн засгийг бий болгохын тулд хэрэглээ ба үйлдвэрлэл нь экосистемийг алдагдуулдаг сөрөг “хоршлыг” эвдэхүйц шинэлэг шийдлүүдийг эрэлхийлэх нь зүйтэй. Эдгээр шийдлүүд нь бизнес эрхлэгчдэд нөөцийг хэмнэх, эдийн засгаа сайжруулах, хэрэглэгчтэй харилцах харилцааг сайжруулах, нэр хүндээ өсгөх, үйлдвэрлэлийн стандартыг хангах, хуульзүйн шаардлагыг биелүүлж, осол ба эрсдэл багатай ажиллах зэрэг олон боломжуудыг нээж өгнө. Хамгийн гол нь үйлдвэрлэлийн үргүй зардлаас зайлсхийж, оронд нь ур чадвартай боловсон хүчнийг татаж ажиллуулах, шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөгч нараасаа давуу талтай болох юм<sup>51</sup>. Бизнесийн “ногоон” санаачилгууд нь Тогтвортой хөгжлийн зорилгын 12.6 дахь зорилт буюу “Хувийн хэвшил, ялангуяа томоохон, үндэстэн дамнасан компаниудыг тогтвортой байдалд чиглэсэн арга ажиллагааг нэвтрүүлж, энэ талаарх мэдээллийг өөрсдийн үйл ажиллагааны тайландаа тусгадаг байхыг дэмжих” зорилттой холбогдоно.

#### 6.1.1. Эко-инновац

Эко-инновац гэдэг нь ямар нэг бүтээгдэхүүний үйлдвэрлэгдэн гарахаас, хог хаягдал болох хүртэл нийт амьдралын мөчлөгийн туршид тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ компанийн бүтээмж, өрсөлдөж чадварыг дээшлүүлж байдаг бизнесийн нэг аргачлал юм. Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийн тухайд шинэ ба өргөжиж буй зах зээлүүдэд нэвтрэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, бизнестээ хөрөнгө оруулалт татах, өртгийн сүлжээнээс ашиг хүртэх байдлаа сайжруулах, дүрэм, журам, ялангуяа хүрээлэн буй орчинтой холбоотой стандартуудын ард хоцрохгүй, харин ч түүчээлэн манлайлж явахад нь тус болно.

Эко-инновац нь компанийн төлөвлөгөө боловсруулахээс эхлээд аж ахуйн нэгжийн хүрээнээс хальж нийлүүлэлтийн сүлжээ хүртэл өргөн цар хүрээг хамардаг учир эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн сацуу тогтвортой байдлыг хадгалж чаддаг харилцан ашигтай шийдэл мөн. Зах зээл тэлж, нөөц хомсдон, хүрээлэн буй орчин доройтож байгаагаас үүдэн нэр хүндийн болоод дүрэм журмын дарамт шахалт ихсэж байгаа нь эко-инновацыг бизнест нэвтрүүлэх шаардлагыг төрүүлж байна.

НҮБ-аас 2017 онд эко-инновацийн гарын авлагыг хэвлэн гаргасан бөгөөд үүнд ЖДҮ-д эко-инновацыг нэвтрүүлэх буюу Эко-инновацыг хэрэгжүүлэх үйл явцыг тайлбарласан байдаг<sup>52</sup>. Эко-инновацыг хэрэгжүүлэх зургаан үндсэн үе шат бий. Үүнд:

<sup>51</sup> <https://www.unenvironment.org/explore-topics/resource-efficiency/what-we-do/responsible-industry>

<sup>52</sup> UN and DTU: Eco-i Manual Eco-innovation implementation process, 2017.

БЭЛТГЭЛ	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь тохирох салбар, зах зээл, компанийг сонгон авч, сонгогдсон субъектүүдийнхээ тогтвортой хөгжлийн асуудлаар тулгарч буй бэрхшээл, боломжуудын тухай анхан шатны ойлголтын зураглалыг гаргана.
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨХ	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь сонгож авсан компанийнхаа үйл ажиллагаагаа явуулж байгаа байдлын талаар урьдчилсан үнэлгээ хийж, тогтвортой хөгжлийн асуудлаар тулгарч байгаа бэрхшээл ба боломжуудын талаарх ойлголтыг сайжруулна. Тухайн мэдээлэл нь тус компанид бизнесийн шинэ стратеги боловсруулж нэвтрүүлэхэд ашиглагдана.
БИЗНЕСИЙН ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ	Тухайн компанийн одоогийн бизнесийн загварыг бүхлээр нь авч үзэн, тогтвортой байдалд нь нарийвчилсан үнэлгээ хийснээр энэхүү үе шат эхэлнэ. Ингээд бизнесийн боломжит шинэ загваруудыг, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болохуйц түвшний инновацуудын хамт боловсруулж гаргана. Дараа нь тэдгээр бизнесийн загварууддаа үнэлэлт өгч хамгийн сайныг хэрэгжүүлэхээр сонгож авна.
ЗАМЫН ЗУРАГЛАЛ ГАРГАХ	Бизнесийн загвараа сонгомогц тус загварыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох үйл ажиллагааны түвшний төслүүдийн зураглалыг гаргана. Эхний нэг юм уу хоёр бодитой төслийг сонгон авснаар бизнесийн загварыг хэрэгжүүлэх эхний алхамыг хийнэ.
ХЭРЭГЖҮҮЛЭЛТ	Эхний ээлжийн төслийн санаануудыг ажил хэрэг болгож эхэлнэ. Асуудал гарч ирэхэд зохицуулах шийдвэр гаргаж ажиллахын тулд уян хатан байх шаардлагатай.
ДҮГНЭЛТ	Хэрэгжилтийн эхний ээлжийн сүүлийн үе шат эхний төслүүдийнхээ алдаа оноог дүгнэж, компанийн авсан сургамжид үндэслэн бизнесийн загвараа шинэчлэн сайжруулснаар өндөрлөнө.

Эко-инновацыг хэрэгжүүлэх нь нэг удаа хийгээд орхих ажил биш юм. Эко-инновацийн хэрэгжилт нь нэг үе шатнаас дараагийнх руу ямар нэг саадгүйгээр шилжин орох боломжтой шинж чанартай хэмээн НҮБ-ын гарын авлагад тусгасан байгаа боловч өөрчлөх, хөгжүүлэх, шинэ мэдээлэл оруулах шаардлага гарвал өмнөх үе шат руугаа эргэн нэг харах шаардлага гарч болох юм. Инновацийн ямар ч үйл явцад ийм зүйл байж болох бөгөөд доголдол гэж ойлгох хэрэггүй. Харин ч урт хугацаандаа иймэрхүү жижиг дутагдлууд нь илүү сайн үр дүнд хүргэх нь элбэг.

## ЮНИДО

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО) нь эко-инновацыг нэвтрүүлэх, компанийн хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөг бууруулах асуудлаар дэлхийд манлайлагч юм. Тус байгууллага нь гурван үндсэн чиглэлээр төслүүдийг ангилан шалгаруулдаг. Үүнд: Бүтээмжит ажлуудын тусламжтайгаар ядуурлыг бууруулах; Худалдааны чадавхыг дээшлүүлэх; Хүрээлэн буй орчин ба эрчим хүч гэсэн сэдвүүд багтана.

### Бангладеш – Хүнцэлгүй ундны ус

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага НҮБ-ын Хүн төрөлхтний аюулгүй байдлын итгэлцлийн сан хамтран хүнцэлийн бохирдол хамгийн ихтэй газруудад усан дахь хүнцэлийн агууламжийг арилгах төсөл хэрэгжүүлэхэд нь Бангладешийн Засгийн газарт туслалцаа үзүүлж ажилласан.

### Гватемала - Ногоон үйлдвэрлэл

Тус төв нь НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага, Байгаль орчны хөтөлбөрийн дэмжлэгээс гадна Дэл Валле их сургууль, Чихэр үйлдвэрлэгчдийн холбоо, Аж үйлдвэрийн танхим зэрэг үндэсний

институциудын дэмжлэгийг хүлээсэн байгууллага юм.

#### **Энэтхэг - Байгаль орчинд ээлтэй (нүүрсхүчлийн хийн ялгарал багатай) хөргөгч**

Швейцарийн Эдийн засгийн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга нарын газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр ЮНИДО байгууллага Энэтхэгийн хоёр том хөргөгч үйлдвэрлэгчтэй (Godrej & Boyce Mfg. ХХК ба Videoson Appliances ХХК) байгаль орчны бохирдлыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор цэвэр хөгжлийн механизм (ЦХМ)-ын шинэ аргачлалыг боловсруулахад хамтран ажилласан.

#### **Словак - Ногоон үйлдвэрлэл**

Словак дахь тус төв нь ашгийн төлөө бус байгууллага бөгөөд бизнесүүдэд нэмүү өртгийг бий болгоход нь зөвлөх үйлчилгээ үзүүлж үр дүнтэй ажилладаг байгууллага юм. Түүнчлэн, цэвэр үйлдвэрлэлийн асуудлаар зөвлөхийн үүрэг гүйцэтгэн ажиллаж, нягт хамтын ажиллагаа, хамтын хүчин чармайлтаар туршлага олж авдаг байна.

#### **Өмнөд Африк - Ногоон үйлдвэрлэлийн Үндэсний төв**

Өмнөд Африкын Ногоон үйлдвэрлэлийн Үндэсний төвийг 2002 онд Йоханнесбург хотноо зохион байгуулагдсан Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын үеэр Өмнөд Африкын Худалдаа, аж үйлдвэрийн газар, Австрийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр үндэслэн байгуулсан. Газар дундын тэнгисийн өмнөд бүс - Газар дундын тэнгисийн эрэг орчмын аж үйлдвэрүүдийг “ногоон” болгох зорилготой.

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага нь байгаль орчинд ээлтэй, зохистой технологийг нэвтрүүлэх, эрэг орчмын үйл ажиллагаанаас үүдэн далайн ус ихээр бохирдож буй асуудлыг шийдвэрлэхэд Египет, Морокко, Тунис улсуудад туслалцаа үзүүлж байна.

#### **Африк тивийн Сахарын цөлөөс өмнө зүгт орших улсууд - Эко аялал жуулчлал**

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага нь Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (ДАЖБ)-тай хамтран далай, тэнгисийн эрэг орчмын газруудын хүрээлэн буй орчны доройтлыг сааруулж, тогтвортой байдлыг сайжруулах зорилготой ажиллаж байна. Энэ чиглэлийн төслүүд Камерун, Гамбия, Кени, Мозамбик, Нигери, Сенегал, Сейшелийн арлууд, Танзани улсуудад хэрэгжиж байна.

#### **Танзани - Ногоон үйлдвэрлэл**

НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллага болон Байгаль орчны хөтөлбөр нь Танзанид Нөөцийн үр ашигтай зарцуулалт, ногоон үйлдвэрлэл (товчоор RECP)-ийн туршилтын төслийг хэрэгжүүлэн, хүрээлэн буй орчны доройтлоос сэргийлэх стратегиудыг таниулж байна.

#### **Вьетнам - Ногоон үйлдвэрлэл**

Вьетнамын Ногоон үйлдвэрлэлийн Үндэсний төв нь 1998 онд Швейцарийн Эдийн засгийн асуудал эрхэлсэн нарийн бичгийн дарга нарын газрын санхүүжилттэйгээр Ханойн их сургуулийн дэргэд байгуулагдсан. Тус төв нь 2009 оны сүүлээр 16 ажилтантай байсан ба цаас, нэхмэл сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл, хүнс, далайн хүнс боловсруулах, метал өнгөлгөө, барилгын материал, химийн бодис, гар урлал зэрэг үйлдвэрлэлийн салбаруудад идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Эх сурвалж: <https://www.unido.org/our-focus/cross-cutting-services/green-industry/selected-unido-projects>

**СВИЧ Ази хөтөлбөр** нь Азийн орнуудад бизнес, эдийн засгийн янз бүрийн салбарт хүрээлэн буй орчинтой холбогдолтой гүйцэтгэлийг нь сайжруулах чиглэлээр 100 гаруй төсөлд дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, Монгол Улсад:

#### **Хонины ноосыг ашиглан байгальд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх, Нийлүүлэлтийн сүлжээ хөгжүүлэх нэгдсэн аргачлал**

Монгол хонины ноосны үйлдвэрлэлийн дийлэнх (90%) нь бүдүүн ширхэгтэй ноос байна. Ийм төрлийн ноосны зах зээлийн эрэлт маш бага бөгөөд бэлчээрийн мал аж ахуй эрхлэгч нарын хувьд бараг үнэгүй шахуу борлуулагдаж байна. Ийм ноосыг ихэвчлэн гэрийн дулаалга буюу хивс, эсгий

хийхэд ашигладаг учраас эрт цагаас барилгын материал болон ашиглагдаж байсан гэж хэлж болно. Хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх, ашиглах технологи нь Чех зэрэг Европын орнуудад дэлгэрсэн байдаг. Харин энэ дээр нэмэлт нөү-хау оруулж ирэх нь тус төслийн нэг гол үр өгөөж байв. Хонины ноосоор хийсэн барилгын дулаалгыг “ногоон”, байгальд ээлтэй, шинэлэг, нөөцийг үр ашигтай зарцуулах, ядуурлыг бууруулж эдийн засгийг хөгжүүлэх, агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад тустай бүтээгдэхүүн гэдэг утгаар нь тогтвортой нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход төслийн зорилго оршино.

Эх сурвалж: <https://www.switch-asia.eu/project/sheep-wool-for-building-material-swbm/>

### Бүтээгдэхүүн, түүний шошгыг сайжруулснаар Монголын зах зээл “ногоон” болно

Монгол орон дотоодын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн арвин түүхтэй. Гэвч бүтээгдэхүүнүүд голчлон чанар муутай байдаг. Үйлдвэрлэлд нөөцийн үр ашиггүй хэрэглээнээс гадна гаргах бохирдол дээр анхаардаггүй. Бүтээгдэхүүнээ тогтвортой хөгжлийн стандарт шаардлагад нийцүүлэн сайжруулах, үйлдвэрлэх, борлуулах талаар туршлага дутмагаас гадна Монголд сүүлийн үед нэвтрээд байгаа “ногоон” шошгын талаар ойлголт муутай байгаа нь үйлдвэрлэгчдийн өмнө тулгараад байгаа бэрхшээл юм. Монголд ЖДҮ, үйлдвэрлэлийн салбар хурдацтай өсөж байгаа хэдий ч зөвхөн ЖДҮ-д гэлтгүй, бодлого боловсруулахдаа ч тогтвортой хөгжлийн аргачлалыг мөрдөж ажиллах шаардлагыг бий болгож байна. Монголын үйлдвэрлэлийн салбар нөөц ашиглалт, бохирдол үүсгэхээс сэргийлэх тал дээр үр дүн муутай ажилладаг. Хэрэглэгч нар “ногоон” сонголтын тухай мэдээлэлгүй байна. Эко шошгожуулалтын асуудлыг нэлээн эрт “хөндсөн” боловч ярвигтай үйл явц, мэдлэг мэдээлэл муу, талуудын оролцоо сул зэргээс шалтгаалан амжилт олсонгүй. Тус төслийн зорилго нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын тулд “ногоон” бүтээгдэхүүн, дотоодын бүтээгдэхүүнүүдийг эко шошготой болгох ажлыг урагшлуулахад оршиж байв. Мөн Монгол Улсын магадлан итгэмжлэлийн стандарт, үйл явцыг бэхжүүлэн, тогтвортой бүтээгдэхүүний бизнес хөгжүүлэлт, сурталчилгааг дэмжих сүлжээг бий болгоход чиглэсэн.

<https://www.switch-asia.eu/project/green-products-development-and-wowэожуунаnm/>

## 6.1.2. Есо-шошго

Хэрэглэгч эко шошгын тусламжтайгаар өөрийн хүрээлэн буй орчин, нийгэмд тавигдах шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг сонгож чадна. Бизнес эрхлэгчдийн хувьд эко шошго бол бизнесийн бүтээмжийг хэмжих, аливаа нэг бүтээгдэхүүний байгаль орчинд сөрөг нөлөөгүй нь баталгаатай байгааг сурталчлах хэрэгсэл болох юм. Харин төрийн хувьд, эдгээр хэрэгслийн тусламжтайгаар үйлдвэрлэгчид ба хэрэглэгчдийн хандлагыг өөрчлөн, урт хугацааны тогтвортой байдлыг бий болгоход ашиглах боломжтой<sup>53</sup>.

Эко шошгын ач холбогдлыг олон улсын тавцанд хэдэн арван жилийн өмнө хамтдаа тогтвортой хөгжилд хүрэхийн тулд хийх ёстой нэг алхам хэмээн хүлээн зөвшөөрсөн. Өнөөдөр байгаль орчинд ээлтэй шошгололтын нэлээн хэдэн төрөл байгаа бөгөөд зарим төрлийг нь бүлгүүдэд хувааж Олон улсын стандартчиллын байгууллага (ISO) дараах ангилалд хуваасан байна.

- **ISO ТӨРӨЛ I** буюу эко-тэмдэг нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөг бүрт үзүүлэх байгаль орчны нөлөөллийг анхаарч, байгаль орчны чанарын олон шалгуур дээр суурилсан. Эко-шошго нь аливаа үйлдвэрлэгч юм уу үйлчилгээний байгууллагын өөрийнх нь байгаль орчинд ээлтэй гэх тэмдэг, тэмдэглэгээ, мэдэгдлээс огт ялгаатай бөгөөд эко-шошгыг зөвхөн найдвартай, гуравдагч этгээд шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгоно.
- **ISO ТӨРӨЛ I БУЮУ ИЖИЛ** хэмээх “магадлан итгэмжлэх схем” буюу “тогтвортой байдлын шошго” нь өмнөх төрөл I шошготой ижил зөвхөн тодорхой нэг асуудлыг тусгасан шинж чанартай. Гэхдээ илүү нарийн тодорхой нөлөөллүүд (жишээлбэл, эрчим хүч зарцуулалт, ХАА-н туршлага гэх мэт)-д төвлөрч, тодорхой нэг асуудлыг

<sup>53</sup> <https://www.unenvironment.org/explore-topics/resource-efficiency/what-we-do/responsible-industry/eco-labelling>

тусгагдаж (жишээлбэл эрчим хүч ашиглаж байгаа цахилгаан хэрэгсэл, ХАА-н бүтээгдэхүүн гэх мэт) байж ашиглагдана. “Органик шошго”, “Ширэнгэн ойн альяансын шошго” зэрэг нь үүний жишээ юм.

- Нэг талаар, **ISO ТӨРӨЛ II** буюу өөрийн зарласан мэдэгдэл нь бие даасан эрх бүхий байгууллагаас олгоогүй, байгууллагууд дотооддоо сайн дураар зохион бүтээсэн байгаль орчны холбогдолтой шошго юм (ихэвчлэн дан тэмдэг юм уу, зарим үед компанийн өөрийнх нь байгаль орчны холбогдолтой лого байна).
- Сүүлийн төрөл буюу **ISO ТӨРӨЛ III** буюу байгаль орчны нөлөөллийн шошго бол бүтээгдэхүүний тоон мэдээллийг дэлгэрэнгүй дурдсан бүтээгдэхүүний тайлбар юм. Ерөнхийдөө тухайн бүтээгдэхүүний шимт бодисын мэдээллийг агуулсан хүснэгттэй төстэй, матриц хэлбэрээр тавигдсан байна.

Үйл ажиллагаа нь жигдэрсэн эко-шошготой байгууллагууд, бие даасан компаниуд, тэдгээрийн байгаль орчны тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулж байгаа жишээ маш олон бий. Тэдгээрээс заримыг нь доор дурдлаа.

### **ХБОШ, Хятадад эрчим хүчний хэмнэлтийг хэмжив**

Хятадын байгаль орчны шошгожуулалт (ХБОШ буюу СЕС) хэмээх байгууллага нь төр худалдан авалт болон хэрэглэгчдийн ч хувьд чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн гэдэг утгаар нь хэвлэгчийн эрчим хүчний хэмнэлтийг хэмжихээр сонгон авчээ. Сонгосон хэвлэгч нь Үндэсний GB 21521-2014 стандартаар баталгаажсан, олон үйлдэлт төхөөрөмж бөгөөд ашиглах үед зарцуулагдах эрчим хүчний хэмжээнээс нь шалтгаалан хүрээлэн буй орчинд хамгийн их нөлөөлөл үзүүлж байна хэмээн тодорхойлогджээ. ХБОШ ойролцоогоор 3 сая орчим олон үйлдэлт төхөөрөмжид зөвшөөрөл олгож, 2018 онд 10 тэрбум орчим квт/цагийн хэмнэлтийг хийжээ.

Энэ төслөөс гарсан сургамж нь системчилсэн ажлын ач холбогдлыг ойлгуулсанд оршиж байна. Аргагүй боловсруулахаас авахуулаад, ангилал сонгох, өгөгдөл цуглуулах хүртэл алхам бүрийг нарийн тооцсон. Хамгийн том бэрхшээл бол лиценц эзэмшигчдээс зөвшөөрөл авах, зөв мэдээлэл цуглуулах байсан. Хэрвээ өгсөн мэдээлэл нь бодит байдал/хүлээлтээс хэтэрхий зөрүүтэй байвал тухайн аж ахуйн нэгжтэй холбогдон давхар нягталж байсан.

Эх сурвалж: <https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/global-ecolabelling-network-gen-magazine-edition-37.pdf>

### **GREENPRO, Энэтхэгт хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан байдлыг хэмжив**

Энэтхэг цемент үйлдвэрлэлээрээ дэлхийд хоёрдугаарт жагсдаг. Поцолана болон Портланд Слаг цементийн 70 гаран хувь нь GreenPro эко шошготой. Цементийн амьдралын мөчлөгийн туршид түүхий эд бэлтгэхээс эслэн үйлдвэрлэх шатанд ялгарч байгаа хүлэмжийн хийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд анхаарчээ. 2018 онд GreenPro нүүрсхүчлийн хийн ялгарлыг 6.5 сая тонноор буурсныг хэмжсэн. GreenPro-гийн өмнө тулгарч байсан бэрхшээл бол нөлөөллийг харьцуулах суурь түвшинг тодорхойлох явдал байсан. Өнгөрсөн гурван жилийн үндэсний стандарт, аж үйлдвэрийн өгөгдлүүд зэрэг янз бүрийн сонголтуудаас сонгон авч суурь болгон ашиглаж байсан. Хэд хэдэн янзаар ажиллаж үзсэний эцэст 2010 оны мэдээллийг нөлөөлөл хэмжих суурь түвшин гэж үзэх болсон. Энэ үйл явцын дүнд бид “суурь түвшинг тодорхойлох нь чухал бөгөөд ярвигтай ажил” гэдгийг мэдэж авсан. Суурь түвшин нь аливаа бүтээгдэхүүний хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг тоогоор илэрхийлэхээс гадна тус салбарынхаа тухай ойлголтыг сайжруулж, цаашлаад эко шошгыг хүлээн зөвшөөрүүлэхэд ач холбогдолтой гэжээ.

Эх сурвалж: <https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/global-ecolabelling-network-gen-magazine-edition-37.pdf>



## Скандинавын орнуудын “Хун” эко шошго

Скандинавын орнуудын “Хун” эко шошго нь Скандинавын орнуудын албан ёсны эко шошго юм. Үүнийг Скандинавын сайд нарын зөвлөл 1989 онд байгуулсан. Энэхүү эко шошгоны зорилго нь тогтвортой зарцуулалт, үйлдвэрлэлд нэмэр болох, “эко шошгыг гол хөдөлгүүрээ болгон, Скандинавын орнуудыг тогтвортой амьдралын хэв маягийн үлгэр жишээ бүс болгох” алсын хараатай болно. Скандинавын орнуудын эко шошго нь аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээний амьдралын мөчлөгийн турш хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, сайн дурын, гуравдагч этгээдээр магадлан итгэмжлэгддэг схем юм. Тус шошго нь бусад хүчин зүйлүүдээс гадна уур амьсгалын өөрчлөлтийн хүчин зүйлийг чухалчилдаг бөгөөд нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулсан бүтээгдэхүүн гэдгийг нь баталгаажуулдаг. Түүнчлэн, тодорхой нэр төрлийн бараа, ялангуяа нэхмэл сүлжмэл эдлэлийн эдэлгээ даах чанарын тухайд эргэлтийн эдийн засагт тавигдах шаардлагуудыг багтааж өгсөн.

“Хун” эко шошго бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авснаар хэрэглэгчид хүрээлэн буй орчиндоо тогтвортой байдлыг тогтооход хувь нэмрээ оруулж чадна. Тус шошго нь Скандинавын орнуудад нийт 20 000 гаруй бүтээгдэхүүн дээр тавигдсан, асар их амжилт олсон шошго юм. Энэ бүс нутгийн хэрэглэгчдийн 91 % нь “Хун” эко шошгыг мэднэ.

Эх сурвалж: <https://www.oneplanetnetwork.org/initiative/nordic-ecolabel-swan>

## ЕХ-ны Эко шошгын элч : Амралтын байр, сууц УТЈЕНА

Монтенегро дахь Амралтын байр, сууц УТЈЕНА нь дэлхийд хамгийн анх Европын холбоо (ЕХ)-ны нэр хүндтэй эко шошгоор шагнуулсан жуулчны хотхон юм. Энэ газар нь Монтенегро болон Европ даяар тогтвортой аялал жуулчлалын үлгэр жишээ болсон байгууллага юм.

2012 онд ЕХ-ны Эко шошгын эзэн болсон цагаасаа хойш Амралтын байр, сууц УТЈЕНА нь эрчим хүчний хэмнэлт хийх тал дээр чухал алхмууд хийж, байшингууддаа нарны зайгаар ажилладаг ухаалаг утас цэнэглэгч “Ginko” хэмээх төхөөрөмжүүдийг суурилуулжээ. “Нүүрсхүчлийн хийн ялгарлыг саармагжуулах аялал жуулчлалын төлөө” (Towards Carbon Neutral Tourism) үндэсний төслийн оролцогч тал болохынхоо хувь тус компани нь зөвхөн эрчим хүчний хэмнэлттэй гэрлийн чийдэн хэрэглэх зэргээр нүүрсхүчлийн ялгарлыг бууруулах талаар дорвитой ажиллаж байна. Жуулчны хотхоны эзэмшигч Майкл Бэйдэр нь ариун цэврийн цаас, саван, шампуниас эхлээд бүх бүтээгдэхүүн, хэрэгслүүд ЕХ-ны эко шошготой байх ёстой гэсэн зарчмаар худалдан авалт хийдэг байна. “ЕХ-ны эко шошгын эзэн болсон явдал нь манай байгууллагын хувьд Баруун Европын зах зээл рүү нэвтрэхэд тус болсон. Ногоон аялал жуулчлал бол тренд төдий биш, харин манай салбарын ирээдүй юм. Тогтвортой байдлын төлөөх хичээл зүтгэлийн маань хамгийн том илрэл нь ЕХ-ны эко шошго мөн” (“Амралтын байр, сууц УТЈЕНА” хотхоны эзэмшигч Майкл Бэйдэр)

Эх сурвалж: [https://ec.europa.eu/environment/ecolabel/documents/Success\\_story\\_Utjeha.pdf](https://ec.europa.eu/environment/ecolabel/documents/Success_story_Utjeha.pdf)

Ази Номхон далайн зарим орнуудад эко шошго тавих явдал эрчимтэй хэрэгжиж байгаа бөгөөд цаг өөрчлөгдөх тусам улам хөгжиж байна.

## Өмнөд Солонгос

Байгаль орчны яамны санаачилгаар 1992 онд “Солонгосын Эко шошгожуулалт” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. 1994 онд Хүрээлэн буй орчны технологийн хөгжил ба дэмжлэгийн тухай хууль батлагдсанаар энэхүү хөтөлбөрийн эрхзүйн үндсийг тавьж өгөв. Солонгос улс Даян дэлхийн эко шошгын сүлжээ (Global Ecolabelling Network, GEN)-д 1997 онд нэгдэн орж, 2005 он гэхэд худалдан авалт хийхдээ заавал байгаль орчинд ээлтэйг нь сонгохыг журамлажээ. Ингээд 2011 онд GENICES гэрчилгээ хэмээх Олон улсын стандартын гэрчилгээг хүртсэн. Харин 2012 онд тус улс 151 шалгуур үзүүлэлтийг боловсруулж, 8,166 бүтээгдэхүүнд эко шошго олгосон байна.

Эх сурвалж: [https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report\\_on\\_key\\_opportunities\\_for\\_pilot\\_products\\_with\\_policies\\_and\\_challenges.pdf](https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report_on_key_opportunities_for_pilot_products_with_policies_and_challenges.pdf)

## Сингапур

Сингапурын эко шошгын схемийг Сингапурын байгаль орчны зөвлөх 1999 оноос хойш хариуцан ажиллаж байна. Үүнийг Сингапурын ногоон шошгын схем (СНШС) гэдэг бөгөөд тус улсын байгаль орчны стандарт, магадлан итгэмжлэлийн тэргүүн зэргийн чанарын тэмдэг юм. 2011 онд аудитын шалгалтаар орж ISO 14024, ISO зааварчилгаа 65 стандартуудыг ханган, мөн оныхоо 10 дугаар сард дээрх GENICES-ээр магадлан итгэмжлэгдсэн. Гадаад, дотоодын ямар ч компани СНШС-д бүртгүүлж болно. Тус схем нь бүтээгдэхүүний 65 ангилалтай.

Эх сурвалж: [https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report\\_on\\_key\\_opportunities\\_for\\_pilot\\_products\\_with\\_policies\\_and\\_challenges.pdf](https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report_on_key_opportunities_for_pilot_products_with_policies_and_challenges.pdf)

## Хятад

Хятадын эко шошгын хөтөлбөрийг 1994 онд Улсын байгаль орчин хамгаалах газар (одоогийн Байгаль орчин хамгаалах яам - Хятадын БОЯ)-ын санаачилгаар байгуулж байжээ. Энэ хөтөлбөр нь төрийн эзэмшлийн, сайн дурын үндсэн дээр эко шошго олгох схем юм. Хятадын байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний шошго, Хятадын байгаль орчны нэгдсэн магадлан итгэмжлэлийн төв (ХБОНМИТ) нь БОЯ-ны мэдэлд байдаг бөгөөд бүтээгдэхүүнд магадлан итгэмжлэх олгох үүргийг хамаардаг. Төрөл I шошгыг БОЯ-наас баталсан техникийн стандартад нийцсэн бүтээгдэхүүнд олгоно. Тодорхой стандартын ангилалд орохгүй бүтээгдэхүүний хувьд төрөл II шошгыг авахаар хүсэлт гаргаж, ХБОНМИТ баталгаажуулна. Хятадын эко шошгын хөтөлбөр нь хөгжлийнхөө 18 жилийн туршид 2,000 компанийг хамруулж, 40,000 бүтээгдэхүүнийг магадлан итгэмжилсэн байна. Тус хөтөлбөр 2013 он гэхэд 85 ангиллын бүтээгдэхүүнийг магадлан итгэмжлэх стандартад болжээ.

Эх сурвалж: [https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report\\_on\\_key\\_opportunities\\_for\\_pilot\\_products\\_with\\_policies\\_and\\_challenges.pdf](https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report_on_key_opportunities_for_pilot_products_with_policies_and_challenges.pdf)

## Япон

Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор эко шошго бүхий бүтээгдэхүүнүүдийг ашиглах тал дээр бүс нутагтаа анхдагч юм. Японы төрөл I Эко тэмдэг хөтөлбөрийг Японы Байгаль орчны холбоо 1989 онд байгуулсан нь эко шошгоны анхны хэлбэр юм. Энэхүү төрөл I эко шошгыг 47 ангиллын 4,500 орчим бүтээгдэхүүнд олгож байна (2009 оны гуравдугаар сарын мэдээгээр). Мөн заавал ашиглах шошгын хөтөлбөр, төрөл II, төрөл III эко шошгууд нь Японы зах зээл дээр нийтдээ 100 гаруй бүтээгдэхүүнд олгогджээ.

Эх сурвалж: [https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report\\_on\\_key\\_opportunities\\_for\\_pilot\\_products\\_with\\_policies\\_and\\_challenges.pdf](https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/report_on_key_opportunities_for_pilot_products_with_policies_and_challenges.pdf)

### 6.1.3. Тогтвортой байдлын тайлагнал

Хөгжингүй ба хөгжиж буй олон орны зах зээлд хувийн хэвшлээс ил тод, хариуцлагатай байхыг улам ихээр шаардах болсон. Компаниуд, тэдний үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл нь тухайн компаниудыг бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйл ажиллагааныхаа хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлын мэдээллийг боловсруулж, үнэлж, ил болгоход чиглүүлж байна. Энэ утгаараа **Компанийн тогтвортой байдлын тайлагнал** нь мэдээллийг үүсгэж, даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гаргаж байгаа ахиц дэвшил, хувь нэмрийг үнэлэх боломжит механизм болж, үүгээр дамжуулан бусад компани, байгууллагууд тогтвортой хөгжлийн үзүүлэлт бүрээр өөрийн гүйцэтгэлээ үнэлэх боломжтой. Ингэснээр тодорхой зорилго тавьж, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, нөөц ашиглалт сайтай, оролцоог хангасан, “ногоон” эдийн засгийг бий болгохын төлөө ажиллана. Тогтвортой хөгжлийн зорилгын 12.6 дахь зорилт нь компаниудын тогтвортой байдлын тайлагналын асуудал дээр төвлөрдөг.

Дэлхийн хамгийн том нийгмийн хариуцлагын санаачилга болох НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, тогтвортой байдлыг тайлагнах асуудлаар дэлхийд тэргүүлэгч Даян дэлхийн

тайлагналын санаачилга (ДДТС буюу GRI) энэ ажлын өмнө тулгараад байгаа сорилтуудыг хамтран шийдвэрлэх платформыг бий болгожээ<sup>54</sup>. Тус платформ нь ЖДҮ эрхлэгч нарт зориулан дараах хоёр хэрэглүүрийг боловсруулжээ. Үүнд:

- “Зорилго ба зорилтын дүн шилжилгээ” хэмээх тайлан<sup>55</sup> нь компаниудын ТХЗ ба түүний зорилтуудад үзүүлж буй нөлөөллийг тогтвортой байдлыг илтгэх үзүүлэлтүүдийг энгийн, ойлгомжтой байдлаар жагсаан үзүүлсэн.
- Компанийн тогтвортой байдлын тайланд ТХЗ-уудыг нэгтгэх зааварчилгаа<sup>56</sup> нь компаниудад одоогийн баримталж байгаа үйл ажиллагаа, тайлангийн үйл явцдаа ТХЗ-уудыг тусган, ДДТС-ийн стандарт болон хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудад нийцүүлэх гурван алхмыг тусгаж өгсөн.

## 6.2. ТОГТВОРТОЙ ХУДАЛДАН АВАЛТ

Эдийн засаг хурдацтай өсөхийн хэрээр зарцуулалт, үйлдвэрлэл ихсэж, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөн, нөөцийн хомсдол, бохирдол, орчны доройтол үүсгэж, уур амьсгалын өөрчлөлтөд нэрмээс болж байгаа нь зарим Азийн орнуудад ажиглагдах болсон.

Төрийн зарцуулалт аливаа улсын ДНБ-ий дунджаар 15-30%-ийг эзэлж байдаг учраас төрөөс явуулах худалдан авах үйл ажиллагааг төрийн тогтвортой худалдан авах ажиллагаа (ТХА) хэлбэрээр зохион байгуулвал инновац, тогтвортой байдлыг сайжруулахад зах зээлийг чиглүүлэхэд чухал хөшүүрэг болж чадна.

### Тогтвортой төрийн худалдан авалтын ашиг тус

ТХҮ-г хэрэгжүүлэхэд цаг хугацаа, хүний нөөц, санхүүжилт гаргахаар үүрэг хүлээснээр улс орнуудад дараах боломжууд бий болно. Үүнд:

- А. Үндэсний бодлогын өргөн хүрээний зорилтуудыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой:** Засгийн газарт төрийн худалдан авалтаар илүү тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний хэв маягийг дэмжих томоохон боломжийг олгож байна гэсэн үг юм. Төр худалдан авалтын ажиллагаа хэрэгжүүлэхдээ “үлгэр дуурайлал” үзүүлэх боломжтой. Ингэснээр тогтвортой хөгжлийг цогцлооход дэм болох эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ зах зээлийг нээгдэхэд нэмэртэй болно.
- Б. Байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулах:** Засгийн газруудын худалдан авах ажиллагаа нь байгаль орчинд ихээхэн нөлөө үзүүлдэг. Тогтвортой худалдан авалтын бодлогоо батлан, хэрэгжүүлснээр цаг уурын өөрчлөлт, усны чанар, хог хаягдал зэрэг хүрээлэн буй орчны өргөн хүрээний асуудал, нөлөөллийг бууруулахад тустай. Бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү тогтвортой байдлаар сонгон, худалдан авч, хэрэглэх нь эдгээрийн хэрэгцээт байдлын талаар ойлгомжтой “дохиог” зах зээлд өгч, улмаар энэ нь байгаль орчны гүйцэтгэлийг сайжруулахад хөтөлнө.
- В. Санхүүгийн өгөөжтэй байх:** ТХА нь байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах үр дүнтэй арга төдийгүй худалдан авагчид зардал хэмнэхэд ө.х. худалдан авалтын үйл ажиллагааны зардал тооцох, эсвэл буцаах шийдлийг хэрэглэхэд, тустай.
- Г. Илүү тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийг хөгжүүлэх:** Байгаль орчны бараа, үйлчилгээний дэлхийн зах зээл 1.3 их наяд доллартай тэнцэж, тасралтгүй өсч байна. Илүү тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгох замаар ТХА-г дараахь зорилгоор ашиглаж болно.
  - Өрсөлдөөнийг өдөөх;
  - Тохиромжтой технологийн зах зээлийг бий болгох (ө.х. заавал өндөр технологийн шийдэл

<sup>54</sup> <https://www.globalreporting.org/information/SDGs/Pages/Reporting-on-the-SDGs.aspx>

<sup>55</sup> [https://www.globalreporting.org/resource/library/GRI\\_UNGC\\_Business-Reporting-on-SDGs\\_Analysis-of-Goals-and-Targets.pdf](https://www.globalreporting.org/resource/library/GRI_UNGC_Business-Reporting-on-SDGs_Analysis-of-Goals-and-Targets.pdf)

<sup>56</sup> [https://www.globalreporting.org/resource/library/GRI\\_UNGC\\_Reporting-on-SDGs\\_Practical\\_Guide.pdf](https://www.globalreporting.org/resource/library/GRI_UNGC_Reporting-on-SDGs_Practical_Guide.pdf)

байх албагүй);

- Шинэлэг тогтвортой шийдлүүдийн зах зээлийг өргөжүүлэх;
- Зах зээлтэй эртхэн холбогдон, харилцаа бий болгохыг дэмжих; болон
- Орон нутгийн зах зээлээс нийлүүлж буй барааны эрэлт хэрэгцээний өсөлтийг дэмжих, улсын секторын худалдан авсан тогтвортой бүтээгдэхүүнийг бие даасан хэрэглэгчдэд илүү хялбар болгох замаар оролцогч талуудтай яриа хэлэлцээг сайжруулах. (UNEP2: 7-11-с засварлан авав)

Хятад, Япон, Тайланд, Солонгос улсын төрийн “ногоон” худалдан авалт ба эко шошгын хөтөлбөрүүдийг харьцуулсан дүн шинжилгээ: Сургамж ба Амжилтад хөтөлсөн нийтлэг хүчин зүйлүүд (2017) хэмээх тайланд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр: “Төрийн тогтвортой худалдан авах ажиллагааг хэрэгжүүлснээр засгийн газрууд өөрсдөө үлгэр дуурайл болж, бодлогын чухал зорилтуудаа олон нийтэд хүргэж болно. ТХА нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүч, усыг үр ашигтай зарцуулах, дахин боловсруулалтыг дэмжих зэрэг хүрээлэн буй орчны зорилгуудаа гүйцэлдүүлэх боломжийг төрд олгоно. ТХА нь нийгмийн сайн сайханд, ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн үндсэн стандартуудад хандуулах анхаарал, зарцуулах хөрөнгө мөнгийг нэмэгдүүлэх зэргээр хувь нэмэр оруулж болох юм. Эдийн засаг талаасаа орлогын эх үүсвэрийг бий болгож, зардлыг хэмнэж, үр чадвар, технологийг нутагшуулах ач холбогдолтой” хэмээн онцлон тэмдэглэсэн байна (UNEP2: 7)

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ) 2015 онд “Ногоон” Хувьсгал - Тогтвортой худалдан авалтын сайн туршлагауд хэмээх, дэлхийн өнцөг булан бүрээс цугларсан тогтвортой худалдан авалтын жишээнүүдээс бүрдсэн тайланг танилцуулсан юм. Хоёр жилийн дараа, 2017 онд НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс гаргасан тус тайланд Хятад, Япон, Тайланд, Солонгос улсын төрийн худалдан авах ажиллагааны хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээгээр баяжуулан дахин танилцуулжээ. Эдгээр тайлангууд нийлээд, ТХА-г амжилттай хэрэгжүүлэх зургаан ерөнхий зөвлөмжийг хүргүүлсэн. Эдгээр зөвлөмжийг бусад оролцогч талууд ач холбогдолтой хэмээн дүгнэжээ:

1. **ТХА-д зориулсан эрхзүйн ба бодлогын баримт бичгүүдийг боловсруулах замаар аж ахуйн нэгжүүдэд худалдан авах ажиллагаандаа НХА-ийг тусгах үйл явцад тус нэмэр болох.** Дээр дурдсан баримт бичгүүдийг боловсруулахдаа аж ахуйн нэгжүүдийг тавьсан зорилгодоо хүрэхэд нэмэр болохуйц, ойлгомжтой тодорхойлолт, зорилт, тэргүүлэх чиглэлүүдийг тодорхой зааж өгөх нь чухал. Эрхзүйн үндсийг нь ул суурьтай тавьж өгөхийн тулд төрийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй. Төрийн худалдан авах ажиллагааг тогтвортой болгохын тулд засгийн газрын түвшинд дэмжлэг үзүүлэн, манлайлж ажиллах нь чухал. (UNEP3:17)
2. **ТХА-г төлөвлөх, түүний дотор зах зээлийн чадамж, техникийн шийдлүүдийг ойлгохын зэрэгцээ, ТХА-ын зардал, үр өгөөжийг үнэлэх.** Одоо байгаа “ногоон” шийдлийн нөөц бололцоо, нийлүүлэлтийн хүчин чадлыг хэмжиж үнэлэхэд оролцогч талууд болон нийлүүлэгч нартай зөвлөлдөх шаардлагатай. Мөн нийлүүлэлтийн зах зээлтэй хэрхэн харилцах, зардал хэмнэх дүн шинжилгээ хийхдээ төрийн байгууллагын удирдлагууд бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн өртгийн үнэлгээг хэрхэн ашиглах талаар зааварчилгаа байвал үйл явцыг түргэсгэж өгнө.
3. **Техникийн тодорхойлолт, худалдан авалтын сонголт хийх, шалгаруулалтад тавигдах шалгуур үзүүлэлтүүд, гэрээний гүйцэтгэлийн актад байгаль орчны стандартыг нэвтрүүлэх.** НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс гаргасан жишээнүүд дээр гүйцэтгэлд суурилсан ямар гэрээ, төлбөрийн нөхцөл нь инновацлагдсан “ногоон” шийдэлд олгох татаасыг авч чадах вэ гэдгийг хүртэл тусгаж өгсөн байна. Ямар бүтээгдэхүүн үйлчилгээг “ногоон” гэж үзэх вэ гэдгийг тодорхойлох батлагдсан стандартууд байна. Тухайлбал, байгаль орчны зорилгоо биелүүлэх урьдчилсан нөхцөл болох эко шошго юм гэх мэт (UNEP3). Эко шошгын схем нь ажилтнуудад төрийн


тогтвортой худалдан авах ажиллагааг илүү хялбар хэрэгжүүлэх, “ногоон” зах зээлийн дэмжихэд тус болно (ДХБ).

4. **НХА-аар мэргэшүүлэх, нөү-хау, ур чадварыг дээшлүүлэх.** ТХА-г хэрэгжүүлэхэд мэргэшсэн мэдлэг, олон талын ур чадвартай баг хамт олон шаардлагатай. Худалдан авах ажиллагааны боловсон хүчин, бусад оролцогч талуудын чадавхыг дээшлүүлэх нь нэн чухал. Тэдний “ногоон” худалдан авалтын үйл явцын талаар илүү их мэдлэгтэй болгох зорилгоор хэрэгжүүлэгч байгууллага сургалт явуулах хэрэгтэй. Сургалт явуулж, зааварчилгаа өгснөөр ажлын үр дүнгийн талаар тод томруун ойлголттой, мэдлэгтэй болно (UNEP3:17).
5. **НХА-ын шийдлүүд, бизнес эрхлэгч, хэрэглэгч, иргэний нийгэмд түүний ашиг тусын талаар ойлголт бий болгох.** ТХА-г зохион байгуулж байгаа төрийн албан тушаалтнууд болон олон нийтэд зөв ойлголт өгөхөд чиглэсэн дорвитой үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь ТХА-г амжилттай хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй. Хэрэгжүүлэгч байгууллага нь бизнес эрхлэгчдийг “ногоон” шийдэлд уриалах, иргэдийн “ногоон” бодлогыг дэмжих сэтгэлийг нь бадраах гэх мэт мэдээлэл-сурталчилгааны арга, хэрэгслийг боловсруулах хэрэгтэй (UNEP3).
6. **НХА-н үр дүнг хянаж, бодлого, дүрэм журамд доголдол байгаа бол залруулах.** Нийгэм ба хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг эерэг байлгахын тулд хяналтын систем зайлшгүй хэрэгтэй. Хэрэгжилтийг зөв хянаж, үнэлэх систем байснаар хөтөлбөрийг дунд ба урт хугацаанд хянах, дүгнэх боломжтой болно (UNEP3). Хяналт, шинжилгээ, үнэлгээний систем нь зөв байж чадвал ТХА-ын давуу талуудыг гарган тавьж, бодлого боловсруулагч нарт зөв зөвлөмж хүргүүлэх боломжтой (OECD1). ‘Тогтвортой худалдан авалтын хэрэгжилтийн мониторинг’ хэмээх тайландаа НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр нь ТХА-ын ХШҮ-ний системийг хэрхэн бий болгох тухай зөвлөмжийг оруулсан байдаг. Түүнийг зураг ХХ-д үзүүлэв. “ТХА-г хэрэгжүүлэх санаачилга өндөр түвшинд дэмжигдэж байгаа л бол Засгийн газар хяналт-үнэлгээний зохистой системтэй болох шаардлагатай. Ийм системтэй болоход маш өргөн хүрээнд, олон талын хүчин зүйлийг авч үзэх хэрэгтэй болно.” (UNEP29: 13)



“Зохицуулалттай, бодлогын удирдамж бүхий НХА-ны бат тогтолцоотой байх нь ногоон бүтээгдэхүүн худалдан авалтын явцыг түргэсгэх, НХА-т тулгарах саад бэрхшээлийг давахад хүчтэй хэрэгсэл болдог. Зохицуулалтын тогтолцоо нь ногоон шийдлийг хөгжүүлэхэд түлхэц болох зах зээл татахыг нэмэгдүүлж, ногоон шийдлийг хөгжүүлэхэд түлхэц болно.”(OECD1: 10)

Зураг 11: Алхам алхамаар хэрэгжүүлэх ТХА-ын аргачлал



Эх сурвалж: (UNEP29: 13)



НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс эрхлэн гаргасан ТХА-г хэрэгжүүлэх зааварчилгаа (2012) нь улс орнуудад ТХА-г хэрэгжүүлэхэд чиглүүлсэн, боловсруулахаас эхлээд бодлогын төлөвлөгөө хэрэгжүүлэх хүртэлх шат дараалсан арга хэмжээний зааврыг багтаасан юм. **Зураг 11**-т үзүүлсэнчлэн, энэ үйл явцын эхнээс нь төгсгөл хүртэл сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулсаар байх шаардлагатай (UNEP2: 12).

### Жишээ 1: Японы эко марк

Японы Байгаль орчны холбоо бүтээгдэхүүний байгаль орчны нөлөөллийн талаар хэрэглэгчдэд мэдээлэл өгч, тэднийг илүү байгальд ээлтэй худалдан авалтад уриалах зорилгоор сүүлийн 20 гаруй жилийн турш Эко марк гаргаж байна. Энэхүү төслийг тус улсын Байгаль орчны яам санхүүжүүлж, үйлдвэрлэгчдэд гэрчилгээ олгодог. Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн турш буюу түүхий эдийг гарган авч, үйлдвэрлэлд оруулж, хэрэглэж, хаях хүртэлх бүх процесс байгальд ээлтэйг нотлох олон төрлийн шошго Эко марк төслийн хүрээнд бий болсон. Бүтээгдэхүүний төрөл тус бүрийн шалгуурыг үйлдвэрлэгч, хэрэглэгч болон бусад оролцогч талуудтай хамтран ажилласны үндсэн дээр тогтоодог. Байгальд ээлтэй бүтээгдэхүүн нийгэмд илүү танигдаж, энэ төрлийн шошготой бүтээгдэхүүн болон шошгийг ашиглаж буй үйлдвэрлэгчдийн тоо нэмэгдсээр байгаа нь хэд хэдэн амжилттай хэрэгжүүлсэн арга хэмжээтэй холбоотой. Үүнд: хэвлэн мэдээлэх, кампанит ажил, уулзалтууд, шошгийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах ажил, шагнал, урамшуулал олгох хөтөлбөр, олон улсын бусад шошгуудтай хамтран ажиллах (харилцан хүлээн зөвшөөрөх замчмаар) зэрэг ажлууд багтаж буй юм. Эко гэрчилгээний схем нь байгаль орчны талаарх нийгэмд ойлголт бий болгох, улам түгээхэд дэмжлэг болдог. Энэ нь мөн компаниудад зах зээлд бусдаас онцгойрох давуу талаа харуулах, тогтвортой хэрэглээг илүү дэмжсэн, чанарын стандарттай стандарт бүхий ил тод бүтээгдэхүүнээр иргэдийг хангахад тустай.

### Зураг 12: ТХА-ын хяналтын системийг бий болгох үндсэн алхамууд



\* Энэ чиглэлийн зөвлөмжүүдийг ТХҮ-ийн 10 жилийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан ТХҮ-ийн үр ашгийг хэмжих, суртачлах ажлын хэсэг боловсруулна.



Түүнчлэн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн тайланд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хөндөөгүй хоёр зөвлөгөөг тусгасан байдаг. Энэхүү хоёр нэмэлт зөвлөгөө нь:

- 1. Бүтээгдэхүүний шалгуурыг тодорхой болгох нь төрийн худалдан авах ажиллагаанд байгальд ээлтэй бүтээгдэхүүний худалдан авалтыг хялбар болгож, төрийн агентлагуудын бодлогын хэрэгжилтийг хурдасгадаг.** Хэрэгжүүлэгч агентлагууд байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг худалдан авахдаа хамгийн хэрэгтэй байгаа бүтээгдэхүүнд төвлөрч, бүс нутгийн байгаль орчны асуудал болон орон нутгын бусад хүчин зүйлсийг бодолцох хэрэгтэй. Түүнчлэн эко бүтээгдэхүүний мэдээллийн санг бий болгож, бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлтүүд, байгальд ээлтэй бүтээгдэхүүний худалдан авах ажиллагааны зөвлөмжийг веб хуудастаа нийтэлж, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хөнгөлөх нь сонгон шалгаруулалтын үеэр худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтнуудад илүү “ногоон” сонголт хийхэд хялбар болгодог (UNEP).
- 2. Олон нийттэй харилцах, сурталчилгаа явуулах нь эхэн үед нэн чухал бөгөөд цаашид ч үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай байдаг.** Төрийн худалдан авах ажиллагааг тогтвортой болгох ажлыг хэрэгжүүлэхэд ихэнхдээ өөр өөр сорилтууд тулгардаг бөгөөд асуудлыг нь ойлгуулж, тухайн ажлыг дэмжүүлэхийн тулд бүх шатны оролцогч талуудад мэдээлэл олгож, сургаж, тусалж, дэмжих шаардлага гардаг. “Ногоон” бүтээгдэхүүн худалдан авах ажиллагаа хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагуудад эдийн засгийн урамшуулал олгох замаар ТХА-г сурталчилж болно. Мөн ТХА-ийн тодорхой ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн байгууллага, бизнес эрхлэгчид, хэрэглэгч нарт ногоон бүтээгдэхүүнээ сурталчлах, худалдан авагчид болон хэрэглэгчдэд байгальд ээлтэй бүтээгдэхүүнийг таниулах боломж олгох мэдээлэл-сурталчилгааны кампанит ажил, үзэсгэлэн, хурал зохион байгуулж болно. (UNEP3:17)



**“Шийдвэр гаргах, процедурын үйл ажиллагаа, тухайлбал худалдан авах ажиллагаанд өөрчлөлт хийх нь цаг хугацаа, ур чадвар, манлайллыг шаарддаг. Томоохон, нарийн төвөгтэй зохион байгуулалттай байгууллагууд ч гэсэн ТХА-г амжилттай хэрэгжүүлэхэд бодит байдалд техникийн өөрчлөлт хийхээс илүүтэйгээр соёлын өөрчлөлт хийх шаардлагатай болдог.” (UNEP4: 56)**

## Жишээ 2: Тайландын Засгийн газрын Ногоон худалдан авалтын хяналт

Сурталчлагч: Тайланд улсын Засгийн газар, Нөөц баялаг, байгаль орчны яамны Бохирдлын хяналтын газар

Төрийн албаны зорилтот байгууллага: Засгийн газрын агентлагууд (Эхний төлөвлөгөө); орон нутгийн захиргааны байгууллагууд, төрийн байгууллагууд, их сургуулиуд (Хоёр дахь шатны төлөвлөгөө)

Хэрэгжүүлэлт: Сайн дурын

### Суурь мэдээлэл

Тайландын Засгийн газрын Ногоон худалдан авалтыг дэмжих ажил 2005 оноос эхлэлтэй. Тухайн үед Нөөц баялаг, байгаль орчны яамны Бохирдлын хяналтын газраас Засгийн газрын худалдан авах ажиллагаанд байгаль орчны шалгуур нэвтрүүлэх баримт бичгийг боловсруулж эхэлсэн байдаг. Үүнд яам дотроо хэрэгжүүлэх НХА-ны шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх эхний ажлуудын жагсаалтыг багтаасан байсан. Энэхүү бодлогыг нийтэд сурталчилснаар Үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө (2007-2011), Байгаль орчны чанарын менежментийн төлөвлөгөө (2007-2011)-нд НХА-г багтаасан байдаг бөгөөд үүнд байгальд ээлтэй бараа, бүтээгдэхүүний зохистой зах зээлийг бий болгохын тулд Засгийн газрын байгууллагууд нь ногоон худалдан авалтыг түүчээлэгч байх хэрэгтэй гэж заасан байдаг. Засгийн газар нь НХА-г сурталчлах төлөвлөгөөний тогтоолыг 2008 оны 1-р сарын 22-ны өдөр баталж, энэхүү зорилтоо үргэлжлүүлэн дэмжсэн. Улмаар бий болсон эерэг үр дагаварт тулгуурлаж 2012 онд хоёрдугаар шатны Ногоон худалдан авалтын

төлөвлөгөөний (2013-2016) төслийг боловсруулж, НХА-г үргэлжлүүлэн дэмжсэн бөгөөд ингэхдээ төрийн албаны бүх шатлалыг хамруулсан байдаг (нийслэлээс орон нутгийн захиргаа хүртэл). Хоёрдугаар шатны төлөвлөгөөг Байгаль орчны танхим баталсан ч Засгийн газрын тогтоол хүлээгдэж байгаа. Гэхдээ Нөөц баялаг, байгаль орчны яамны Бохирдлын хяналтын газар (БХГ) аль хэдийн хэрэгжүүлж эхлээд байгаа юм байна.

### **Тогтвортой худалдан авалтын арга хэмжээ, зорилтууд**

Ногоон худалдан авах ажиллагааг сурталчлах төлөвлөгөөний гол зорилт нь Засгийн газрын байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтыг нэмэгдүүлэх. Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд зорилтот агентлаг болон ногоон худалдан авалтыг хэмжээний явцын зорилтуудыг тодорхойлсон.

### **Хяналтын систем**

Бодлогын зорилтуудыг хянахын тулд БХГ нь 2009 онд сайн дурын хяналтын смстем бий болгож, дараах зүйлст анхаарав. Үүнд:

- агентлагуудад хэрэгжүүлж буй албан тушаалтнуудын тоо;
- тодорхой жагсаалтад багтсан ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгийн худалдан авалтын түвшин;
- ногоон бүтээгдэхүүн худалдан авалтын түвшинд үндэслэн БХГ нь Үндэсний шинжлэх ухаан, технологийн хөгжлийн агентлагтай (ҮШУТХА) хамтран ажиллаж дараах тооцооллуудыг мөн хийж байна. Үүнд: ногоон бүтээгдэхүүн худалдан авахад бий болж буй тогтвортой байдлын үр өгөөжийн тооцоолол ба зах зээлд хүртээмжтэй байгаа ногоон бүтээгдэхүүнд оруулж буй хувь нэмэр.

### **Хэрэгжүүлэгч агентлагуудын тоог хянах нь**

Хэрэгжүүлэгч агентлаг гэж хүлээн зөвшөөрөхийн тулд БХГ нь дараах шаардлагуудаас алийг нь ямар байдлаар хэрэгжүүлж байгааг хянадаг ба багадаа нэгийг нь хэрэгжүүлэх ёстой байдаг: тухайн агентлаг нь хэрэгжүүлэх тунхаг бичигт, аль эсвэл түүнтэй дүйцэх албан бичигт гарын үсэг зурсан байна; үүнийг НХА-ын веб хуудсанд бүртгүүлсэн байх бөгөөд энэ нь тайлан гаргах системд нэвтрэх боломжтой болгоно; НХА-ын сургалт, семинарт хамрагдсан байна; НХА-ын тайлантай холбоотой мэдээллийг хүргүүлсэн байна.

### **Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтын түвшинг хянах нь**

Ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтын бодит түвшинг бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр нь ангилж (нийт 17) тодорхой эрэмбэлсэн дараалалтайгаар хянадаг. Ногоон гэж хүлээн зөвшөөрүүлэхийн тулд худалдан авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Тай эко шошго (Thai Ecolabel), Ногоон навч (зочид буудлын Green Leaf), аль эсвэл БХГ-ийн боловсруулсан байгаль орчинд ээлтэй худалдан авах ажиллагааны шалгуурыг хангасан байх шаардлагатай. Мөн БХГ-аас боловсруулсан эхний хоёр шалгуурын (Тай эко шошго, эсвэл НХА-ын шалгуурыг хангаж, гэрчилгээ авсан) аль нэгийг хангасан зах зээл дээрх бүтээгдэхүүнийг жагсаасан НХА-д холбогдох бүтээгдэхүүний санд багтсан байж болно. Тооцоолох үзүүлэлтүүд нь:

- тодорхой ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авсан хэмжээ (нэгжээр болон үнийн дүнгээр);
- ижил төрлийн бүтээгдэхүүн/үйлчилгээг нийт ногоон бүтээгдэхүүн/үйлчилгээний худалдан авалттай харьцуулсан хувь хэмжээ;
- тайлагнах ажлыг хялбар, нэгэн жигд байлгах зорилгоор БХГ нь цахимаар тайлан хүргүүлэх систем бий болгож, цаасаар ч мөн хүлээн авах боломжтой болгосон. Хэрэгжүүлэгч агентлагуудад 6 сар тутамд худалдан авах ажиллагааныхаа нэгдсэн тайлангаа хүргүүлэх хүсэлт хүргүүлдэг. Худалдан авах ажиллагаа нь Засгийн газартаа төвлөрөөгүй тул агентлаг тус бүр нь өөрсдийн худалдан авах ажиллагааг мэдээллийн нэгдсэн сангийн тусламжтайгаар бие даан хариуцаж, дараа нь тайлагнах зорилгоор худалдан авалтуудыг өөрсдийн механизмаар хянадаг.

### **Ногоон худалдан авалтын тогтвортой байдлын үр өгөөжийг дүгнэх нь**

НХА-ын үр өгөөжийн талаар санал солилцож, цааш түгээхийн тулд 2012 онд нэгдүгээр төлөвлөгөө дууссаны дараа БХГ болон ҮШУТХА-с ногоон бүтээгдэхүүн худалдан авахын үр ашиг, тогтвортой байдалд оруулж буй хувь нэмрийн талаар судалгааны төсөл эхлүүлсэн. 17 бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалтаас өгөгдөл нь бэлэн 10 бүтээгдэхүүнийг сонгосон. ҮШУТХА олон өөр арга барил (насжилтийн мөчлөгийн үнэлгээ, зардал г.м) ашиглан энгийн болон ногоон бүтээгдэхүүний нөлөөллийн ялгааг тооцоолж, ногоон бүтээгдэхүүн тус бүрийг CO<sub>2</sub> ялгарал болон байгаль орчны хөндлөнгийн зардлыг (тухайлбал эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежмент, үйл ажиллагаатай холбогдох зардлууд) бууруулж буй хэмжээтэй нь уялдуулах замаар нөлөөллийг бууруулах коэффициент тогтоосон. Нөлөөллийг бууруулах коэффициентийг худалдан авсан ногоон бүтээгдэхүүнээр үржүүлснээр ногоон худалдан авалтын хүлэмжийн хийн ялгарал, зардлыг хэдий

хэмжээгээр бууруулсныг ҮШУТХА тооцдог.

### **Зах зээлд бэлэн байгаа ногоон бүтээгдэхүүнийг үнэлэх нь**

Төрийн албаны ногоон худалдан авалтыг дэмжих анхны төлөвлөгөөний нөлөөг үнэлэхдээ ҮШУТХА хоёр зүйлийг үнэлсэн:

- Төрийн албаны ногоон худалдан авалтыг дэмжих эхний төлөвлөгөөнд хамрагдсан болон хамрагдаагүй бүтээгдэхүүнүүдийг ялгахын тулд Тай эко шошгын гэрчилгээ авсан бүтээгдэхүүний тоогоор ялгаж, энэхүү төлөвлөгөө нь үйлдвэрлэгчдийг тухайн бүтээгдэхүүнийг илүү ихээр үйлдвэрлэж байгаа эсэхийг дүгнэхээс гадна хичнээн шинэ бүтээгдэхүүн гэрчилгээ авсныг тогтоосон;
- Засгийн газрын худалдан авалтыг (бүтээгдэхүүний гурван бүлэгт тааруулж: барилгын будаг, цаас хэвлэл, хувилах төхөөрөмж) оролцуулаад зах зээл дэх эко шошготой (Тай эко шошго) бүтээгдэхүүний худалдан авалтад үнэлгээ хийсэн.

### **Үр дүнг хэвлэж, нийтлэх нь**

Хэрэгжүүлэгч агентлагуудын улирал тутмын мэдээллийг ашиглан БХГ нь хяналтын тайлан боловсруулж, Засгийн газартаа жил бүр танилцуулдаг. Энэхүү тайланд үндэслэсэн тоймыг БХГ-ийн худалдан авах ажиллагааны веб хуудсанд байрлуулдаг (“цааш унших” сонголттойгоор). Түүнчлэн БХГ, ҮШУТХА-ийн хэрэгжүүлсэн судалгааны төслийн үр дүнд тулгуурлан Үнэлгээний тайланг боловсруулж, ҮШУТХА-ийн веб хуудсанд байрлуулдаг. Урамшуулах замаар хэрэгжилтийг дэмжихийн тулд БХГ-т хүргүүлсэн тайланд үндэслэж, НХА-ын шагналыг энэ чиглэлд шилдэг ажилласан агентлагуудад 2009 оноос хойш олгож байна.

### **Хүн хүч ба эдийн засгийн нөөц бололцоо**

НХА-ын эхний төлөвлөгөөнд зориулсан НХА-ний хяналтын өөр өөр үйл ажиллагаанд гарсан зардал, хүн хүч, хугацааны тооцоог дор харуулав:

- бүтээгдхүүн, тайлангийн мэдээллийн санг байгуулахад дунджаар 1 сая батт (30,000 ам.доллар) (тайлагнах системийг бий болгоход анхандаа 3 сар орчим болсон);
- үйл ажиллагааг ажиглаж, худалдан авалтыг тайлагнахад агентлаг тус бүрд 1 долоо хоног орчим болсон;
- тайлангуудыг цуглуулсны дараа жилийн үр дүнг нэг хүн дунджаар нэг сар орчимд нэгтгэдэг ч тайланг цуглуулахад үүнээс илүү хугацаа шаарддаг;
- Түүнчлэн бүтээгдэхүүний мэдээллийн сан, мэдээлэл цуглуулах ажилд хоёр хүн бүтэн жилийн турш ажиллаж байна. НХА-ын бодлогыг нөлөөллийн судалгааг 9 сар орчим хугацаанд хийсэн.

### **Үр дүнгийн тойм**

НХА-ын анхны төлөвлөгөөний үр дүн болон нөлөөллийн судалгааг зургаар харуулав.

### **Гол сургамжууд**

Хяналтын системийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай зарим хүчин зүйлсийг дор жагсаав:

- Өгөгдлийн харилцан адилхан байдлыг хадгалахын тулд тайлагнах системийг нэгдсэн стандартад оруулах нь чухал.
- Ногоон бүтээгдэхүүний худалдан авалтын хяналтыг хянахын эерэг хүчин зүйл нь байгаль орчны үр ашигийг тооцоох боломжтой болдог.
- Ногоон шалгуурыг эко шошготой нэгтгэснээр төрийн албаны худалдан авах ажиллагааны зах зээлд үзүүлэх боломжит эерэг үр дүнг тооцох боломжтой болно.
- НХА-ын шагнал НХА-г сайн дураараа хэрэгжүүлж буй агентлагын шилдэг туршлагыг үнэлдэг тул хэрэгжилтэд эерэг нөлөөтэй.

Гэсэн ч сорилтууд мөн бий:

- НХА-ын хяналт нь сайн дурынх тул хариу тайлан ирүүлэх байдал нь бага байх эрсдэлтэй тул ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авалтын бодит түвшинг харуулахгүй байх магадлалтай.
- 2012 онд нийт агентлагуудын ердөө 40% нь НХА-ын хяналтын тайлангаа илгээсэн.
- Худалдан авах ажиллагааны нэгдсэн платформ байхгүй байгаа тул хэрэгжүүлэгч агентлаг тус бүр өөрсдийн НХА-ын өгөгдлөө хянах шаардлагатай болж, үүнд ихээхэн хугацаа шаардагддаг.
- Ногоон худалдан авалтыг бүрэн хянаж, илүү өргөн хэмжээнд нэгтгэхэд санхүү/төсвийн журам, систем шаардлагатай бөгөөд энэ нь дунд хугацаандаа бий болох төлөвгүй байна.
- Үр дүн гарсан ч худалдан авагчдыг ногоон бүтээгдэхүүн сонгуулахын тулд илүү их хүчин чармайлт шаардлагатай байна.

### Жишээ 3: Шведийн байгаль орчны зорилгуудыг биелүүлэхэд ТХА-г ашиглах

Швед улс нь байгаль орчны хамгааллын чиглэлд ихээхэн туршлагатай. Швед Улсын үндэсний, бүс нутгийн, орон нутгийн захиргаан нь ихээхэн эрх мэдэлтэй бөгөөд байгаль орчны зорилтуудад хүрэхэд төрийн худалдан авалтыг ашиглах бүрэн боломжтой.

#### Зорилтууд

Шведийн засгийн газрын гол зорилт нь НХА-ын тодорхой шалгууруудыг засгийн газрын хүрээний гэрээнүүд болон мужийн зөвлөл, орон нутгын худалдан авалт хариуцсан нэгжид нэмэх явдал. Ингэхдээ НХА-ын хэрэгслийг олон нийтэд нээлттэй болгосон. Улмаар гэрээ байгуулж буй албаныхан өөрсдийн НХА-ын шалгуурыг бий болгоход цаг хугацаа, мөнгө зарцуулж, олон төрлийн бүтээгдэхүүний бүлэгт байгаль орчин, тогтвортой байдлын гүйцэтгэлтэй холбоотой өндөр түвшний ажиллах хүч, мэдлэг чадвар хайх шаардлагагүй болсон.

#### Хэрэгжилтийн явц

Шведийн төрийн худалдан авах ажиллагаанд байгаль орчны ихэнх шалгуур багтсан байгааг тус улсын Байгаль орчныг хамгаалах агентлаг 1995 онд тооцоолсон байдаг. Гэхдээ зарим шалгуурууд нь байгаль орчны гүйцэтгэлийн зарим үзүүлэлтүүдийг сайжруулахад хүргэсэн байдаг. Үүнийг сайжруулж, зах зээл дэх тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээг тэлэхийн тулд Шведийн Засгийн газар хэд хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүний нэг нь Экологийн тогтвортой худалдан авах ажиллагааны хороог байгуулах (1998-2001) явдал байсан. Энэхүү хороо нь Шведэд НХА-г сурталчлах үндсэн үүрэг даалгавартай төдийгүй Европын холбооны худалдан авах ажиллагааны үндсэн зарчимд ногоон зорилтуудыг багтаах чиглэлээр Европын холбоонд нөлөөлж ажилласан. Холбооны хийсэн гол ажил нь НХА-г үндэсний хэмжээний хэрэгсэл болгож, үүнд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд НХА-ын шалгууруудыг тусгаж өгсөн. 2003 онд Шведийн Засгийн газар энэхүү хэрэгслийг Шведийн Байгаль орчны удирдлагын зөвлөлд (ШБОМЗ буюу SEMCo) шилжүүлсэн. НХА-ын хэрэгслийн хөгжүүлэлт, менежментэд шаардлагатай санхүүжилтийг үүнээс хойш Шведийн Засгийн газар хариуцаж байна. Швед улс 2007 онд төрийн худалдан авах ажиллагааг ногоон бодлогын нэг хэсэг болон албажуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Энэхүү төлөвлөгөөнд дараах зорилтуудыг багтаасан:

- төрийн худалдан авах ажиллагаанд байгаль орчин, тогтвортой хөгжлийн хүчин зүйлийн эзлэх хувийг нэмэх,
- ногоон хөгжилд чиглэсэн гэрээнүүд, болон
- байгаль орчны шалгуур ашигладаг орон нутгийн захиргаа, мужийн зөвлөл, засгийн газрын байгууллагуудын тоог нэмэх.

Ногоон эсвэл байгаль орчинд ээлтэй худалдан авах ажиллагаа нь тогтвортой хөгжлийн гурван тулгуурын зөвхөн нэгтэй нь нийцдэг тул үндэсний НХА-ын хэрэгсэлд нийгмийн шалгуурыг нэмэхээр ШБОМЗ шийдсэн. Үүнийгээ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн конвенц болон Нэгдсэн үндэсний байгууллагын хүний эрхийн шалгууруудыг одоогийн НХА-ын шалгуурууд дээр нэмэх замаар үндсэндээ хэрэгжүүлж чадсан. ШБОМЗ энэхүү хэрэгслийн нэрийг өөрчилж Төрийн тогтвортой худалдан авах ажиллагаа (ТХА)-ны хэрэгсэл болгосон ("www.msrf.se"-ээс харна уу). Энэхүү хэрэгсэл нь цахим орчинд нээлттэй бөгөөд төрөл бүрийн бараа бүтээгдэхүүн, ажлуудын гэрээний тогтвортой байдлын шалгуурыг худалдан авагчид харж болох мэдээллийн сан байдлаар ажилладаг. Шалгуур үзүүлэлтүүдийг гурван өөр түвшинд тогтоодог. Энэхүү хэрэгсэлд өөр өөр эрчим хүч ашигладаг бараа бүтээгдэхүүн, сургалтын материал зэргийн талаар суурь мэдээлэл, баталгаажуулах тэмдэглэл, амьдралын мөчлөгийн зардлын тооцоо зэргийг багтаасан байна. Төрийн худалдан авах ажиллагааг шинэ, сайжруулсан аргаар дэмжих зорилгоор бий болгосон Шведийн өрсөлдөөний байгууллага нь тогтвортой байдлын бүх хүчин зүйлийг хангахад анхаардаг.

Үүнээс гадна "Uppföljningsportalen" гэх веб-д суурилсан гэрээний удирдлагын төвийг ШБОМЗ болон Шведын орон нутгийн захиргаа болон бүсийн холбоо хамтран байгуулсан; "[www.uppfoljningsportalen.se](http://www.uppfoljningsportalen.se)"-аас харна уу. Энэхүү нэгж нь худалдан авах ажиллагаанд гэрээ байгуулагч албаныхан болон нийлүүлэгчид нийгмийн шаардлагуудыг хангасан эсэхийг баталгаажуулдаг. Гэрээ байгуулагч албаныхан болон нийлүүлэгчид нь гэрээтэй холбоотой мэдээллээ нийтлэхийн тулд тусгай хаяг, нууц үг хүлээн авдаг. Мэдээлэл хүргүүлэх нь гэрээний хүрээнд хийгдэх ажил бөгөөд олон нийтэд ил болохгүй. Зөвхөн аудитын тайланг олон нийтэд ил болгодог. Энэхүү нэгжийн хариуцлагыг 2014 оны 7-р сарын 1-нд Шведийн өрсөлдөөний байгууллагад шилжүүлсэн.

Шведийн Засгийн газар төрийн худалдан авах ажиллагааг сайжруулахад чиглэсэн санаачилгыг 2013 онд эхлүүлснээс гадна төрийн худалдан авалтад ногоон, тогтвортой байдлын шалгуурыг нэмсэн. Санаачилга нь хоёр хэсгээс бүрдсэн: санхүүгийн болон байгууллагын. 2015 оноос эхлэн их хэмжээний нэмэлт санхүүжилтийг төрийн худалдан авах ажиллагаанд НХА-г багтаах Засгийн газрын дэмжлэгэд хуваарилсан. Санаачилгын хоёр бүрэлдэхүүн хэсэг бол санхүүгийн болон зохион

байгуулалтын хэсэг. Худалдан авагч байгууллагын бүх арга хэмжээ, мэдээллийн үйлчилгээг 2014 оны 7-р сарын 1-нд Шведийн өрсөлдөөний байгууллагад буюу нэг байгууллагад нэгтгэсэн. Үр дүнд нь ногоон, тогтвортой худалдан авах ажиллагаатай холбоотой хариуцлага, үйл ажиллагаануудыг нэгтгэж, ШБОМЗ-с Шведийн өрсөлдөөний газарт шилжүүлжээ.

### **Хэрэгжүүлэгч байгууллага ба оролцогч талууд**

Орон нутгийн захиргаа, мужийн зөвлөл, засгийн газрын агентлагууд, төрийн өмчит компаниуд бүгд үндэсний ТХА-ын хэрэгслийг ашигладаг. Хувийн хэвшлийн худалдан авалт болон ТББ-ууд мөн НХА-ын шалгуурууд болон ШБОМЗ-ийн албан ёсны веб хуудсанд ил байгаа бусад материалуудыг (2015 оны 1-р сарын 1-ээс Шведийн өрсөлдөөний газрын веб хуудсанд оруулсан) түгээмэл хэрэглэдэг болсон. Ерөнхий журмын дагуу НХА нь Шведэд сайн дурын хандлагатай байдаг. Шведийн худалдан авах ажиллагааны журамд гэрээ байгуулагч албаныхан төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой асуудалд боломжтой бол байгаль орчин, нийгмийн шалгуурыг тооцох хэрэгтэй гэж заасан байдаг. Засгийн газрын цөөн хэдэн худалдан авах ажиллагаа л байгаль орчны тодорхой шалгуурыг дагах ёстой байдаг. Жишээ нь Засгийн газрын автомашины худалдан авалт.

### **Нөлөө, хяналт**

Шведийн байгаль орчныг хамгаалах агентлаг (ШБОХА) нь НХА-ын хэрэгжилтийг хянадаг. Төрийн албаныхнаас үе үе асуулга авдаг бөгөөд тендерийн баримт бичгийг шалгадаг. ШБОХА 2004 онд НХА-ын шаардлагыг агуулсан төрийн албаны хэд хэдэн гэрээнд судалгаа явуулсан. ШБОМЗ-ийн худалдан авах ажиллагааны шалгуурын хэрэглээ тогтвортой нэмэгдсэн (Зураг 3). Тендерийн баримт бичгүүдэд зөвхөн НХА-ын шалгуур үзүүлэлтийн хэрэглээг хянадаг; НХА/ТХА-ын байгаль орчинд үзүүлж буй нөлөөг хэмжих судалгаа огт байхгүй. Худалдан авах ажиллагааны өмнөх болон худалдан авах ажиллагааны гэрээнүүдийн аудит, үнэлгээ гэхээс илүү өдийг хүртэл худалдан авах ажиллагааны журамд анхаарсан. Нийлүүлэгчид болон нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нь гэрээний шаардлага хангасан эсэхийг шалгахад гэрээний менежмент, аудит, үнэлгээ зэрэг нь бүгд чухал. Маш олон гэрээ байгуулагч албан тушаалтнуудад эдгээр чухал даалгаврыг гүйцэлдүүлэх хүний нөөц, мэдлэг, ур чадвар дутагдалтай тул байгаль орчин, тогтвортой байдлын бодлого биелэхгүйд хүрч, үндэсний байгаль орчны зорилтууд орхигдож, шудрага бус өрсөлдөөн бий болдог. Энэ нь нөгөө талаасаа нийлүүлэгчдийг цаашид тогтвортой бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх сонирхлыг нь бууруулах эрсдэлтэй.

Өөр нэгэн сорилт бол НХА-ын шалгуурыг ашигласнаар бий болж буй байгаль орчин/тогтвортой байдлын бодит үр нөлөөг тооцоолох явдал. Байгаль орчин, тогтвортой байдлын үр нөлөөг нь тооцоолж, аудит хийж, хэмжиж болохуйц байдлаар шалгуурыг тогтоохгүй бол үр ашиггүй болох магадлалтай төдийгүй өрсөлдөөнд сөрөг нөлөө учруулж мэднэ.

### **Гол сургамжууд**

Нийлүүлэгчдийг дэмжиж, нийлүүлэлтийн сүлжээнд итгэх итгэлийг нь нэмэгдүүлж, тэдэнд алдаанаасаа суралцах боломж олгохын тулд худалдан авах ажиллагааны урьдчилсан шатанд гэрээ байгуулагч нэгжид илүү тусламж, дэмжлэг үзүүлж, гэрээний менежмент, аудит, үнэлгээг илүү нарийн, хяналттай хийдэг болох хэрэгтэй.

Тогтоосон шалгуурын үр ашгийг үнэлж, дүгнэхийн тулд НХА/ТХА-ын нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд харуулах тоон үзүүлэлт хэрэгтэй байгаа.

НХА/ТХА-ын системийг илүү хэрэгцээтэй, хатуу, үр дүнтэй болгохын тулд хариуцсан салбар нэгжийг илүү хариуцлагатай болгож, зохих нөөц бололцоогоор нь хангах нь чухал.

Өдийг хүртэл төрийн албыг ногоон худалдан авах ажиллагаанд шилжүүлэхэд гол анхаарал төвлөрсөн. Тогтвортой худалдан авах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нийлүүлэгчид болон тэдний нийлүүлэлтийн сүлжээнд энэ талаар ухуулга, сурталчилгаа хийж, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлж, ТХА-ны шаардлагад нийцүүлэх шаарлагатай. Энэ нь жижиг, дунд бизнест төрийн худалдан авалтын зах зээлд нэвтрэх боломж олгож, компаниудын дотоод ба гадаад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, богино, урт хугацаандаа өрсөлдөөнийг дэмжинэ (OECD1: 36-40).



### 6.3. ТОГТВОРТОЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



“Аялал жуулчлал бол дэлхийн хамгийн том, хамгийн хурдацтай хөгжиж буй эдийн засгийн салбаруудын нэг бөгөөд олон оронд тогтвортой хөгжлийг хангахад чухал үүргийг гүйцэтгэж байна. Үүний зэрэгцээ, нутгийн иргэд, байгаль болон соёлд үр өгөөжтэй байхын тулд сайн зохицуулалт шаардлагатай.” (UNWTO: 12)

Аялал жуулчлал бол дэлхийн эдийн засгийн гол салбаруудын нэг. Одоогоор энэ салбар дэлхийн нийт ДНБ-ий 10%, экспортын 7%-ийг бүрдүүлж буй төдийгүй 10 ажлын байр тутмын нэгийг бий болгож буй салбар юм<sup>57</sup>. Олон улсын жуулчдын хөдөлгөөн 2016 онд дэлхийн хэмжээнд 3.9%-иар өсч, 1.235 тэрбум болсон нь жилийн өмнөхөөсөө 46 саяар өссөн дүн юм. Олон улсад жуулчдын тоо 2030 он гэхэд 1.8 тэрбум хүрнэ гэж Дэлхийн аялал жуулчлалын байгууллага (ДАЖБ) тооцоолсон<sup>58</sup>. Гэсэн ч аялал жуулчлалын салбарын өсөлтийг байгалийн нөөц ашиглалтаас хамааралтай байдлаас салгах, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр, ТХҮ-ийн үйл явцыг түргэсгэхэд энэ салбарын боломжийг ашиглах шаардлагатай байгаа юм<sup>59</sup>.

*ДАЖБ-ын 2018 оны Аялал жуулчлалын хандлага, бодлогууд тайлан*-д аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дэмжих өргөн хүрээний бодлогыг тусгасан бөгөөд үүндээ аялал жуулчлалын салбарыг илүү тогтвортой байдлаар хөгжүүлэхэд шаардагдах хэд хэдэн гол бодлогыг онцолсон:



“Улс орны хөгжлийн ерөнхий зорилгод хүрэхэд аялал жуулчлалын өнөөгийн болон боломжит хувь нэмэр, үүргийг хүлээн зөвшөөрөх нь аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг дэмжих бодлого, араг хэмжээг хэрэгжүүлэх эхний бөгөөд чухал алхам юм. Энэ нь тухайн салбарыг дэмжихэд тэр л саад болж буй хүчин зүйлийг арилгахад ач холбогдолтой.” (UNWTO: 43)

#### Бодлогын нэгдсэн арга барилыг хөгжүүлэх:

- Холбогдох бодлогын чиглэлүүдтэй уялдуулах, харилцан нөхөх байдлыг харгалзан, гол оролцогч талуудын оролцоо, үүрэг, хамтын ажиллагааг тодорхойлсон урт хугацааны стратеги боловсруулах,
- Бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлт, хяналтын шатанд засгийн газар, аж үйлдвэр, иргэний нийгмийн нягт хамтын ажиллагааны үнэ цэнийг үнэлэх.

#### Мегатренд буюу нийтлэг хандлагыг боловсруулах:

- Хурдацтай тэлж буй, хоорондоо холбогдсон, динамик орчинд дасан зохицох системчилсэн, стратегийн арга барилыг хөгжүүлэх.
- Зохицуулалтын болон хууль зүйн орчинг орчинг шинэчилж, хөгжүүлэлтийн явцад гол оролцогч талуудтай тулж ажиллан бодлого, зохицуулалтын шатанд илүү урьдчилан тооцоолох механизмыг дэмжих.
- Мега хандлагын нөлөөллийн давхардлыг шийдвэрлэж, хүргэж буй үйлчилгээнд шинэ, инновацлаг бизнесийн арга барилыг ашиглахын тулд тухайн салбар, бусад засгийн газрууд болон иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийг хөгжүүлэх.
- Урт хугацааны мега хандлагыг тооцсон, ялангуяа өгөгдлийг найдвартай шинжилж, хувилбар бүхий төлөвлөлт хийх замаар ирээдүйд чиглэсэн аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэх, инновацийн соёлыг дэмжсэн, засгийн газрын өөрчлөлтийн менежментийг дэмжсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.

<sup>57</sup> UNEP5; NCC

<sup>58</sup> One Planet Network

<sup>59</sup> UNEP5: 57; UCLG: 14, 10YFP1: 1, OECD: 3, UNWTO: 5, WTO: 8



## Тогтвортой аялал жуулчлалд зориулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийг дэмжих:

- Төрийн санхүүжилт болон хөрөнгө оруулалтад байгаль орчин, тогтвортой байдлын шалгуурыг тусгах, аялал жуулчлалын салбарын төслүүд болон ялангуяа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад ногоон санхүүжилтын хэрэгслийг хэрэглэхийг дэмжих,
- Аялал жуулчлалын салбарын бодлого, хөтөлбөрт байгаль орчин, нийгмийн шалгуурыг тусгах, ногоон хөрөнгө оруулагчдыг дайчлах, бизнес эрхлэгчид тогтвортой туршлагыг эзэмшүүлэх замаар хариуцлагатай бизнесийн арга, туршлагыг дэмжих,
- Засгийн газар, бодлого боловсруулагчдын янз бүрийн түвшинд чадавхыг бэхжүүлэх, аялал жуулчлалын тогтвортой хөрөнгө оруулалт, санхүүгийн туршлагыг дэмжих үүднээс арга хэмжээний хэрэгжилтэд аялал жуулчлал, байгаль орчин, инновацийн салбарыг оролцуулан хоорондын зохицуулалтыг сайжруулах,
- Аялал жуулчлалын санхүүжилт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад байгаль орчны эрсдэлийг оновчтойгоор тодорхойлохыг нэгтгэх, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтаас гарах эдийн засаг, нийгэм, экологийн үр өгөөжийг илүү ойлгомжтой тодорхой болгох үүднээс тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж буй ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтын өгөгдөл, шинжилгээг сайжруулах (OECD: 4).

## Шигтгээ 4: Тогтвортой аялал жуулчлалын зорилтууд

1. ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГТАЙ БАЙДАЛ: Аялал жуулчлалын тодорхой чиглэлүүд цааш хөгжин цэцгэлж, урт хугацаандаа үр өгөөжөө өгдөг байхын тулд үр ашигтай байдал, өрсөлдөх чадварыг нь найдвартай хангах.
2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТ: Аялал жуулчлалын салбараас жуулчдын тухайн газарт зарцуулж буй зардлыг оролцуулан, аялал жуулчлалаас орон нутагт үлдэх үр ашгийг бүрэн ашиглах.
3. ХӨДӨЛМӨРИЙН ЧАНАР: Аялал жуулчлалын тусламжтай дотоодод бий болсон ажлын байрны тоо хэмжээ, чанарыг сайжруулах. Тухайлбал цалин, хөлсний түвшин, үйлчилгээний орчин, арьс, хүйс, хөгжлийн чадвар зэрэг ямар нэг байдлаар ялгаварлан гадуурхахгүй байх.
4. НИЙГМИЙН ТЭГШ БАЙДАЛ: Боломж бололцоо, орлого, ядууст хүртээмжтэй үйлчилгээ зэргийг сайжруулах зэргээр хүлээн авагчийн улсад аялал жуулчлалаас үлдэж буй эдийн засаг, нийгмийн өгөөжийг тэгш хүртээх.
5. ЖУУЛЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ: Арьс, хүйс, хөгжлийн бэрхшээл болон бусад ямар нэг ялгаварлан гадуурхах зүйлгүйгээр жуулчин бүрд аюулгүй, сэтгэл ханамжтай, бүрэн дүүрэн дурсамж үлдээх.
6. ОРОН НУТГИЙН ХЯНАЛТ: Тухайн нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой аялал жуулчлалын төлөвлөлт, шийдвэр гаргалтанд орон нутгийнхний оролцоог дэмжиж, бусад оролцогч талуудтай зөвшилцөх.
7. НУТГИЙН ИРГЭДИЙН САЙН САЙХАН БАЙДАЛ: Нийгмийн бүтэц, нөөц баялагийн хүртээмж, үзвэр үйлчилгээ, эрүүл мэндийн систем зэрэг орон нутгийн хүн амын амьдралын чанарыг хангаж, сайжруулж, ямар нэг байдлаар дордуулахгүй байх.
8. СОЁЛЫН БАЯЛАГ БАЙДАЛ: Хүлээн авагч орны түүхэн өв, соёл, уламжлал, онцлог байдлыг хүндэлж, дэмжих.
9. БИЕТ ӨВИЙН БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ: Хот суурин газар, орон нутгийн байгаль, ландшафтын чанарыг хэвээр нь хадгалж, сайжруулж, байгаль орчны биет буюу харагдах байдлыг доройтуулахгүй байх.
10. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ: Байгалийн орчин, амьтдын амьдрах орчин, ан амьтаныг хадгалан хамгаалаж, тэдгээрт учруулж буй хохирлыг бууруулах.
11. НӨӨЦ ҮР АШИГТАЙ БАЙДАЛ: Аялал жуулчлалын байгууламжийн бүтээн байгуулалт, үйлчилгээний үйл ажиллагаанд ховор, сэргээгдэх бус нөөцийн хэрэглээг аль болох бага байлгах.
12. БАЙГАЛИЙН ЦЭВЭР ОРЧИН: Аялал жуулчлалын байгууллагууд болон жуулчдаас бий болгож буй агаар, ус, хөрсний бохирдол, хог хаягдалын хэмжээг бууруулах.

*Эх сурвалж: ДАЖБ/ЕХ, Хөгжилд зориулсан тогтвортой аялал жуулчлал, 2013 он, х.18.*

### 6.3.1. Нэгдсэн стратеги

Хөгжиж буй улс орнуудын хөгжилд чиглэсэн тогтвортой аялал жуулчлалын чадавхыг бэхжүүлэх гарын авлага тайландаа ДАЖБ нь Тогтвортой ажлал жуулчлалын нэгдсэн ойлголт, арга хэмжээг сайжруулж, тогтвортой хөгжилд чиглэсэн аялал жуулчлалын салбарыг дэмжихэд засгийг газрууд болон бусад оролцогч талуудад туслах боломжийг эрэлхийлсэн. Бусад байгууллагуудын адилаар ДАЖБ нь аялал жуулчлалын салбарыг тогтвортой хөгжүүлэх эхний алхам нь энэ чиглэлд үндэсний нэгдсэн стратеги хөгжүүлэх явдал гэдгийг зөвлөж буй юм.

#### Аялал жуулчлалын бодлого ба засаглал

“Тус салбарыг тогтвортой хөгжлийн бодит хөдөлгөгч нэг хүч хэмээн зөв байрнаас хандахын тулд үүнийг хөгжлийн судалгаанд болон тухайн орны бодлого төлөвлөлтөд харгалзсан байх ба засгийн газраас үүнд онцгойлон анхаарах хэрэгтэй. Бүх улс орнууд тогтвортой байдлын зарчмуудыг баримтлан, үр дүнтэй, хэрэгжүүлж болохуйц аялал жуулчлалын бодлого, стратеги эсвэл мастер төлөвлөгөөтэй байна. Салбарын хэрэгцээнд нийцсэн, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хяналт тавьж, чиглүүлж чадахуйц хангалттай хууль тогтоомж, дүрэм журамтай байх ёстой. Аялал жуулчлалын асуудлыг тодорхой яаманд хариуцуулж, зохих мэргэжлийн ур чадвартай, нөөцийг нь бүрдүүлсэн төрийн албад дэмжиж ажиллах ёстой.

Эцэст нь олон талт энэ салбарын сайн засаглалд тавигдах үндсэн шаардлага бол хувийн хэвшлийн болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг илэрхийлсэн, тэднийг идэвхижүүлэхэд чиглэсэн бөгөөд аялал жуулчлалын салбарын төлөвлөлт, хөгжүүлэлт, менежментийн чиглэлээр засгийн газартай хамтран ажиллах боломжийг нь бүрдүүлсэн бүтэц, үйл явцыг бий болгох явдал юм. Энэ нь зөвхөн үндэсний хэмжээнд хамаатай төдийгүй салбарын үр өгөөжид нөлөөлөх олон арга хэмжээг хэрэгжүүлэх орон нутгийн түвшинд ч ач холбогдолтой.” (UNWTO: 10)

Энэ төрлийн стратегийн гол хүчин зүйлсийг ДАЖБ тус тайланд дэлгэрэнгүй дурдсан: “Аялал жуулчлалын стратеги нь энэ чиглэлийн бодлогод нөлөөлж, улмаар үр дүн үзүүлснээр бодлогын зорилтуудыг хангах үйл ажиллагааг чиглүүлдэг. Үүнийг мөн Хөгжлийн стратегийн төлөвлөгөө эсвэл Ерөнхий төлөвлөгөөнд тусгах боломжтой. Энэ нь тус улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа, менежмент, арга хэмжээ, хяналт гээд бүх хүчин зүйл, бүрэлдэхүүн хэсгийг багтаасан цогц байх хэрэгтэй. Аялал жуулчлалын стратегийг тус улсын нөхцөл байдал, хөгжлийн түвшнээс хамаараад 5-15 жилийн хугацаанд төлөвлөх хэрэгтэй. Ингэхдээ тухайн жилийн үйл ажиллагаа, санхүү хуваарилах ажлуудыг багтаасан Үйл ажиллагааны төлөвлөгөө болон нөөц бололцоонд уялдуулж хэрэгжүүлнэ. Судалгаа, үнэлгээ, зөвлөгөөний нарийвчилсан хөтөлбөрт тулгуурлаж, стратегийг баримтжуулах хэрэгтэй.

Стратегийн төлөвлөгөө, эсвэл Ерөнхий төлөвлөгөөнд дараах зүйлийг голцуу тусгадаг:

- Аялал жуулчлалын үр ашигтай, сонирхол татахуйц бүтээгдэхүүн болох боломжтой аялал жуулчлалын нөөц, боломж,
- Аялал жуулчлалын байгууламж, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын боломж бололцоо,
- Аялал жуулчлалын одоогийн урсгал, гүйцэтгэл,
- Зорилтот зах зээлийн төрөл, цар хүрээ,
- Тээврийн хүртээмжтэй байдал, үйлчилгээний бүтэц,
- Эдийн засгийн одоогийн болон тооцоолсон шинжилгээ,
- Нийгэм, соёл, байгаль орчин, эдийн засгийн нөлөөлөл,

- Нөөцийн менежмент - эрчим хүч, ус, хог хаягдал,
- Аялал жуулчлалын хөгжүүлэх үүрэг бүхий институцийг бий болгох,
- Аялал жуулчлалтай холбоотой хууль, эрх зүй, дүрэм журам,
- Хүний нөөцийн хэрэгцээ,
- Аялал жуулчлалын дэд бүтцэд тавигдах шаардлагууд,
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутаг,
- Аялал жуулчлалын бүс нутаг, амралтын газар, жуулчдыг татах үзвэрийг хөгжүүлэх зураг төсөл,
- Нутгийн иргэдийг хамруулах, тэдэнд чиглэсэн санаачилгууд,
- Аялал жуулчлалын маркетинг, мэдээлэл түгээх,
- Нэмэлт биет төлөвлөлт, амралтын газрыг тодорхой байршилд бүтээн байгуулах зэрэг нарийн зүйлсийг төлөвлөгөөнд илүү тодорхой тусгасан байна” (WTO).

Энэхүү стратегийг мөн холбогдох бусад бодлого, стратегиудад тусгаж өгсөн. Үүнээс гадна дотоодын нөхцөл байдалд тааруулах шаардлагатай: “Аялал жуулчлалын стратеги, ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн түвшинд боловсруулах шаардлага нэмэгдсээр байна. Үүнийг мөн өөрөөр ‘чиглэлийн менежмент’ гэж нэрлэдэг. ‘Дээр дурдсан асуудлуудын ихэнхийг энэ нь шийдэж болох ч зөвхөн тухайн чиглэлд төвлөрсөн байдаг. Тэдгээр нь аялал жуулчлалын хөгжил, үйл ажиллагааны чиглэлийг тухайн бүс нутгийн онцлог байдалд тааруулж хөгжүүлэхэд чухал нөлөөтэй. Энэ төрлийн төлөвлөгөөг бүс нутаг, муж, аймаг, хот, амралтын газар, орон нутгийн бүс (үндэсний парк гэх мэт) зэргээр тусгайлан боловсруулж болно. Тэдгээр нь одоо байгаа үндэсний аялал жуулчлалын стратеги, ерөнхий төлөвлөгөөтэй уялдах нь маш чухал. Одоо үйлчилж буй бодлого, стратеги, төлөвлөгөө нь аялал жуулчлалын суурь хөгжлийг тодорхойлоход чухал нөлөөтэй ч гэсэн бодитоор хэрэгжихгүй, цагт үнэ цэнэгүй байх нь бий. Ерөнхий төлөвлөгөө болон стратегийн хөгжлийн төлөвлөгөөнд тогтмол хяналт тавьж, тухай бүрийн нөхцөл байдалд нь тааруулж өөрчлөх шаардлагатай байдаг. Өс бөгөөс эдгээр төлөвлөгөө нь маш хурдан хуучирч, анхандаа тодорхойлсон стратегийн зорилтууддаа хүрдэггүй. Гурван төрлийн хяналтын арга хэмжээ үр дүнтэй байж болно. Үүнд:

- **Гарц** – авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, боловсруулалтын шатандаа яваа, эсвэл боловсруулсан арга хэмжээг системжчилсэн байдлаар бүртгэх
- **Үр дүн** – тодорхой гүйцэтгэлийн үзүүлэлттэй холбогдох арга хэмжээнүүдийн үр дүнг шалгах
- **Нөлөө** – бодлогын ерөнхий зорилт, төлөвлөсөн үр дүнг тооцох. Үүнд аялал жуулчлалын түвшин, хөгжлийн ерөнхий үзүүлэлтүүдийг тусгаж болно (WTO: 48).

Стратегийн хэрэгжилтийг тогтмол хангахын тулд ашиглах хэрэгсэл, арга барилыг боловсруулалтын явцад бодолцож, үндэсний болон орон нутгийн хэмжээнд тооцох хэрэгтэй. (UNEP5: 14, UCLG: 14, UNEP28; 10YFP1; WTO: 17).

## Хүснэгт 11: ТХҮ-ийн бодлогын хэрэгсэл ба аялал жуулчлалын амьдралын мөчлөг

Бодлогын хэрэгсэл	Амьдралын мөчлөгийн үе шат				
	Байгалийн нөөц баялагийн олборлолт	Бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэл	Тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангаж, ажил гүйцэтгэх явц	Хэрэглээ	Амьдралыг мөчлөгийн төгсгөлийн менежмент
<b>Зохицуулалт болон эрх зүйн хэрэгсэл</b>	Эмзэг бүс нутаг, соёлын болон байгалийн өв газруудад нэвтрэх, үйл ажиллагаа явуулах тухай журам	Ус, эрчим хүчний үр ашигтай технологи, усыг дахин ашиглах, нөхөн сэргээх, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээтэй холбоотой журам	Барилгын материалын журам, бүтээгдэхүүний байгаль орчны стандарт	Жуулчдын менежмент, хүлээн авах хүчин чадалтай холбогдох журам	Бохир ус, хатуу хог хаягдлын тухай журам
<b>Эдийн засаг, санхүүгийн хэрэгсэл</b>	Тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн нөөц газар, түүнчлэн бусад үзмэрт нэвтрэх хураамж	Технологи болон хүлэмжийн хийг ялгаралтыг бууруулах арга хэмжээнд татаас, зээлийн эсвэл татварын урамшуулал олгох	Тогтвортой бизнесийн хөгжилд чиглэсэн санхүүжилтийн схем	Аялал жуулчлалын татварыг байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагаан зориулах (далайн эрэг цэвэрлэх, хог хаягдлын дэд бүтэц, олон нийтэд сурталчлах г.м)	Орон нутгийн болон тур операторын төслийн хөрөнгө оруулалттай уялдах нүүрстөрөгчийн ялгарлыг шингээлтийг дэмжих схем
<b>Мэдээлэл-сурталчилгаа, сайн дурын хэрэгсэл</b>	Тогтвортой аялал жуулчлал, сүлжээнд чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлд орон нутгийн иргэдийг хамруулах	Аялал жуулчлалын салбарын компаниудын нийгмийн хариуцлага	Хариуцлагатай үйл ажиллагаанд гэрчилгээ олгох схем, зөвлөмж ашиглах	Тогтвортой байдлын асуудал, ёс зүйн дүрэм журамтай холбоотой мэдээллийг нийтэд түгээх	Байгаль орчинд нөлөө багатай аялал жуулчлалын үйл ажиллагааг сурталчлах (явган аялал, ажиглалт)

Эх сурвалж: *UNWTO, 2019:20*

Аялал жуулчлалын салбарт ТХҮ-ийн хэрэгжүүлэх гурван сайн хэрэгслийг НҮББОХ тодорхойлсон байдаг (**Хүснэгт 10**-г харна уу) (UNEP5):

- **Зохицуулалтын болон эрх зүйн хэрэгсэл:** Эдгээр нь зайлшгүй биелүүлэх Засгийн газраас гаргасан тогтоол, журам бөгөөд ихэнх тохиолдолд хориг тогтоох нь эрсдэл дагуулдаг. Хэрэгжилтийг бүрэн хангахын тулд зохих механизмыг давхар бий болгох хэрэгтэй.
- **Эдийн засаг, санхүүгийн хэрэгсэл:** Эдгээр нь зарим үйл ажиллагааг санхүүгийн хувьд илүү үр ашигтай болгох урамшуулал, зарим тодорхой үйл ажиллагаанд торгууль ногдуулах арга хэмжээ байдаг.
- **Мэдээлэл- сурталчилгаа, сайн дурын хэрэгсэл:** Нийгэмд тодорхой хэв журам тогтоож, нийтэд таниулж, ухуулах замаар бий болгох хэрэгсэл.

“Аялал жуулчлалын бодлого тодорхойлогчид нь эдгээрээс гадна тогтвортой аялал жуулчлалд оруулах тогтвортой хөгжлийн нөлөөг хянах хэрэгслийг боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй” (UNEP5: 21).

### 6.3.2. Оролцогч талуудыг идэвхижүүлэх

Хөгжлийн стратеги, бодлого, хэрэгсэл, арга барилыг (UNEP5: 17-18, UCLG: 14; 10YFP1: 1, WTO: 21) – мөн засгийн газрын бүх шатны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага зэрэг өргөн хүрээний оролцогч талуудтай (UNEP5: 17-18, WTO: 21) нягт ойр хамтран ажиллах замаар боловсруулах хэрэгтэй. “Аялал жуулчлалыг илүү тогтвортой болгох нь: Бодлого тодорхойлогчдод хандсан зөвлөмж” (2005) хэмээх тогтвортой аялал жуулчлалын тайландаа НҮББОХ дараах дүгнэлтийг гаргасан: “Аялал жуулчлалыг тогтвортой байдлаар хөгжүүлж, удирдахын тулд өргөн хүрээний оролцогч талуудын хэрэгцээнд тулгуурлан, цогц бөгөөд тэгш байдлаар шийдвэрлэх хэрэгтэй. Харилцан адилгүй эдгээр талуудын ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд Засгийн газар хоёр үндсэн зорилго бүхий бүтцийг бий болгох нь зүйтэй. Үүнд:

- Тогтвортой аялал жуулчлалын стратеги, бодлогыг боловсруулахдаа оролцогч талуудтай уулзаж, зөвлөлдөх.
- Оролцогч талуудын харилцан холбоотой үйл ажиллагаа, тухайн үед яригдаж буй асуудлуудыг үр дүнтэй, уялдаатай байдлаар үргэлжлүүлэх.

Ихэнх тохиолдолд энэхүү хоёр зорилгыг ижил бүтцээр хангах боломжтой. Хоорондын уялдаа холбоог хадгалахад байнгын нэгж хэрэгтэй; бодлого боловсруулах шатанд нэмэлт, түр хугацааны ажлын хэсэг шаардлагатай болж магадгүй. Дараах үр дүнд хүрэх зорилгоор тухайн нэгжийн бүтцийг бусад оролцогч талуудтай түншлэл байгуулах замаар хөгжүүлж болно, Тухайлбал:

- Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн хэрэгцээг олон нийтэд илүү таниулж, үүнд нөлөөлж чадах талуудын анхаарлыг энэ чиглэлд бүрэн төвлөрүүлэх,
- Ашиг сонирхол, хариуцаж буй зүйл нь аялал жуулчлалын хөгжил, менежментийн нөлөөлөлд өртөх талуудын дуу хоолойг сонсох,
- Аялал жуулчлалтай холбогдох эдийн засаг, нийгэм, байгаль орчны асуудалд мэргэжлийн боловсон хүчнийг татан оролцуулах,
- Аялал жуулчлалд нөлөөлөх бусад салбар, үйл ажиллагааны чиглэлийн бодлого, үйл ажиллагааг харгалзан, бодлогын зөрүү гарахаас урьдчилан сэргийлж, уялдаа, холбоог сайжруулах, болон
- Дундын, харилцан тохиролцсон хөтөлбөрийн дэмжлэг, нөөц бололцоог өргөн хүрээнд ашиглах.” (UNEP28: 50)

### Хүснэгт 12: Тогтвортой аялал жуулчлалын оролцогч талууд

Оролцогч тал	Тогтвортой аялал жуулчлалд гүйцэтгэх үүрэг
Хөгжилд дэмжлэг үзүүлэгч олон улсын агентлагууд	<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бодлого, хэлэлцээрт аялал жуулчлалыг хамруулах</li> <li>• Тогтвортой аялал жуулчлал, бие даасан хөтөлбөр, төслүүдэд санхүү, техникийн туслалцаа үзүүлэх</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Олон талт агентлаг, хөтөлбөрүүд</b></li> <li>• <b>Хоёр талын агентлагууд</b></li> </ul>	
Засгийн газар	<ul style="list-style-type: none"> <li>• Аялал жуулчлалын бодлого, стратегийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт</li> <li>• Аялал жуулчлалыг өргөн хүрээний бодлого, стратегид уялдуулах</li> <li>• Салбарын холбогдох хууль, стандарт, журам</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Аялал жуулчлалын яам</b></li> <li>• <b>Бусад яамд</b></li> <li>• <b>Аялал жуулчлалын зөвлөл зэрэг салбарын агентлагууд</b></li> </ul>	

<ul style="list-style-type: none"> <li>• Засгийн газрын хэрэгжүүлэгч бусад байгууллагууд</li> <li>• Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлага, хариуцсан салбар нэгжүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтэц төлөвлөлт, бүтээн байгуулалт</li> <li>• Байгалийн нөөцийн менежмент</li> <li>• Мэдээлэл-сурталчилгаа, маркетинг</li> </ul>
<p>Орон нутгийн захиргаа, чиглэл хариуцсан нэгж</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүс нутгийн засаг захиргаа</li> <li>• Дүүргийн зөвлөл гэх мэт орон нутгийн захиргаа</li> <li>• Чиглэлийн менежмент хариуцсан байгууллага, төр-хувийн хэвшил зэрэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн хөгжлийн стратегийн чиглэл, төлөвлөлт</li> <li>• Бодлого, журмын хэрэгжилт</li> <li>• Орон нутгийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, менежмент</li> <li>• Оролцогч талуудын оролцоо, уялдаа, дэмжлэг</li> </ul>
<p>Хувийн хэвшлийн бизнес</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний болон орон нутгийн аялал жуулчлалын холбоо</li> <li>• Зочид буудал гэх мэт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч бизнес</li> <li>• Олон улсын болон ирэх жуулчид хариуцсан операторууд</li> <li>• Хүнс үйлдвэрлэл зэрэг салбарын ханган нийлүүлэгчид</li> <li>• Олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аялал жуулчлалын салбарыг төлөөлж, салбарын хөгжилд нөлөөлнө</li> <li>• Аялал жуулчлалын үйлчилгээний үйл ажиллагааг хариуцана</li> <li>• Дотоодын зах зээлийг олон улсын зах зээлтэй холбоно</li> <li>• Бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хөрөнгө оруулж, сайжируулна</li> <li>• Ажлын байр бий болгож, орон нутагт орлогын эх үүсвэр бий болгоно</li> <li>• Эдийн засаг, нийгэм, байгаль орчны зорилтыг хангана</li> <li>• Салбарын хөгжил, үйл ажиллагааны тогтвортой байдлын асуудал</li> </ul>
<p>Ажиллах хүчин болон холбогдох нэгж</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрчний эвлэлүүд</li> <li>• Салбарын хувиараа хөдөлмөр эрхлэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ажиллах хүчний ашиг сонирхлыг төлөөлнө</li> <li>• Хүний нөөцийн төлөвлөлт, хөгжүүлэлт</li> <li>• Цалин, хөлсний хариуд тогтвортой үйлчилгээ үзүүлнэ</li> </ul>
<p>Олон улсын, үндэсний, орон нутгийн ТББ-ууд</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тогтвортой хөгжлийн ТББ-ууд</li> <li>• Байгаль орчин, соёлыг хамгаалах чиглэлийн ТББ-ууд</li> <li>• Нийгэм, олон нийтийн ТББ-ууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хоорондоо адилгүй оролцогч талуудын ашиг сонирхолыг төлөөлнө</li> <li>• Стратеги төлөвлөлт, боловсруулалтад оролцоно</li> <li>• Оролцогч талуудын уялдаа холбоотой байдлыг хангаж, дэмжлэгийг хэрэгжүүлнэ</li> <li>• Чадавхыг бэхжүүлж, боловсон хүчээр хангана</li> </ul>
<p>Боловсролын болон сургалтын байгууллага</p> <ul style="list-style-type: none"> <li>• Их сургууль, коллеж, сургалтын нэгжүүд</li> <li>• Судалгааны хүрээлэн</li> <li>• Техникийн мэргэжилтнүүд болон зөвлөлдөх нэгжүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсон хүчнийг цуглуулж, мэдээлэл түгээнэ</li> <li>• Бодлого болон стратеги хөгжүүлэлтийг дэмжинэ</li> <li>• Чадавхыг бэхжүүлж, боловсон хүчинг сургана</li> <li>• Тодорхой зөвлөгөө, ажиллах хүчнээр дэмжинэ</li> </ul>
<p>Орон нутаг, нутгийн иргэд</p> <ul style="list-style-type: none"> <li>• Иргэдийн зөвлөл болон бусад төлөөлөх нэгж</li> <li>• Уугуул иргэд, омгийн тэргүүн/нэгж зэрэг уламжлалт бүтэц</li> <li>• Эмэгтэйчүүд залуус зэрэг зохион байгуулалттай бүлэг</li> <li>• Орон нутгийн албан болон албан бус худалдаачид</li> <li>• Өрхүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутгийн түвшинд аялал жуулчлалын төлөвлөлт, шийдвэр гаргахад оролцоно</li> <li>• Орон нутгийн иргэдийн ашиг сонирхолыг төлөөлж, тэдэнтэй холбогдоно</li> <li>• Үр ашгийг иргэдэд тэгш хүртээж, хуваалцах ажлыг эрэлхийлнэ</li> <li>• Харилцан ашигтай байдлыг хангах үүднээс жуулчидтай холбогдож ажиллана</li> <li>• Жуулчдын зардлаас орлого олно</li> </ul>
<p>Хэрэглэгч/жуулчид</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хувиараа аялагчид</li> <li>• Хэрэглэгчдийн сүлжээ, клуб, байгууллагууд</li> <li>• Аялал жуулчлалын хэвлэл, олон нийтийн сүлжээний хэрэглэгчид</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын орлогын гол эх үүсвэрээр хангана</li> <li>• Аялалаа сонгохдоо болон аялахдаа байгаль орчин, орон нутагтаа хариуцлагатай хандах</li> <li>• Аялалын чиглэл, тогтвортой байдлын асуудлын талаар үнэн зөв, шударгаар мэдээлэл болон санал бодлоо солилцоно</li> </ul>



## Жишээ 4: БНЭУ-ын Кэрала

Энэтхэгийн Кэрала муж салбарын болдог, үйл ажиллагаандаа Хариуцлагатай аялал жуулчлалын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрсөн. Стратегийнх нь нэг чухал зүйл нь орон нутгийн иргэдтэй тогтмол холбоотой байх. Ингэхдээ тосгоны түвшинд жуулчдын аялалын сэтгэгдэлийг нь хүлээн авч, шинжилгээ хийсэн. Өөрөөр хэлбэл тосгонд айлчилсан, төрөл бүрийн соёлын өвийн үйл ажиллагаанд оролцсон жуулчдыг хамруулж, орон нутгийн фермерүүд болон аялал жуулчлалын бизнесийн нийлүүлэлтийн сүлжээг сайжруулсан байна. Крон нутгийн захиргааны бүтцийг үр ашигтай болгох нь энэхүү арга барилыг амжилттай хэрэгжүүлэх суурь хүчин зүйл болсон байна.

Орон нутгийн түвшинд оролцогч талуудын дөрвөн шатлалтай бүтэц шаардлагатай байсан нь ажиглагдсан. Үүнд:

- Грама Панчаят буюу тосгоны өөртөө засаглах захиргаа. БНЭУ-ын захиргааны доод нэгж.
- Кэралагийн аялал жуулчлалын газар
- Зочид буудал зэрэг орон нутгийн аялал жуулчлалын салбарын төлөөлөл.
- Бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч, гар урлалчид, хөтөч зэрэг орон нутгийн иргэдийн бүлгийн чиглүүлэгч, идэвхтэй бүлэг. Кэралагийн туршлагийг бусад мужуудад хэрэглэж байгаа бөгөөд БНЭУ-ын аялал жуулчлалын үндэсний бодлогод мөн тусгасан байдаг. (WTO: 61)

## Жишээ 5: Гол хүмүүсийг нэгтгэх нь, Гондурас

Байгалийн тогтоц болон түүхийн өв газрын үзмэр ихтэй байдлаа ашиглан Гондурас улс тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд хэд хэдэн санаачилга хэрэгжүүлсэн байдаг. Ингэж зорилгодоо хүрэхийн тулд үндэсний болон орон нутгийн түвшний хамтын ажиллагааг хангах үүднээс яам болон аялал жуулчлалын салбарын оролцогч талуудын бүтцийг зөв зохистой байдлаар хийх нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Аялал жуулчлалын хүрээлэн байгуулж, Ерөнхийлөгч, аялал жуулчлал, хүрээлэн буй орчин, байгалийн нөөц баялаг, санхүү, хууль эрх зүй, аюулгүй байдал, зам тээвэр, нийтийн хэрэглээний байгууламж, урлаг, соёлын асуудал хариуцсан нарийн бичгийн дарга нарыг гишүүдээр оролцуулсан. Аялал жуулчлалын алба байгууллага дотроо байгаль орчин болон хотын хөгжил хариуцсан нэгжийг тусад нь байгуулжээ.

Орон нутгийн түвшинд хотын аялал жуулчлалын хөгжлийн 60 орчим комиссыг байгуулж, тус бүрд нь орон нутгийн хувийн хэвшил болон ТББ-уудын оролцуулан, удирдлагад нь хотын захирагчийг томилсон. Аялал жуулчлалын хүрээлэн нь эдгээр комисст аялал жуулчлалын менежмент, байгаль орчны хууль эрх зүйн хэрэгжилт, зөвлөмж гаргах зэрэгт нь техникийн туслалцаа үзүүлдэг. Хотын захирагчид мөн бүс нутгаараа бүлэг болж, хоорондоо хамтран ажилладаг. Жишээ нь тогтвортой аялал жуулчлалын санаачилгыг умард эргийн бүс болон Копаны дэлхийн өв газарт хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг байна. (UNEP28: 51)

### Дэлгэрэнгүйг:

- UNWTO; Тогтвортой аялал жуулчлал For Development Guidebook Enhancing Capacities For Тогтвортой аялал жуулчлал For Development In Developing Countries, 2013: <https://www.e-unwto.org/doi/pdf/10.18111/9789284415496>
- OECD Tourism Trends and Policies, 2018: <https://www.oecd.org/cfe/tourism/2018-Tourism-Trends-Policies-Highlights-ENG.pdf>

## Жишээ 6: Филиппины хүнс ханган нийлүүлэгчдээр дамжуулан орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн нь

**Ерөнхий мэдээлэл:** Филиппиний Падаван дахь Эл Нидо тосгон болон Таятаяйн тогтвортой аялал жуулчлалын баазуудын нэгдсэн бүлгийг Эл Нидогийн жуулчны баазууд гэж ерөнхийд нь нэрлэдэг. Үүнд дөрвөн арлын жуулчны баазууд, эх газрын гурван зочид буудал хамрагддаг бөгөөд эдгээр нь аялал жуулчлалын төрөл бүрийн байгууламж, үйлчилгээг санал болгодог. Эдгээр амралт, жуулчны газрууд нь анхандаа ферм, загасчлалын бүс байсан газарт, тэр дундаа Эл Нидо тосгон (2015 оны байдлаар нийт 41,606 оршин суугчидтай) болон Таятаяд (2015 оны байдлаар 75,165

оршин суугчидтай) голцуу байрладаг.

Гэсэн хэдий ч аялал жуулчлалын салбар нь амьжиргааны гол эх үүсвэр болж чадсан бөгөөд жилд дунджаар 25% өсөн нэмэгдэж, энэхүү бүс нутгийн нийт жуулчдын тоо 2018 онд 200,000 хүрсэн. Эл Нидог Филипиний аялал жуулчлалын гол бүс болгосноор жуулчдын тоо огцом өсөж (2018 онд дунджаар 200,000 жуулчин бүртгэгдсэн бөгөөд нэг жуулчин дунджаар 2.7 хоног аялдаг), энэхүү бүсийн хүн амын хэмжээ (орон нутгийн хүн амыг оролцуулаад) нэмэгдсэн. Эл Нидогийн жуулчны баазууд хурдацтай нэмэгдэж буй хүнсний эрэлт хэрэгцээг хангах сорилтыг шийдвэрлэхийн сацуу хүнсний өртгийн сүлжээгээр орон нутгийн иргэдэд орлогын ихээхэн боломж, бололцоог бий болгож чадав.

**Стратеги:** Эл Нидогийн жуулчны баазууд хөдөлмөр эрхлэлтийг илүү үр ашигтай дэмжих зорилгоор орон нутгийн иргэдийг ажилд авснаар Эл Нидо, Таятаяийн иргэдэд өндөр цалинтай ажлын байр бий болгож, тухайн орон нутагтаа тогтвор суурьшилтай үлдэх боломжийг олгоод зогсохгүй худалдан авах ажиллагаагаараа бүс нутгийн хүнс үйлдвэрлэгчдээс бүтээгдэхүүн худалдан авах замаар орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжсэн. Дараах арга хэмжээ нь энэхүү ажилд дэмжлэг болсон

Эл Нидогийн жуулчны баазуудын орон нутгийн иргэдэд чиглэсэн стратеги: Ten Knots Development корпораци болон Эл Нидогийн фермийн аж ахуй эрхлэгчид 2017 онд санамж бичиг байгуулж, Эл Нидогийн жуулчны баазуудад 7 хоногт багадаа нэг тонн хүнсний ногоо нийлүүлэхээр тохиролцсон. Хэдийгээр энэхүү хэлэлцээр нь фермийн аж ахуй эрхлэх сэдлийг орон нутгийн компаниудад олгож байгаа ч сар бүр 19 тонн хүнсний ногоог Лузоны бусад мужаас татан авдаг. Эл Нидогийн жуулчны баазууд 2006 оноос эхлэн Эл Нидогийн 4 га органик фермийн талбайд урт хугацааны тогтвортой байдлын талаар орон нутгийн фермерүүдэд сургалт явуулж байна. Үүнээс гадна Эл Нидогийн аялал жуулчлалын баазууд Техникийн боловсрол, ур чадварын хөгжлийн газартай (ТБУЧХГ) хамтран 2018 оны 6-р сараас хойш фермийн аж ахуй, хүнсний ногоо үйлдвэрлэлийн талаар 22 хоногийн үнэгүй сургалтыг 25 фермерт зориулан явуулж байна. Эл Нидогийн аялал жуулчлалын баазууд мөн иргэдэд чиглэсэн сургалт явуулдаг. Тухайлбал цүнх, гэрийн шаахай зэрэг Эл Нидогийн жуулчны баазуудын байр, өрөөнд зориулан худалдан авдаг бүтээгдэхүүнийг урлах сургалтыг орон нутгийн барангая (тосгон)-уудын эмэгтэйчүүдэд зориулан явуулснаар одоо байгаа эрэлтийг хангадаг. Мөн Азийн байгаль хамгаалах сантай хамтран одоо байгаа нөөц бололцооны зураглал, хүн хүчийг тооцоолж, орон нутгийн иргэдэд бий болгох боломж, бололцоог тодорхойлсон.

**Нөлөөлөл:** Эл Нидогийн жуулчны баазуудад тогтвортой байдлыг хангасан хоолны цэс гаргах чиглэлд голцуу анхаарч, орон нутгаас улирлын чанартай хүнс, орон нутагт тарьж, ургуулсан хүнсний ногоог ашигладаг бөгөөд эдгээр нь баазуудын гал тогооны нийт худалдан авалтын 60 орчим хувьд хүрдэг; харин орон нутгаас худалдан авсан малын гаралтай бүтээгдэхүүн гал тогооны нийт худалдан авалтын 90%-тай тэнцэж байна. Орон нутгаас хүнс худалдан авснаар нийт хүнсний зардлыг 2016 онд гэхэд 20% бууруулж чадсан. Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг сонгосноор мөн тээвэрлэлтийн зардлыг бууруулаад зогсохгүй цаашлаад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулдаг байна. Эл Нидогийн аялал жуулчлалын баазуудын нийт ажиллах хүчний 90% нь орон нутгийн оршин суугчид байдаг. Хүнсээ орон нутгаас худалдан авснаар аялал жуулчлалын салбарт гар урлалын бүтээгдэхүүн, жижиг орон сууц, тээвэрлэлтийн үйлчилгээ зэрэг орон нутгийн ЖДҮ-үүдийг шинээр бий болгосон. Эдгээр шинэ бизнесүүд нь дотоодын аялал жуулчлалын салбарыг хөгжилд ч эерэгээр нөлөөлсөн.

**Сургамж:** Алслагдмал газар төрөл бүрийн бүтээгдэхүүнийг чанартай, их хэмжээгээр олж авахад тулгарах сорилтыг орон нутгийн үйлдвэрлэгчидтэй хамтрах шийдвэрлэх нь хамгийн үр ашигтай байна. Ингэснээр орон нутгийн үйлдвэрлэгчид жуулчны бааз, зочид буудлуудтай ханган нийлүүлэх гэрээ байгуулж, ашиг хүртэх боломжтой болно. Эл Нидо шиг тусгай хамгаалалттай газар, хөдөө аж ахуйн үйл ажиллагааг дэмжих нь ой мод сүйтгэх, загасчлалд хүндрэл учруулах зэрэг шууд бус сөрөг үр дагвар дагуулж мэднэ. Энэ төрлийн болзошгүй сөрөг үр дагаврыг бууруулахын тулд жуулчны бааз, зочид буудал зэрэг томоохон хэрэглэгчид фермер, загасчид зэрэг тусгай хамгаалалттай газрын хууль, журмыг мөрдөж, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах талуудтай түншлэх, хамтран ажиллах үүрэг хариуцлагыг хүлээдэг байна.

## 6.4. Мэдээлэл, сурталчилгаа



“Тогтвортой хэрэглээний боловсрол (ТХБ)-оор дамжуулан хэрэглээний зуршлыг бүрэн өөрчлөх боломжгүй ч боловсрол үйл явцад ихээхэн түлхэц болно. ТХБ-ийг албан боловсролын сургалтанд суулган ерөнхий боловсролын бүх сурагчид, албан бус боловсрол эзэмшиж буй хүмүүст хүртээмжтэй болгосноор нийгэмд өргөн цар хүрээтэй өөрчлөлт хийх үндэс суурийг тавих боломжтой”. (UNEP30: 16)

*Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл: ТХЗ 12-ийн хүрээнд Умард бүсэд хэрэгжсэн үйл ажиллагааны дүн шинжилгээ болон цаашдын замнал (2018)* тайланд мэдээлэл, сурталчилгааг сайжруулах асуудлыг ТХҮ-д шилжихэд нэн чухал төдийгүй 12.8 зорилтын хүрээнд дараах байдлаар тодорхойлсон: “Тогтвортой хөгжлийн замналд чиглэхийн тулд өөрсдийн бодол, зан үйлээ өөрчилж, ТХЗ-уудад тусгасан тогтвортой байдлын үйл ажиллагаанд гар бие оролцохоос гадна хувь хүмүүс ч мөн тогтвортой байдлын өөрчлөлтийг авчрах элч байх хэрэгтэй. Боловсрол эсвэл мэдээлэл, мэдлэг, чадвар, үнэт зүйлийг түгээх, хуримтлуулах, бүтээх, өөрчлөх зэрэг нь тогтвортой хөгжлийн төдийгүй ТХЗ-уудыг хэрэгжүүлэх, ахиц гаргахад нэн чухал хөшүүрэг болно.” (NMR: 30)

### 6.4.1. Боловсрол



”Боловсролгүйгээр эрх чөлөө, хариуцлага гэж байхгүй. Иргэд бид боловсролоор дамжуулан өдөр тутмын амьдралдаа сонголт хийхэд суралцдаг.” (UNEP30: 4)

Боловсролыг нь мэдээллийг түгээж, олон нийтэд сурталчилах түлхүүр хэрэгсэл гэж үзэх (SWITCH Asia: xvi, NMR: 30, UNEP30, UNEP31) ба НҮББОХ-ийн тодорхойлсноор “боловсрол бол биднийг хариуцлагатай шийдвэр гаргахын сацуу бидний хэрэгцээгээ ханган, хүссэнээ гүйцэлдүүлэхэд нөлөөлдөг хамгийн хүчирхэг хэрэгсэл юм. Боловсрол нь хэрэглээг эрх чөлөө, хариуцлагатай ч уялдуулна. Хувь хүн болон нийгмийн бүлгүүдэд хэрэглэгч гэдэг утгаар өдөр тутам сонголт хийхэд нөлөөлөх, түүнчлэн үр дүнтэй шийдэл, хувилбаруудын талаар зохих мэдээлэлтэй болоход Тогтвортой хэрэглээний боловсрол (ТХБ) нэн шаардлагатай.” (UNEP30: 4)

” Нутгийн уугуул иргэдийн мэдлэгийг хүндэтгэх, амьдралын өөр хэв маягийг хүлээн зөвшөөрөх талаар:



ТХБ нь олон янзын соёл, амьдралын хэв маягийг сонгоход хүндэтгэлтэй хандахад сургана. ТХБ нь бидний мэдлэгээс өөр байж болох мэдлэг, түүний арга хэлбэрийг сонсох, суралцах, анхаарахыг уриалдаг. Ингэснээр суралцаж буй хүмүүс эргэцүүлэн бодох, хоорондоо ижил төстэй байдал, ялгааг олж харах, бусад амьдралын хэв маягийн талаар үнэ цэнэтэй ойлголт олж авах боломжтой. ТХБ нь инноваци ба уламжлалт мэдлэгийн аль алинд суурилсан бодит шийдлийг гаргах залуур болно.” (UNEP30: 19)

Албан болон албан бус боловсролын аль алинд нь тэргүүлэх ач холбогдол өгөх, мөн зорилтот бүлгүүдийг, жишээ нь хүүхэд, залуучууд, эрдэмтэд, мэргэжилтнүүд, улс төрчид, нутгийн иргэд гэх мэтээр, ялгаатай харгалзах ёстой (SWITCH Asia: xvi, OECD5, UNEP30: 12) ба өдөр тутмын амьдралын бүхий л хүрээг хамруулсан байх шаардлагатай: “Боловсролын салбарын тэргүүлэх чиглэлүүд, ТХҮ-ийн олон улсын зорилтууд, орон нутгийн хөгжлийн чиглэлүүд нь хүний зан байдал, амьдралын хэв маягийг зохих хэмжээнд

өөрчилж, мэргэжил, боловсрол зэрэг амьдралын бусад зүйлсдээ ТХҮ-ийн дадлыг суулгаж, яваандаа ТХҮ-ийн амьдралын ур чадварыг (SWITCH Asia: xvi) суулгахад тогтвортой хэрэглээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн боловсрол (ТХБҮБ) нь гол үүргийг гүйцэтгэнэ.” (СВИЧ Ази: xvi)

### Жишээ 7: БОТБДИСТ-ийн 3 тулгуур

НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр (НҮББОХ) 2012 онд Дэлхийн Их, дээд сургуулиудын Байгаль орчин, Тогтвортой байдлын Түншлэлийг (товчоор ДИБТТ буюу GUPES) байгуулахад дэмжлэг үзүүлсэн. ДИБТТ нь байгаль орчин, тогтвортой байдлын асуудлыг боловсрол, судалгаа, олон нийтийн оролцоо, их, дээд сургуулиудын менежмент, сургуулийн дэд бүтэц болон үйл ажиллагааг ногоон болгоход суулгаж өгөх, түүнчлэн дэлхий даяар оюутнуудыг сургуулийн тогтвортой байдлыг дэмжих үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. ДИБТТ боловсрол-сургалт-сүлжээ гэсэн гурван тулгуурт суурилдаг (дор харна уу). Одоогоор ДИБТТ-ийн түншлэлд дэлхийн 800 орчим их сургууль нэгдээд байна.

(SWITCH Asia)

ЭНД, ОДОО! Тогтвортой хэрэглэгчийн боловсрол - Зөвлөмж ба зааварчилгаа тайланд (2010) тогтвортой хэрэглээний боловсролын (ТХБ) сорилтуудыг шийдвэрлэж, албан боловсролын салбарт шинэ боломжийг эрэлхийлэхийг зорьсон бодитой хэрэгслийг тодорхойлохыг зорьсон (UNEP30: 4). Тайланд мөн ТХБ-ын 10 зөвлөмжийн үндсэн чиглэлийг баримтлахыг засгийн газруудад уриалсан. Үүнд:

1. Боловсролын байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тусгах.
2. Тогтвортой хэрэглээний боловсролын сэдэв, агуулга, модуль, курс, академийн зэрэг олгох сургалтыг сургалтын хөтөлбөрүүдэд суулгах.
3. Тогтвортой хэрэглээний боловсролтой холбоотой судалгааг дэмжих.
4. Судлаачид, багш нар, сургагч багш нар, нийгэм, эдийн засгийн төлөөлөл болон оролцогч талуудын холбоог бэхжүүлэх.
5. Тогтвортой хэрэглээний боловсролын аргачлалыг цогцоор хөгжүүлэх үүднээс янз бүрийн салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг сайжруулах.
6. Тогтвортой хэрэглээний боловсролын хүрээнд дэлхийн хэмжээнд, ирээдүйд чиглэсэн, бүтээлч байдлыг дэлгэрүүлэхэд хувь нэмэр болох сургагч багш нарыг бэлдэх, сургахуйн үйл явцыг хялбар болгох
7. Тогтвортой хэрэглээний боловсролтой холбоотой бүтээлч, шүүмжлэлтэй, инновацилаг сэтгэлгээг урамшуулах.
8. Тогтвортой хэрэглээний боловсрол нь уугуул иргэдийн мэдлэгийн ач холбогдлыг үнэлдэг, амьдралын өөр хэв маягийг зөвшөөрдөг байхыг баталгаажуулах.
9. Залуу, ахмад үеийнхэн харилцан суралцах нь тогтвортой хэрэглээний боловсролын салшгүй нэг хэсэг гэж үзэн дэмжих.
10. Нийгмийн идэвхийг дээшлүүлэх болон олон нийтийн ажлын хүрээнд онолын судалгааны үр дүнг бодитоор хэрэгжүүлэх боломж олгох. (UNEP30: 12)

### Жишээ 8: КТН Хааны Технологийн Институт, Швед Улс

Шведийн КТН Хааны Технологийн Институт нь техник, эдийн засаг, нийгэм, экологи болон үйл явц хоорондын харилцан үйлчлэлийг ойлгуулахад чиглэсэн, аж үйлдвэрийн экологийн зарчимд суурилсан тогтвортой технологийн чиглэлээр магистрын зэрэг олгох сургалт явуулдаг. Үйлдвэрлэлийн экологи, системийн дүн шинжилгээ, шилжилтийн онолууд, цэвэр үйлдвэрлэл, экосистемийн үйлчилгээ, экологийн эдийн засаг, үйлдвэрлэлийн симбиоз /харилцан ашигтай зэрэгцээ оршихуй/, байгаль орчны менежмент, эргэлтийн эдийн засаг зэрэг олон салбарыг хамарсан сургалтын хөтөлбөртэй. Түүнчлэн амьдралын мөчлөгийн шинжилгээ, тогтвортой хүнс

үйлдвэрлэл ба хэрэглээ, хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжил зэрэг бусад нэмэлт хичээл ордог. Суралцагч нь технологийг илүү тогтвортой байдлаар практикт хэрэглэх боломжийг олгох мэдлэг, хэрэгслүүдэд суралцдаг. (SWITCH Asia: 4-15)

Мөн НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн тайланд бодлого боловсруулагчид, сургалтын хөтөлбөр боловсруулагч нарт зориулж ТХБ-ын төлөвлөгөө боловсруулахдаа хэрэглэж болохуйц нилээн хэдэн хувилбаруудыг санал болгож, сургуулийн тогтолцоонд ТХБ-г хэрхэн тусгахыг оруулсан (UNEP30: 16):

- a) ТХБ-г одоогийн хичээл/сургалтын хөтөлбөрийн хэсэг болгон тусгаж болно. Ингэхийн тулд багш нар өөрсдийн зааж буй хичээлүүд, ТХБ хоорондын хамаарал болон бусад хичээлүүдтэй холбогдох байдлыг тодруулж, тайлбарладаг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, ТХБ нь сургалтын хөтөлбөрт тавигдах бусад шаардлагуудын дунд хоцрогдож үлдэхээс сэргийлэхийн тулд сургуулиудын зүгээс ямар хичээлүүдэд тэдгээрийг хэзээ заахаас хамааран ТХБ-ын аль аль талууд тусгагдаж байгааг олж тогтоон, дүгнэж байх шаардлагатайг харуулж байна. Үүнийг хялбарчлах зорилгоор Нөөц бололцоотой холбогдох баримт #3 гэсэн хэсэгт матрицийг оруулжээ.
- b) ТХБ-ын сэдвүүдийг олон салбарыг хамарсан, нийтлэг шинж бүхий байдлаар, эсвэл төслүүд, үйл ажиллагаанууд болон сургуулийн клубууд, хичээлийн дараах арга хэмжээтэй уялдуулж зааж болно. ТХБ-ын мөн чанараас шалтгаалан сэдэвчилсэн байдлаар заах нь илүү түгээмэл байдаг. Энэ нь тухайн асуудлыг өөр өөр өнцгөөс харах боломжийг олгодог. Сэдэвчилсэн байдлаар заах нь мөн практик үйл ажиллагаа, төслүүдтэй сайн хоршиж, хийсвэр болон онолын мэдлэгийг илүү бодит болгож, сурагчид өдөр тутмын амьдралд холбох ойлгоход нь тустай (UNEP30: 16).
- c) Үүнээс гадна ТХБ-ыг сургалтын суурь хөтөлбөрт тодорхой хугацаа бүхий тусгай хичээл болгон зааж болно. Хугацаа нь тогтмол (долоо хоногт нэг удаа, хоёр долоо хоногт нэг удаа гэх мэт) эсвэл хичээлийн жилийн турш урт хугацаагаар хувааж заах гэх мэт байж болно. Энэ төрлийн хичээлүүд нь заавал ТХБ гэсэн нэртэй байх албагүй ч нэг ижил зорилготой байдаг ба агуулга нь ТХБ-ын тухай байна. Ийм хичээлүүд нь “дэлхийн иргэншил”, “ирээдүйн судлал”, “амьдрах чадвар”, “дэлхийг сахин хамгаалагч” гэх мэт ангилалд багтана (UNEP30: 16). НҮББОХ нь энэхүү тайланд дурдсан хувилбаруудыг бүхий л төрлийн нөхцөл байдалд бүгд зэрэг нийцнэ гэж үзэх шаардлагагүй бөгөөд хүсвэл тэдгээрийн аль нэгийг дангаар нь эсвэл бусад хувилбаруудтай нь хамт ашиглаж болно хэмээн тодотгосон байна (UNEP30: 16).

## **Жишээ 9: Вьетнам Улсын Нийтийн Удирдлагын Үндэсний Академийн ТХҮ-ийн сургалт**

ТХҮ-ийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагчид гол үүрэг гүйцэтгэдэг гэдгийг харгалзан Вьетнамын Нийтийн Удирдлагын Үндэсний Академи болон Азийн Технологийн Институт хамтран 2016 оны 11 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд төрийн ахлах албан тушаалтнуудад зориулж “Бодлого боловсруулагчдад зориулсан Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэлийн танилцуулга ба Эко-инновац” сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтыг НҮББОХ-ийн төслийн зохицуулагч Др. Вальтер Райгхардт болон Азийн Технологийн Институтийн Дэд Захирал Нгуен Ти Бич Хоа нар заасан. Сургалтад ТХҮ, эко-инновацийн суурь зарчмуудыг бодлого боловсруулагч нарт танилцуулах хичээл багтсан байв. Түүнчлэн сургалтын агуулгад Вьетнамын янз бүрийн үйлдвэрлэлийн салбаруудын эко-инновацийг дэмжихэд тулгарч буй асуудлууд, саад тотгоруудын талаар тайлбарласан. Үндсэндээ сургалтанд хамрагдагсад ялангуяа хэт хэрэглээ, байгаль орчны бохирдлын шалтгаан болсон үйлдвэрлэлийн өсөлт бүхий, шинэ засаг захиргааны бүс нутаг олширсон, түүнчлэн Вьетнамын аж үйлдвэржүүлэлт, шинэчлэлийн үе дэх ТХҮ-ийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай холбоотой сэдвүүд багтжээ.

*Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзэж болно: <http://www1.napa.vn/en/training-course-for-napa-lecturers-introduction-to-sustainable-consumption-and-production-and-eco-innovation-for-policy-makers>. (SWITCH Asia)*



## Жишээ 10: Байгаль орчны талаарх мэдлэг ойлголт цахимжиж байна

Байгаль орчны асуудлаар олон нийтийн мэдлэг, боловсролыг сайжруулах нь НҮББОХ-ийн Дэлхийн Байгаль Орчны Иргэншлийн Хөтөлбөрт тулгарч буй гол асуудал юм. Хэрэглэгчид International буюу Олон улсын хэрэглэгчид байгууллагатай хамтран ажиллаж, “Хэрэглээний цахим сургууль” төслийг хэрэгжүүлж байна. Уг хөдөлгөөний хүрээнд 1986 оноос хойш Мексик улсад байгаль орчны боловсролыг сайжруулах нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байгаа Colectivo Ecologista Jalisco буюу Жалиско экологичдын нэгдэл (ЖЭН) байгаль орчны төрийн бус байгууллага нь 2005 онд Хэрэглээний цахим сургууль (ХЦС) хөтөлбөрийг тус улсад мөн хэрэгжүүлсэн. Эдгээр цахим сургуулиудыг хүн бүр хэрэглэгч бөгөөд бидний дадал зуршил чухал юм гэдэг зарчим дээр суурилж боловсруулсан. Нийгэм нь хүмүүсийг өөрсдийн хэрэгцээнээсээ илүү ихийг хэрэглэхэд хөтөлдөг бөгөөд олон төрлийн хүчин зүйл үүнд нөлөөлдөг. Хүмүүс хэрэглээгээ хэрхэн хариуцлагатай болгох талаар өмнө нь заалгаагүй, сураагүй байдаг. ХЦС нь энэ зорилгод чиглэсэн интерактив сургалтыг санал болгодог. ХЦС нь дараах зургаан сэдвээр дамжуулан хэрэглэгчдийг чиглүүлдэг. Үүнд: i) хэрхэн хариуцлагатай хэрэглэгч болох вэ, ii) ахуйн хортой бодисууд, iii) хогны менежмент, iv) биологийн олон янз байдал ба хэрэглээ, v) хотын ногоон байгууламж, vi) хотын хөдөлгөөнт байдал орно. Жишээлбэл, ахуйн хортой бүтээгдэхүүнд цэвэрлэгээний болон хувийн ариун цэврийн бүтээгдэхүүнүүд, хоол хүнс, хорхой шавьж устгах бодис зэргээр дамжин хорт бодисууд хэрхэн хүний биед ордог талаар оруулжээ. Хүүхдэд тохиолдож болзошгүй эрсдлийн талаар боловсрол олгодог бөгөөд өдөр тутмын амьдралд тулгарах хортой бодисын хоруу чанарыг тайлбарлан, орлуулж болох аргуудын талаар заадаг. Цахим сургуулиудад хэрэглэгчдэд өөрийн мэдлэгийн түвшнийг өөрөө үнэлэх аргыг оруулжээ. Тус цахим сайтад багш нар, хамтын нийгэмлэгийн зохион байгуулагч нар, түншүүдэд зориулсан боловсрол олгох үр дүнтэй арга хэрэгсэл мөн бий. Сонирхсон хүмүүс семинар, эрдэм шинжилгээний сургалт, блог болон бусад хэлбэрээр боловсролын материалуудыг ашиглаж болно. (UNEP1: 145)

## Жишээ 11: СВИЧ Азийн Бүс нутгийн бодлогыг дэмжих бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгддэг Тери Их Сургуулийн ТХҮ-ийн сургалт

СВИЧ Ази нь Тери Их Сургуультай хамтран хөгжиж буй оронд заадаг Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн чиглэлээр магистрын зэрэг олгох сургалтыг боловсруулж, хэрэгжүүлсэн. Энэ нь ТХҮ-ийн чиглэлээр кампанит ажлуудыг дэмжиж ажиллах, зан байдлын өөрчлөлтийг бий болгох, энэ сэдвийг сургалтын хөтөлбөрүүдэд суулгах чадварлаг хүний нөөцийг бэлдэхэд чиглэсэн юм. (SWITCH Asia, 4-22).

Зорилтууд:

- Мэдээлэл сайтай ирээдүйн бодлого боловсруулагчдыг бэлдэхийн тулд ТХҮ-ийн зарчмууд, ач холбогдол, дэвшил зэргийн талаарх мэдлэгийг Энэтхэг болон Өмнөд Азийн бүс нутгийн өргөн хэмжээнд түгээх.
- Хэрэглэгч болон нийлүүлэгч талд ТХҮ-тэй холбоотойгоор сорилт, боломжуудын талаар залуу бодлого боловсруулагчдыг мэдлэгжүүлэх.
- ТХҮ-ийг бодлогод тусгах зорилгоор сонгогдсон салбаруудад бодлогод дүн шинжилгээ хийхэд залуу бодлого боловсруулагчдыг бэлдэх.

Сургалтын агуулга:

- ТХҮ-ийн танилцуулга
- Бүс нутгийн, Үндэсний, Орон нутгийн бодлогын хүрээ дэх ТХҮ
- Хэрэглэгч тал: Тогтвортой зан байдал ба Амьдралын хэв маяг
- Нийлүүлэгч тал: Нөөцийн үр ашигтай байдал ба Илүү цэвэр үйлдвэрлэлийн ТХҮ
- ТХҮ-ийг бодлогод тусгах I - Бодлого боловсруулалт ба хэрэгжүүлэлт
- ТХҮ-ийг бодлогод тусгах II – Хот суурин газрын салбарын стратеги
- ТХҮ-ийг бодлогод тусгах III - Эдийн засаг, санхүүгийн арга хэрэгслүүд

Үр дүн:

- ТХҮ-ийн талаарх илүү сайн ойлголттой болох, мөн тогтвортой хэрэглээ ба тогтвортой үйлдвэрлэлийн харилцаа холбоог сайжруулах
- Тодорхой улс орон, эдийн засгийн салбартай холбогдох тогтвортой хөгжил дэх ТХҮ-ийн үр



дүнтэй хэрэглээ болон бизнесийн загварыг хооронд нь харьцуулж, эсрэгцүүлэх чадвартай болох

- ТХҮ-ийн одоо мөрдөгдөж буй төлөвлөгөө, бодлогуудтай хоршиж буй байдлыг судлах боломжтой болох
- Тогтвортой Хөгжлийн засаглалд ТХҮ-ийг тусгах олон төрлийн бодлогын арга хэрэгслүүд, стратегийн хувилбарууд, зохион байгуулалтын аргуудын ач холбогдлыг сурсан байх

Сургалтын арга зохицуулалт: Танхимын лекц, санал бодлоо уралдуудах, илтгэл тавих хичээлүүд, уг сэдвээрх үндэсний, бүс нутгийн, дэлхийн жишээтэй танилцах сургалтын аялал. (SWITCH Asia, 4-22)

## Жишээ 12: ЮНИТАР-с зохион байгуулдаг ТХҮ-ийн цахим сургалт

НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэн (ЮНИТАР), НҮББОХ хамтран Ази, Номхон далайн бүс нутагт ТХҮ-ийн сургалтыг сайжруулах, түүний зарчим, хэрэгжилтийн талаарх иж бүрэн ойлголтыг бодлого боловсруулагчдад олгохоор ажиллаж байна. Энэ чиглэлд, тус хоёр байгууллага “Ази дахь ТХҮ-ийн танилцуулга” цахим сургалтыг боловсруулж, зохион байгуулахад тусалсан. СВИЧ Ази хөтөлбөрийн зүгээс сургалтыг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Зорилтууд: Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн зарчмыг тодорхойлж, тогтвортой хөгжлийн үнэ цэнийг тайлбарлах; Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг дэмжих үр дүнтэй бодлогын төлөвлөлтийн гол элементүүдийг ялгаж таних; үндэсний засаглалд тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн бодлогыг тусгаж, хэрэгжүүлэх боломжийг олгохуйц нөхцлүүдийг тодорхойлох; үндэсний хэмжээнд тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг урагшлуулахад чиглэсэн гол сорилтууд, боломжуудыг хэлэлцэх, үндэсний засаглалд тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг тусгахад дэмжлэг үзүүлэх дэлхий нийтийн болон бүс нутгийн санаачилгуудын хүрээг дүгнэх, бодит байдал дээрх бодлого боловсруулах үйл явцад тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийн зарчмыг тусгаж мөрдөх

Сургалтын агуулга:

- Модуль 1: ТХҮ-ийн танилцуулга: Тодорхойлолт, шалтгаан, суурь
- Модуль 2: ТХҮ-ийн бодлогуудыг загварчилж, хэрэгжүүлэх: Үндэсний засаглалын бүтцүүд дэх бодлогын мөчлөг ба ТХҮ
- Модуль 3: Нийлүүлэгч талын өөрчлөлтийн голлох хэсгүүдэд бодлогуудыг хэрэгжүүлэх ба тогтвортой үйлдвэрлэл
- Модуль 4: Хэрэглэгч талын өөрчлөлтийн голлох хэсгүүдэд бодлогуудыг хэрэгжүүлэх ба тогтвортой үйлдвэрлэл
- Модуль 5: 2015 оноос хойшхи ТХЗ-уудын хүрээнд ТХҮ-г амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын ажиллагаа, бүс нутгийн санаачилга ба тэргүүлэх чиглэлүүд

Үр дүн: Сургалтад багтсан жишээ дасгал нь оролцогчдод практикт ТХҮ-ийн зарчмуудыг хэрэгжүүлж үзэх боломжийг олгодог. Оролцогчид нь аливаа асуудлын нөхцөл байдал, түүнд холбогдох асуудлуудыг олж тогтоон, шаардлагатай арга хэмжээнүүдийг тодорхойлж, тодорхой нөхцөлд таарсан ТХҮ-ийн ажлын төлөвлөгөөг боловсруулдаг. Сургалтаар ажилласан сургалтын жишээ бүрийг сургалтад оролцогчид өөрсдөө бие биенээ болон сургалтын зохицуулагч үнэлж дүгнэдэг.

Сургалтын арга зохицуулалт: Цахим лекц, заавар, интерактив/хэлэлцүүлэг болон илтгэлийн хичээлүүд, уг сэдвээр үндэсний, бүс нутгийн, дэлхийн жишээтэй танилцах сургалтын аялал.

Зорилтот чиглэлийн хүмүүс: Улсын яамд болон мужийн, орон нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчид, хувийн салбарын байгаль орчны чиглэлээр ажилладаг менежерүүд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөгчид, шинжлэх ухааны байгууллагуудын төлөөлөгчид, судлаачид, бодлогын үйл явцад оролцогч бусад хувь хүмүүс.

Дэлгэрэнгүйг: <https://www.unitar.org/event/full-catalog/introduction-sustainable-consumption-and-production-asia> (Switch Asia: 4-23)

#### 6.4.2. Хамтын ажиллагаа

ТХБ-г боловсролын хөтөлбөрүүдэд суулгахдаа ямар ч байсан: “ТХУ-ийн талаарх боловсролын шийдвэрт хамаарах бүх талуудын ашиг сонирхол, асуудлуудыг зохих ёсоор, тэгш анхаарах” нь чухал гэсэн нийтлэг ойлголттой болох хэрэгтэй (SWITCH Asia: 2-4).

НҮББОХ нь оролцогч талуудыг хамруулах нь чухал болохыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд ТХБ-д хамаарах талууд үр дүнд хүрэхэд тодорхой дэмжлэг болж, ингэснээр түншлэлээр ТХБ-ыг хөгжүүлэх нэг арга зам болно үздэг: “Тогтвортой хэрэглээнд чиглэсэн боловсролын чанарыг сайжруулахад боловсрол олгогч нартай хамтран ажиллах боломжтой өргөн хүрээний түншүүд (засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл гэх мэт) бий. Тогтвортой хэрэглээний чиглэлээр ажилладаг хувь хүмүүс, байгууллагууд харин мэргэжлийн холбоо, нэгдэл байгуулбал багш, сурагчид тэднээс сүүлийн үеийн мэдлэг, туршлагаас суралцах боломж бас бий. Энэ нь ТХБ-ыг хичээлийн танхимын сургалтаас амьдралд хэрэгжүүлэхэд нь нэмэртэй юм. Хамтын ажиллагааг танхимын эсвэл цахимаар зохион байгуулж болно. Ийм төрлийн түншлэл нь нутгийн иргэдийн дундаас гарах санаачилгыг өдөөж өгдөг.”

Үүнээс гадна, ТХБ-ын талаарх чадавхийг бэхжүүлэх болон ТХУ-ийн талаарх мэдлэг, туршлага, мэдээллийн солилцоог сайжруулахыг дэмжих зорилгоор бүс нутгийн байгууллагууд, Азийн улс орнуудын хооронд болон дэлхий дахинаа үндэстэн дамнасан солилцоо, дэмжлэг, сүлжээ болон хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай байгааг олонтаа онцолдог.

#### Жишээ 13: Бутан улсын Бага боловсролын төв

Бутан улсын Бага боловсролын төв (ББТ) нь 6 дугаар анги хүртэл хичээллэдэг бага сургууль юм. Төв байгуулагдсанаасаа хойш сурагчдын бусдыг ойлгох чадвар, энэрэх сэтгэл, хамт олон болон эх орныхоо өмнө хүлээх хариуцлага зэрэг үнэт зүйлийг нь хөгжүүлэхэд анхаарлаа хандуулсаар иржээ. Энэ концепц нь Бутан улсын Үндэсний нийт аз жаргалын индекс (ҮНАЖИ)-тэй уялдана. ББТ нь Өөрчлөлтийн Төлөөх Загвар (ӨТЗ)-тай хамтран “мэдрэх, төсөөлөх, гүйцэтгэх, хуваалцах” гэсэн дөрвөн алхамт томъёоллыг ашиглан хүүхдүүдэд нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх чадавхи олгох, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий нилээн хэдэн төсөл хэрэгжүүлсэн. Эдгээрийн нэг нь савлагаат хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг багасгах тэдний санаачилга байсан юм. Уг төсөл нь хаягдал болон түүний байгаль орчин, хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулах нөлөөллийн талаарх ажилд дэмжлэг үзүүлэх зорилготой байсан юм. ББТ нь савлагаат хүнсний бүтээгдэхүүнийг долоо хоногт нэг удаа хэрэглэж (Лхагва гариг бүр), хүнсний хаягдлыг зориулалтын бордоо бэлтгэх хэсэгт тушаахыг уриалсан аяныг хэрэгжүүлсэн. Бутан дахь хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтын Ногоон зам компани цаасны хаягдлыг боловсруулдаг бол, хуванцар хаягдлыг нь дахин ашиглаж, боловсруулдаг байна. Уг санааг Тимпугийн Захирлуудын бага хурлын үеэр болон үндэсний телевизээр сурталчилж, бусад сургуулийн сурагчдыг мөн нэгдэхийг уриалжээ. Бутаны 80 гаруй сургууль энэ аяныг дэмжиж буйгаа илэрхийлсэн байна.

*Хөтөлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах хаягаар танилцаж болно: Бага боловсролын төв (ББТ): <http://elchighschool.co/>*

*Өөрчлөлтийн Төлөөх Загвар Бутан: <http://dfcworld.com/dfc/BHUTAN/> (Эх сурвалж: СВИЧ Ази)*

### 6.4.3. Кампанит ажил



“Амжилттай хэрэгжиж буй санаачлагууд хүмүүсийг үнэт зүйл, өөрийгөө таньж мэдрэх, хэрэгцээ болон хүсэл эрмэлзлийг нь хөндөхөд чиглэгддэг бөгөөд ингэснээр урам зоригтойгоор, утга учиртайгаар, бодитоор өөрчлөлт хийх боломжийг нээж өгдөг.” (UNEP31: 94)

Ойлголтыг өдөөх, мэдээлэл солилцох нь боловсролын хүрээнээс хальсан асуудал байдаг. Хүмүүс өдөржин янз бүрийн агуулгатай мэдээлэл хүлээн авч, орчин тэдний хандлагад нөлөөлдөг. “Тогтвортой амьдралын хэв маягийг зүгээр хий хоосон зүйлээс болж сонгохгүй. Хэрэглээг өөгшүүлсэн бодлого, үйл ажиллагаа хэвшсэн зүйл бөгөөд өөрчлөлт хийхэд энэ нь эдийн засгийн, соёлын, дэд бүтцийн болон бусад олон саадыг бий болгодог. Хүмүүс өдөр бүр хэрэглэгчийг татах мартетингийн сурталчилгаагаар бөмбөгдүүлж байдаг учир шинэ маягийн тогтвортой амьдралын хэв маягийг сурталчлах хүчин чармайлт үндсэндээ хангалтгүй бөгөөд үүнд зарцуулах нөөц ч дутагдалтай байна. (UNEP31: 8). Иймээс хэрэглэгчид болон бизнесийг салбарынхныг ТХҮ-д хөтлөх, хүмүүсийг тогтвортой сонголт хийхэд чиглүүлэх сурталчилгааг маркетингийн тусламжтайгаар хийх зайлшгүй шаардлагатай болоод байна.

Хэрхэн ТХҮ-г дэмжсэн кампанит ажил, санаачилгуудыг боловсруулах үндэслэлийг гаргах зорилгоор НҮББОХ “Тогтвортой амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, сурталчлах – Зарчмууд ба сүүлийн үеийн туршлагаууд” (2016) хэмээх тайланд олон улсын туршлага, холбогдох бүтээлүүдэд дүн шинжилгээ хийжээ. Дүн шинжилгээнээс харвал кампанит ажлыг амжилттай явуулахад хүмүүсийн амьдралын утга, өөрийгөө таних, аюулгүй байх, бусдаас хамааралгүй байх, сэтгэл хангалуун байх зэрэг хэрэгцээг нь таньж, ашиглах явдал ажээ. Хэдийгээр агуулгын хувьд өөр ч кампанит ажлууд сонирхлыг өдөөх, идэвхижүүлэх, шинэ дадалд сургах зэрэг нийтлэг шинжийг шингээсэн байдаг байна (UNEP31: 11). Тайланд тогтвортой амьдралын хэв маягийг сурталчилсан кампанит ажил эсвэл санаачилга боловсруулахад гол санаа, нийцүүлэлт, үнэлгээ хийх зааварчилгаа болох дараах стратегийн зураглалын 8 зарчим бүхий 4 алхамыг санал болгожээ (UNEP31: 8).

#### Жишээ 14: Кампанит ажлын гол санааг хүргэх арга, талуудын оролцоо

Вьетнамын хөдөө нутагт “Гурвыг хасч, гурвыг нэмэх” кампанит ажлыг - шавж устгагч, химийн бордоо болон арилжааны үр - гурван хэрэглээг багасгах, - эдийн засгийн үр ашиг, эрүүл мэнд, хөрсний чанар - гурван ашгийг авчрах зорилгоор 11 мужийн 950 сайн дурын тариаланчдыг оролцуулан шууд мэдээллийг хүргэх замаар хэрэгжүүлсэн. (UNEP31: 13)



“Иймэрхүү кампанит ажлын хүрээнд тогтвортой амьдралын хэв маягийн утга учрыг тодорхой болгох, үүнд хүрэх нь өнөөгийн дэлхийн ихэнх хүмүүсийн хувьд заавал хуучнаасаа салах биш харин хүсэл эрмэлзлэлээ шинэчлэн өөрчлөх явдал гэдгийг ойлгуулах, нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөх зорилгоор бодлого боловсруулагчдад арга хэрэгслийг зааж өгөх ёстой.” (UNEP31: 96)

## НЭГДҮГЭЭР АЛХАМ: Зорилтот бүлгээ ойлгох

**Оролцогч талуудад төвлөрсөн:** Оролцоог дэмжсэн, хөрсөндөө буусан, энгийн аргууд хэрэглэх

- Хүмүүсийн хүсэл, хэрэгцээнд тулгуурлах, итгэлийг нь хүлээх, тухайн нутгийн онцлог болон орон нутагт нийцсэн үйл ажиллагааг дэмжих.

## ХОЕРДУГААР АЛХАМ: Зорилгоо тодорхойлох

**Гэгээлэг амьдралын төлөө:** Зорьж буй зүйлдээ төвлөрөх

- Оролцогч талуудын үнэт зүйлст нийцсэн алсын харааг тодорхойлох
- Асуудлыг тодорхой хэмжээнд дурдах ч гэсэн уриалгад голчлон төвлөрөх. Нөлөөлөл: зорилгоо тодорхойлж, тогтвортой байдлын үр дүнгийн жишээнүүдийг харуулах; экологи, нийгэм, эдийн засгийн хувьд хүрч болохуйц зорилгуудыг тавьж, явцын дунд хэрэгжилтийг хэмжих алхамуудыг тодруулж өгөх.

## ГУРАВДУГААР АЛХАМ: Стратегиа тодорхойлох

**Системтэй:** Амьдралын хэв маягийн хандлагыг анхаарах

- Амьдралын тогтвортой хэв маягийг бүрдүүлдэг суурь хүчин зүйл, системтэй бүтцийг тодотгон харуулах.
- Салбар бүрт үйл ажиллагааг сурталчлах кампанит ажлыг боловсруулах.
- Амьдралын идэвхтэй өөрчлөлт: Амьдралын тодорхой үе шат, шилжилтийн давуу талыг ашиглах
- Гэр бүл зохиох, эцэг эх болох, нүүх, тэтгэвэрт гарах, ажлаа солих гэх мэт амьдралын шилжилтийн үеийг шинэ хэв маяг, шинэ дадал олж авах завшаан болгон ашиглах.

**Олон янз байдал:** Амьдралын хэв маягийн олон талт байдалд нийцүүлэх

- Тогтвортой амьдралын олон хэлбэрийг харуулах. Оролцогч талуудыг бүлгээр ангилж, бүлэг бүрт тохирсон, тухайн ард түмний соёлд тохирсон туршлага, стратегийг нэвтрүүлэх.

**Хамтын үйл ажиллагаа:** Амьдралын хэв маяг хувь хүний хандлагаас давуу гэдгийг харуулах

- Нийгмийн тодорхой бүлэг хүмүүсийг оролцуулж, мэргэжил нэгтнүүдээр нь дэмжүүлэх стратегийг хэрэгжүүлэх.
- Хувь хүний үйлдлийг бодлогын өөрчлөлт гэх мэт томоохон тогтолцооны өөрчлөлттэй холбох.

**Жишээ 15: Бэрхшээл, сорил учруулахгүй, тэмүүлэлд төвлөрсөн кампанит ажил төлөвлөх. Сорилын цар хүрээ болон алсын харааны зоримог чанарын ялгааг харуулах.**

Эдийн засаг өсөхийн сацуу Хятадын хэрэглэгч давхаргын хувь эрс нэмэгдэж үүний хирээр байгаль орчин, нийгэмд үзүүлэх дарамт улам нэмэгдэж байгаа учир “Хятад мөрөөдөл” хэмээх сайн сайхан амьдралын “аз жаргал-эв нэгдэл” гэсэн алсын хараатай кампанит ажлыг шинээр эхлүүлэв. “Хятад мөрөөдөл” нь хохирогчдын тухай биш, харин тогтвортой амьдралын хэв маягийн талаар эрэгцүүлэхэд өдөөн түлхэх, хятадын соёл, уламжлал шингэсэн, гэрэлтэй ирээдүйд хөтлөх бөгөөд тогтвортой тэмүүлэлд нийцэж байгаа юм. Энэхүү алсын хараа нь барууны соёлоос үүдэлтэй “хэрэглэгч иргэн”-ий оронд тогтвортой Хятад улсын төлөө хувь хүнийг сайн сайханд хөтөлсөн “өөрийн” хувилбар болно. (UNEP31)

## ДӨРӨВДҮГЭЭР АЛХАМ: Хэмж, хариул

**Эргэх холбоо:** Өөрчлөлтөд суралцах, дасан зохицох

- Кампанит ажлын туршид оролцогчдыг сонсох замаар суралцах соёлыг бий болгох, дараагийн арга хэмжээнд идэвхижүүлэх болон цаг хугацааны туршид гарсан санаачилгуудыг хэрэгжүүлэх арга зам гэдэг утгаар эргэх холбоотой байх (UNEP31: 8)

НҮББОХ “Бизнесийн холбоод, маркетерууд, сурталчилгаанынхан, болон холбогдох талуудтай ажиллах замаар хэрэглээ төвтэй мессэжүүдийн эсрэг, тэмүүлэлд төвлөрсөн, өөрчлөлтийг дэмжсэн хэтийн зорилго тавих нь илүү дорвитой үр дүнд хүрэх нэг боломж юм” гэж тайлбарлажээ. (UNEP31: 11).



**Мьянмарын орон нутгийн ТХҮ-ийн элч**

гэдэг нь Бирмийн хөдөөгийн тогтвортой хөдөө аж ахуйн санаачилга бөгөөд кампанит ажлын үндсэн санааг хүргэхдээ орон нутгийн хөрсөн дээр буулгаж, танил “нүүр царай”-аар дамжуулах зорилгоор төгсөгчдийг орон нутагаа төлөөлөх нөлөө бүхий элч болгон татах юм. Тухайлбал, төгсөгчид хөрсний менежмент, хөрсний төрөл, таримлын онцлогт тохируулан тариалалтын арга технологийг нутгийн хүмүүст зааж сургана. (UNEP31: 14)

**Дэлгэрэнгүй мэдээллийг:**

- ЭНД, ОДОО! Тогтвортой хэрэглэгчийн боловсрол - Зөвлөмж ба зааварчилгаа, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр, 2010 он:  
<http://www.unep.fr/shared/publications/pdf/DTIx1252xPA-Here%20and%20Now%20EN.pdf>
- Тогтвортой амьдралын хэв маягийг дэлгэрүүлэх, ойлгуулах – Зарчмууд ба шинэ туршлагауд (тайлан бүрэн эхээрээ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөр, 2016 он:  
[https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/20170209\\_un\\_communicating\\_sust\\_lifestyles\\_fullreport\\_lores\\_2016.pdf](https://www.oneplanetnetwork.org/sites/default/files/20170209_un_communicating_sust_lifestyles_fullreport_lores_2016.pdf)

**Жишээ 16: Хятадын эрчим хүчний хэмнэлттэй орон сууц – Үйл ажиллагааны зарчим**

**Талууд:** Барилгын компаниуд, төр

**Байгууллага:** СВИЧ Ази (засгийн газрууд оролцсон олон талт түншлэл)

**Хөндөж буй асуудал:** Ойлголцол, оролцоо, бүтээмж

**Сурталчилгааны арга:** Семинар, сүлжээнд нэгтгэх, арга хэмжээ, бодлого боловсруулалт, мэдээллийн уулзалт, онлайн видео, цахим хуудас

### Нөлөөлөл

Эрчим хүчний зарцуулалт багатай орон сууцны кампанит ажил нь Ази болон дэлхийн холбогдох талуудад зориулсан чанд хяналтын системийн үр дүнд чиглэсэн. Энэхүү кампанит ажлын үр дүнд хэрэгжсэн барилгын төслүүд Хятадын хүлэмжийн хий ялгаруулах худалдааны системээс нүүрсхүчлийн хийн ялгарлын зөвшөөрөл авахгүй байх боломжийг олгох замаар нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулж, ихээхэн хэмнэлт гарсан. Үр дүнд Сичуаны зах зээлд тогтвортой барилгын эзлэх хувь 2010 онд 4.2% байсан бол 2014 онд 16.6%, Шэнжэньд 2010 онд 22.3% байсан бол 2014 онд 39.5% хувь болж өсчээ. Кампанит ажилд 700 гаруй жижиг дунд үйлдвэр холбогдон, 42 сурталчилгааны арга хэмжээнд хамрагдсан. Уг санаачилгын хүрээнд бизнесийн салбарын болон засгийн газрын сонирхогч талуудад Хятадын онцлогт тохирсон тогтвортой барилгын давуу талыг сурталчлах болон бодлого боловсруулах, үл хөдлөх хөрөнгийн төлөвлөлт, барилгын чиглэлээр төр, хувийн хэвшлийнхнийг зохицуулалттай арга хэмжээ хэмжээ авдаг болохыг дэмжих зорилгоор өргөн хүрээнд арга хэмжээнүүд, уулзалт-семинарыг зохион байгуулсан. Эрчим хүчний зарцуулалт

багатай орон сууцны кампанит ажлын хүрээнд техникийн сургалт, төслийн зөвлөх үйлчилгээг санал болгохдоо олон улсын ноу-хауг ашигласан. Хятад улсын тогтвортой хөгжлийн загварт шилжих үндэсний томоохон шилжилтийн энэ үед оролцох гэсэн Хятадын барилгын компаниудын хүсэл, эрмэлзлэлийг харгалзаж хэрэгжүүлсэн тул барилга байгууламжийн ажлын арга барилд өөрчлөлт, дэвшил гаргах зорилгодоо хүрсэн юм.

Эрчим хүчний зарцуулалт багатай орон сууцны кампанит ажилд орон нутгийн удирдлага, хэвлэл мэдээллийн байгууллага, хэрэглэгчдийн холбоо, орон нутгийн төлөөлөл гээд 36 оролцогч талуудыг татан оролцуулсан.

Тэд бодлогын харилцан ярианд санал бодлоо илэрхийлж, техникийн сургалт, шилдэг туршлагаа хуваалцах, сүлжээг бий болгох зэргээр ашиг тусаа өгчээ. Эдгээр оролцогч талууд бодлогын хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулахын зэрэгцээ техникийн сургалтад хамрагдаж, тэргүүн туршлагатай танилцан, сүлжээнд нэгдэх зэргээр үр шим хүртсэн. Гурван жил хэрэгжсэн кампанит ажилд оролцон, тогтвортой арга барил болон байгаль орчинд ээлтэй барилгын үйлдвэрлэлийг нэвтрүүлсэн компаниуд нийт 7.45 сая м<sup>2</sup> талбай бүхий эрчим хүчний хэмнэлттэй барилга барьж, ингэснээр 420,000 тонн СО<sub>2</sub> хэмнэж болон эрчим хүчний хэрэглээг 67 петажоулиар багасгав. Мөн 2010 оныхтой харьцуулахад нарны зайгаар ажиллах халаагуур, газрын гүний дулааны хэрэглээ 16.5%-иар өсөв.

### **Мэдээлэл-сурталчилгаанаас хуримтлуулсан туршлага**

#### Зорилтот бүлгүүдтэй тогтоосон холбоо: Төр-хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх

Бодлогын өөрчлөлтийг зүгшрүүлэхэд хэрэгтэй төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох, зорилтот бүлгүүдэд тогтвортой зан үйлийн өөрчлөлтийг бий болгоход шаардлагатай урамшууллын хөшүүргийг бий болгох. Энэ удаагийнх шиг түншүүд суралцах боломжийг ашиглах (эрчим хүчний зарцуулалт багатай орон сууцны давуу талууд зэрэг), бодлогод нөлөөлөх зорилгоор нэгдэх, мэргэжил нэгтгүүдээсээ харилцан суралцаж болно. Жишээлбэл, төр, хувийн хэвшлийн тоглогчдын санхүүгийн хөрөнгө оруулалт болон олон улсын, төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн хамтын ажиллагааг бий болгож чадсанаар Эрчим хүчний зарцуулалт багатай орон сууцны хөтөлбөр амжилттай хэрэгжсэн.

#### Стратеги: Үйл ажиллагааны хэрэгцээг тодорхойлох

Хүлээн авагч тал маань ямар асуудлын талаар мэдлэг чадвар дулимаг байгааг олж хараад, тэдний хүчин чармайлтыг нэмэгдүүлэх стратеги зохиогоорой. Энэ стратеги нь маш тодорхой техникийн хэрэгцээ шаардлагаас эхлээд талуудын уялдаа холбоог хангах ерөнхий хэрэгцээ гэх мэт өргөн хүрээг хамарч болно. Тухайлбал, энэхүү кампанит ажилд оролцсон барилгын компаниуд тогтвортой, нүүрсхүчлийн хийн бага ялгаралтай барилгыг барих мэдлэг, чадавхаа дээшлүүлэхийн тулд оролцож байсан.

Зорилтот бүлгүүдэд ямар зохицуулалт эсвэл мэдлэгийн хэрэгцээ байгааг тогтоож, тэднийг дэмжихэд чиглэсэн стратеги боловсруулах.

Хамрах хүрээ нь тодорхой мэрэгжлийн хэрэгцээ, түүнчлэн талууд хоорондын зохицуулалтын хэрэгцээ ч байж болно. Тухайлбал, барилгын компаниуд тогтвортой, бага нүүрстөрөгч ялгаруулдаг барилгын талаар мэдлэгтэй болох чадавхид суралцах зорилгоор энэхүү кампанит ажилд оролцсон.



## АШИГЛАСАН БҮТЭЭЛ

---

- [1] GGGI (2016). Mongolian Green Credit Fund Concept Note.
- [2] GIZ, UNDP (2019): Aligning Mongolia's NDC and SDGs through its Хороон хөгжлийн бодлого. Available in: <https://www.transparency-partnership.net/gpd/aligning-mongolias-ndc-and-sdgs-through-its-national-green-development-policy>
- [3] Le Blanc, D. (2015): Towards integration at last? The sustainable development goals as a network of targets. DESA Working Paper No. 141. ST/ESA/2015/DWP/141.
- [4] PAGE/UN, MoF (2015): Review of the public procurement legal framework of Mongolia.
- [5] The SWITCH-Asia Network Facility (2013): Sustainable Consumption and Production Policies – A Policy Toolbox for practical use.
- [6] UN and DTU (2017): Eco-i Manual Eco-innovation implementation process.
- [7] UNEP (2015): Sustainable Consumption and Production. A Handbook for Policymakers, available in:  
<https://sustainabledevelopment.un.org/index.php?page=view&type=400&nr=1951&menu=35>
- [8] UNEP (2017): Comparative Analysis of Хороон худалдан авалт and Ecolabeling Programmes in China, Japan, Thailand and the Republic of Korea: Lessons Learned and Common Success Factors
- [9] WEF (2019): Insight report. The Travel & Tourism Competitiveness Report 2019, Travel and Tourism at a Tipping Point, Geneva.
- [10] World Travel and Tourism Council (2018): Travel and Tourism Economic Impact 2017: Mongolia. London.
- [11] БОАЖЯ, ҮХГ, ҮСХ, АНДЭЗНК, Монгол улсын Тогтвортой хөгжлийн төлөв, тайлан, Мөнхийн үсэг ХХК, 2018 он.
- [12] МУ-ын Засгийн газар, Монгол улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019 – Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, Улаанбаатар, 2019 он.

# ХАВСРАЛТ

## ХАВСРАЛТ 1: Уулзаж ярилцсан оролцогч талуудын төлөөлөл

Нэр	Албан тушаал	Байгууллага
Ц.Уранчимэг	дарга	БОАЖЯ, Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс
Цэдэвсүрэн	мэргэжилтэн	БОАЖЯ, Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс
Ц.Батзул	дарга	СЯ, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс
Я.Эрдэнэсайхан	дарга	ХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого, зохицуулалтын газар
Эрдэнэсайхан	мэргэжилтэн	ХААХҮЯ, ЖДҮҮХБЗГ
Б.Золзаяа	зохицуулагч	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл (SECIМ), БХ2
Чойжилсүрэн	Ахлах мэргэжилтэн	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл (SECIМ), Хангамжийн сүлжээ
Энхбаяр	Ахлах мэргэжилтэн	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл (SECIМ), Хангамжийн сүлжээ
У.Сарангоо	Manager	СВИЧ Ази, Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг төсөл
Б.Дөлгөөн	мэргэжилтэн	СВИЧ Ази, Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг төсөл, AVSF Mongolia байгууллага
Цогцолмаа	менежер	Чех Каритас
Б.Марото-Изкүйрдо	Суурин төлөөлөгч	СВИЧ Ази, Дулаан шийдэл төсөл, GERES байгууллага
Ууганбаяр	Үйлдвэрийн захирал	Ханбогд Кашмерийн үйлдвэр
Цэрэнсамбуу	Захирал	ТӨБЗГ, Төрийн худалдан авалт, гадаад хамтын ажиллагааны газар
Mrs. Khaliun	мэргэжилтэн	ТӨБЗГ, Төрийн худалдан авалт, гадаад хамтын ажиллагааны газар
П-И. Лукас	дарга	ЕХ-ны төлөөлөгчийн газар, Хамтын ажиллагааны хэлтэс
М.Бямбарагчаа	Төслийн менежер	ЕХ-ны төлөөлөгчийн газар
Энхтүвшин	мэргэжилтэн	БХБЯ, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
Ромэйн Бриллие	Суурин төлөөлөгч	Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Байгууллага (GGGI)

## ХАВСРАЛТ 2: Оролцогч талуудыг төлөөлөл

д/д	Нэр	Албан тушаал	Байгууллага	Email	Утас
<b>Яам</b>					
1	Т.Булган	дарга	БОАЖЯ, Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар	bulgantumen@yahoo.com	310357
2	Ц.Уранчимэг	дарга	БОАЖЯ, Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс, СВИЧ Ази хөтөлбөрийн ТХҮ-ийн үндэсний зохицуулагч	uranchimeg@mne.gov.mn	311278
3	С.Баясгалан	дарга	БОАЖЯ, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар	bayasgalan.saranjav@gmail.com	311173
4	Ц.Батзул	дарга	СЯ, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс	Batzul_ts@mof.gov.mn	51-267646
5	Б.Батхүү	дарга	ХААХҮЯ, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар	batkhuu@mofa.gov.mn	51-263422
6	Я.Эрдэнэсайхан	дарга	ХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого, зохицуулалтын газар	erdenesaikhan.ya@mofa.gov.mn	51-264995
7	Д.Гантулга	дарга	БХБЯ, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилт зохицуулах газар		99172040
8	Мишээл	мэрэгжилтэн	БХБЯ, Ногоон хөгжлийн газар		
9	Д. Оунчимег	захирал	ЭМЯ, Эм, үйлдвэрлэл, технологийн газар	oyunchimeg_d@moh.gov.mn	
10	Б.Алимаа	дарга	ХНХЯ, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	alimaa@mlsp.gov.mn	263634
<b>Агентлаг, төрийн байгууллага</b>					
1	Ц.Ням-Осор	дарга	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (ТӨБЗГ)		
2	Н.Улам-Өрнөх	дарга	ТӨБЗГ, Төрийн худалдан авалтын газар	ulamurmukh@pcsp.gov.mn	263031
3	Б.Лхагва	дарга	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ)	contact@ТӨБЗГ.gov.mn	
4	Д.Эрдэнэбаяр	дарга	ҮХГ, Салбарын хөгжлийн бодлого зохицуулалтын газар	erdenebayar.d@YXG.gov.mn	261573
5	Л.Төгсбаяр	дарга	МХЕГ, Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, тусгай хяналтын газар		261073
6	Ж.Батбаясгалан	1-р орлогч	Хотын захирагчийн хотын Хөгжлийн бодлого хариуцсан	batbayasgalan.j@ulaanbaatar.mn	327125

7	И.Баттөгс	дарга	Нийслэлийн МХГ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, тусгай хяналтын хэлтэс		99115921
8	Л.Өлзийбаяр	дарга	ОБЕГ, Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар		262182
9	Г.Өнөржаргал	дарга	СХЗГ, Стандарчилал, тохирлын үнэлгээний бодлогын газар	unurjargal@СХЗГ.gov.mn	261578
10			Аймаг, бусад хотын удирдлагын төлөөлөл		

#### Аж ахуйн нэгж

1			Барилгын компаниуд		
2			Нэхмэл, сүлжмэлийн компаниуд		
3			Арьс, ширний компаниуд		
4			Аялал зуулчлалын компаниуд		
5			Хог хаягдал дахин боловсруулах компаниуд		
6			Бусад		

#### Боловсрол, судалгааны байгууллагууд

1	Б.Батцагаан	захирал	ШУТИС, Барилга архитектурын сургууль, Барилгын дэвшилтэт материал, бүтээцийн судалгааны төв		
2	Б.Мөнхбаяр	захирал	ШУТИС, Барилга архитектурын сургууль, Барилгын эрчим хүчний хэмнэлтийн сургалт, судалгааны төв		
3	Л.Жаргалсайхан		ШУА, Хими, химийн технологийн хүрээлэн		70002542
4	Д.Батбаяр		ШУТИС, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн	info@khureelen.edu.mn	70003143

#### Иргэний нийгмийн төлөөлөл

1	Т. Дүүрэн	дарга	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ)		
2	Оюунгэрэл		Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо (МТСХ)	info@МБХ.mn	99884080
3	Баясгалан		Монголын ноос, ноолуурын холбоо	http://www.mongoltextile.mn/	342950
4	Д.Содбуян	Гүйцэтгэх захирал	Монголын Хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо, (МХХДБҮХ)		77116345
5	Б.Мэндбаяр	Захирал	Монголын Байгаль Орчны Консорциум (МБОК)	mnec8@yahoo.com	
6			Гэр хорооллын зураглал төв		98225523
7	Л.Хулан	Гүйцэтгэх	Монголын үндэсний барилгын	info@mnca.mn	70111515

		захирал	ассоциаци		99998028
8	Б.Буянхишиг	Захирал	Байгаль орчин, тогтвортой хөгжил судлалын төв (БОТХСТ)	esdsc2011@gmail.com	99037436
<b>СВИЧ Ази: Төслүүд</b>					
1	У.Сарангоо	Төслийн менежер	"Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг" /STePEcoLab/ төсөл	u.sarangoo@avsf.org	70110043; 99112541
2	Үүрийнцолмон		Чех Каритас, Барилгын материал дахин боловсруулалт		70135899
3	К. Велискова		Чех Каритас, Барилгын материал дахин боловсруулах төсөл	jana.zilkova@caritas.cz	90930350
4	Б.Марото-Изкүйрдо	Country director	СВИЧ Ази, Дулаан шийдэл төсөл, GERES байгууллага	b.maroto-izquierdo@geres.eu	75052000
5	Г.Тайоти		СВИЧ Ази, Монголын нэхмэлийн салбарын тогтвортой үйлдвэрлэл, эко тэмдэг төсөл /STeP Ecolab/		99112541
<b>Түншүүд, бусад төсөл, хөтөлбөр</b>					
1			Монголын худалдааг дэмжих төсөл (EU-TRAM)		
2	Б.Золзаяа	зохицуулагч	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл (SECiM), БХ2	Zolzaya.Baljinnyam@fao.org	70150075, 99174131
3	Г.Мөнхболор	зохицуулагч	Монгол Улсад ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл БХ1	m.gungaa@ynido.org	99818438
4			Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Байгууллага (GGGI)		
5			Хэвлэл мэдээллийн төлөөлөл		

### ХАВСРАЛТ 3: БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

#### Бодлогын суурь баримт бичгүүд:

Бодлогын баримт бичгүүд	Хэрэгжих хугацаа
1 Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ-ын 2010 оны 48 дугаар тоот тогтоолоор)	2010-2030
2 Ногоон хөгжлийн бодлого (УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор)	2014-2030
3 Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (УИХ-ын 2016 оны 19 дугаар тогтоолоор) <sup>60</sup>	2016-2030
4 Алсын хараа-2050 (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор)	2020-2050
5 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (УИХ-ын 2020 оны 24 дугаар тогтоолоор)	2020-2024

#### Байгаль орчны салбарын бодлогын баримт бичиг:

Бодлогын баримт бичгүүд	Хэрэгжих хугацаа
1 Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	2015-2025
2 Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр	1999-2030
3 Чанарын болон байгаль орчны удирдлага (менежмент)-ыг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2016
4 Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр	2005-2015
5 Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр	2005-2035
6 Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр	2010-2020
7 Ус үндэсний хөтөлбөр	2010-2025
8 Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	2011-2021
9 “Хатан Туул” хөтөлбөр	2012-2020
10 Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах үндэсний хөтөлбөр	2012-2021
11 Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	2014-2022
12 Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр	2014-2040
13 Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги	2009-2013
14 Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016-2025
15 Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2017-2025

#### Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичиг:

Бодлогын баримт бичгүүд	Хэрэгжих хугацаа
1 Мах, сүүний анхдугаар аян	2016-2020
2 Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого	2015-2030
3 Үйлдвэржилт 21: 100 хөтөлбөр	2018-2021
4 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр	2019-2022
5 “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр	2009-2016
6 “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр	2019-2023
7 Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	2014-2025
8 Монголын экспорт хөтөлбөр	2018-2022
9 Атрын гурав дахь аян	2016-2020
10 Үндэсний чанарын хөтөлбөр	2016-2020
11 Ноолуур хөтөлбөр	2018-2021
12 “150 мянган айл-орон сууц” үндэсний хөтөлбөр	2019-2023
13 “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр	2017-2021

<sup>60</sup> Энэ тогтоолыг Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хүчингүй болгон, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдав.



[www.switch-asia.eu](http://www.switch-asia.eu)

**switchasia**  
● SCP FACILITY

